



ЭРДЭМ

СОЁЛЫН ЖИМЭЭР  
THE CULTURAL WAY

ШИНЖИЛГЭЭ

ᠰᠣᠶᠣᠳᠣᠰᠣᠶᠣᠳ



ᠰᠣᠶᠣᠳᠣᠰᠣᠶᠣᠳ

Эрхэлсэн: Э.Итгэл

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР  
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ **VIII** (№ 4)

**Редакцын зөвлөл:**

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	/ Монгол улс /
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	/ Монгол улс /
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	/ Герман улс /
Доктор (Ph.D)	Цолмон	/ БНХАУ /
Доктор (Ph.D)	Ургаацэцэг	/ БНХАУ /
Доктор (Ph.D)	Н.Мягмар	/ Монгол улс /
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	/ БНХАУ /
Доктор (Ph.D)	Б.Болд	/ Япон улс /
Доктор (Ph.D)	Залгаабаяр	/ БНХАУ /

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

*Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр улирал тутам хэвлэгдэх сэтгүүл*

Улаанбаатар 2023

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР  
THE CULTURAL WAY

**ISSN: 2791-1446**

**VOLUME VIII**

**Editorial board:**

Doctor (Sc.D)	Badamdorj	( MGL )
Doctor (Ph.D)	Chuluunbaatar	( MGL )
Doctor (Ph.D)	Qurčabaatar	( GER )
Doctor (Ph.D)	Tsolmon	( PRC )
Doctor (Ph.D)	Urgaatsetseg	( PRC )
Doctor (Ph.D)	Myagmar	( MGL )
Doctor (Ph.D)	Qasbaatar	( PRC )
Doctor (Ph.D)	Bold	( JAP )
Doctor (Ph.D)	Zalgaabayar	( PRC )

**Edited by: Itgel. E**

THE CULTURAL WAY  
CENTER FOR CULTURAL STUDIES  
Printed with permission of editorial board  
a quarterly journal of research

Ulaanbaatar 2023

*ISSN: 2791-1446*

© *Sodon Soyod Publishing, Mongolia*



# СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

## ГАРЧИГ

### ТҮҮХ, СОЁЛ СУДЛАЛ

1. Үзэсгэлэн, Ургаацэцэг <i>Чин улсын үеийн Бортохой дахь үндэстний их нэгдлийг товч өгүүлэх нь.....</i>	1
2. Жао Хашэнь Гаова <i>Коллежийн монгол оюутнуудад зориулсан ерөнхий япон хэл заах аргын талаар зарим асуудал.....</i>	7
3. Сарнай <i>Бэлгэдэл тэмдгийн урлагийн зохион бүтээл дэх хэрэглэлт.....</i>	12
4. Л.Чулуунбаатар <i>Ариг Урианхай аялгууны тухай.....</i>	17
5. Наргил, Л.Хасбаатар <i>Шинэ зуучлуурын орчин дахь Ренчиний Чойномын зохиол бүтээлийн дундад улс дахь дамжуулгын хэлбэрийн хувиралт.....</i>	21
6. Мишээл <i>17 дугаар зууны сурвалж бичиг дэх он сарыг илтгэх арга.....</i>	32
7. А.Ариунболд <i>Монгол гэрийн хөгжлийн тойм ба гэртэй холбогдох зарим заншил.....</i>	41
8. Ө.Хасмөчир <i>Хуурын үүсэл гарлын тухай мөшигх нь.....</i>	49
9. Кан Хай Ин <i>Харьцуулсан утга зохиолын тал дахь Н.Өлзийбатын найрууллын ертөнц.....</i>	55
<b>ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ</b>	
10. А.Мөнхцэцэг <i>Монгол улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа.....</i>	67
11. Л.Батчулуун <i>Төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах ажлын хэрэгжилт өнөөгийн байдал.....</i>	74
12. Ц.Түвшинбаяр <i>Гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанд хүүхдийн эрхийг хамгаалах шүүхийн практикийн өнөөгийн байдал.....</i>	81
13. Ц.Өнөболд <i>Багш хөгжихөд хамтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, багш бүр өрийгөө хөгжүүлэх арга зам.....</i>	90





# СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

## CONTENT

1. Uzesgelen, Urgaatsetseg  
*A brief description of the great unity of the nation in Bortokhoi during the Qing Dynasty*
2. Zhao Hashen Gaowa  
*Some issues about general Japanese teaching methods for Mongolian college students*
3. Sha ri na  
*Application of symbols in artistic creation*
4. Chuluunbaatar. L  
*About Arig Uriankhai dialect*
5. Nargil, Qasbaatar. L  
*The transformation of the form of transmission in the China of Renchin Choynom's writings in the new mediated environment*
6. Misheel  
*Method of indicating dates in 17th century documents*
7. Ariunbold. A  
*An overview of Mongolian ger development and some customs related to home*
8. Qasmuchir. U  
*Tracing the origin of the fiddle*
9. Kan Hai Ying  
*The world of N. Ulziibat's composition in the field of comparative literature*
10. Munkhtsetseg. A  
*A comparative study of the legal regulation of child adoption in Mongolia*
11. Batchuluun. L  
*The current state of implementation of the work of conducting public services in Cyrillic and national scripts*
12. Tuvshinbayar. Ts  
*The current state of judicial practice for the protection of children's rights in disputes arising from family relations*
13. Unubold. Ts  
*Ways to increase the effectiveness of collaborative activities in teacher development and to develop each teacher's debt*



# СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

## ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭГЧИЙН ҮГ

*Энэ удаагийн дугаарт Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургууль, Өвөр Монголын Багийн Их Сургууль, Монголын Үндэсний Их Сургууль, Бортохойн Дээд Сургууль, Чифөн Их Сургууль, Өвөр Монголын Урлагийн Дээд Сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Дотоод Хэргийн Их Сургууль зэрэг их, дээд сургуулиудын эрдэмтэн багш, судлаачдын өгүүллүүд багтлаа. Уйгуржин монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэх, хятад хэлнээс монгол хэлэнд орчуулах орчуулгын баг, зүтгэл нэгт хамт олондоо талархал илэрхийлье. Энэ удаагийн дугаарын нэг онцлог нь нийт илтгэлүүдийг хоёр үндсэн бүлэгт хуваах оролдлого хийв. Хойшдоо ч хэд хэдэн үндсэн бүлэгт багтаан хэвлэхээр төлөвлөж байна. Эрдэм шинжилгээний сэтгүүлтэй холбогдох аливаа үйл хэргийг чин сэтгээлээсээ дэмжин тусалдаг хэн бүхэнд баярлалаа.*

*Номын цагаан буян дөрвөн зүг найман зовхист өнө мөнхөд дэлгэрч байх болтгуай*

2023 оны 12 сар

ЧИН УЛСЫН ҮЕИЙН БОРТОХОЙ ДАХЬ ҮНДЭСТНИЙ ИХ НЭГДЛИЙГ ТОВЧ  
ӨГҮҮЛЭХ НЬ

(Шажинтохой орноор жишээлэх нь)

Үзэсгэлэн\*

Боржгин Ургаацэцэг\*\*

## ХУРААНГУЙ

Хятал нүүдэл иргэд бол монголчуудын нийгмийн хөгжлийн дунд анхаарууштай нэгэн асуудал болно. Манж чингийн үеэс эхлэн дотор орны нүүдэл иргэд/нүүж ирсэн хятад иргэд/ монгол оронд хэсэг бусгаар нэвчин ороод, нэгэнт гурван зуу гаруй жилийн түүхтэй болжээ. Хятад иргэдийн удаа дараалан монгол оронд нүүдэллэн ирж, тариалан үйлдвэрлэл, худалдаа наймаа, мал аж ахуй эрхлэхээр дамжин, онцгой нийгмийн бүтцийг бүрэлдүүлж, улс төр, аж ахуй, үндэстний бүрэлдэл тэрчлэн нийгмийн амьдрал, соёл, амь ахуй зэрэг бүх талаар үндсэн чанартай хувьсалыг бий болгов. Үүнд Өвөр монголын баруун хэсэг дэх Хатан голыг хөвөөлөн дагасан Шажинтохой орон нь усны эх баялаг гүйцэд, хөрс шороо өнгө шимлэг байдгаас чин улсын сүүлчээс эхлэн, ойр зэргэлдээ Ганьсу, Ниньшянь зэрэг хятад газрын ядуу зүдүү иргэд хил даван Алшаа буюу Бортохойг дамжиж Шажинтохой оронд нүүдэллэн ирсэн байна. Тэнгэрийн тэтгэсэн ба Сайшаалтай ерөөлтийн үе хүрэхэд нэн олон хятад иргэд нэвчин орж ирэн, тариалан үйлдвэрлэл эрхэлж эхэлсэн билээ. Хүн ам ч алгуур аажмаар нэмэгдэж, ихэнх нь тариалан үйлдвэрлэл эрхэлж, хятад монгол холилдон суурьшсан нийгэм буюу цул тариачилсан нийгэм бүрэлджээ.

Түлхүүр үгс: *Манж чин, нүүдэл иргэд*

Манж чин улсын үес Алшаа Хошууд хошуу нь зүүн өмнө зүгт Ниньшянь фу-тай Хө лань шань уулаар зааглан харилцан бэрлэж, баруун өмнө зүгт Ганьсу жич Лян жөү фу, Гань жөү фу-тай хөршилснөөс аль эртнээс Ганьсу, Ниньшянь зэрэг хилийн гаднах газар орны хятад иргэд хил даван Алшаа оронд хэсэг бусгаар нэвчин орж ирсэн билээ. Өнгө шимлэг Хатан голын сав газрын ойролцоох газар орон нь Тэнгэрийн тэтгэсэн, Сайшаалтай ерөөлтийн үеэс эхлэн хятад иргэдийн нүүдэллэн

\* Бортохой Их Сургуулийн Марксын үзлийн дээд сургуулийн багш, доктор

\*\* Бортохой Их Сургуулийн Марксын үзлийн дээд сургуулийн багш, доктор



## THE CULTURAL WAY

ирэх гол орон болсон байна. Их хэмжээний хятад нүүдэлчдийн нүүдэллэн орж ирэхийг дагалдан, Алшаа монголчуудын нийгмийн уг төрөх болсон уламжлалт малжих амьдралд яваандаа тариалах соёлын элементийг агуулан, алгуур аажмаар хагас тариалах хагас малжих орон, тэрчлэн тариалахаар голлосон тосгод зүг хөгжсөн билээ. Онцгойлон Хатан голын хөвөө дагуу байрласан Шажинтохой орон нь гүйцэд хангамжтай усалгааны нөхцөл, өнгө шимлэг хөрс шороо зэрэг тариалан үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжтой нөхцлийг бүрэлдүүлснээс 19-р зуунаас эхлэн Шаньсы, Ганьсу, Ниньшянь зэрэг газар орны нүүдэлчин иргэдийн чухал нэгэн нүүдлийн орон болсон юм.

Аль эрт Энх-Амгалангийн үед гүнжийг дагаж ирсэн даруй Алшаа Хошууд хошууны вангийн ордон байгаа Дин юань ин хотын ойролцоо Хатан гол дагуу тариа тарьж байжээ. Найралт төвийн үе болоход нэг бүлэг хааны гүнжийг дагагсад, гадуур дотуур орны хятад иргэд Хатан голын эрэг дагуу газар оронд тариа тарьж, жил болгон тогтсон түрээс татвар тушаадаг байлаа. Тэнгэрийн тэтгэсэний үеэс эхлэн Ганьсу орны хятад иргэд их хэмжээгээр Алшаа оронд нэвчин ирж, Шажинтохой багт вангийн ордны ногооны цэцэрлэг гэгч бага хэмжээний ногоо тарьдаг газар гаргав. Сайшаалтай ерөөлтийн үеэс эхлэн Шаньсы, Ганьсу, Ниньшянь, Хөбэй зэрэг оронд жил дараалан ган хавсрага болж хур тундас цөөрөн, тариа төмс хураалтгүй болсноос ядуу өлсгөлөн иргэд гамшгаас зайлан хил давж, бусад муж хошуу шянь-аар цагаачлан тэнүүчилж, Шажинтохой, Хар хоньт, Долоосухай, Дөнкөү зэрэг Хатан гол дагасан багуудаар бөөн бөөнөөр ирж атар хагалбарлан тариалангийн газар гаргав. Чин улсын дунд, сүүлчээс эхлэн Хатан голоос ойрхон Шажинтохой, Хар хоньт, Булаг нуур зэрэг газар оронд тариа таригсдын өдөр ирэхүй олохыг дагалдан дээр дурдсан багуудын хагалбарласан тариалан нийт 119000 му-д хүрсэн байв. Бүрэнт засагчийн (1862) оноос хойш Хотончуудын бослого гарснаас болж энд тариалан эрхэлж байсан тариачин иргэд нутагтаа зугтаан явсан болохоор тарьж болох тариан газар нь зөвхөн 4000 му хэр үлджээ. Тухайн үеийн бүртгэлийг үндэслэвэл Шажинтохой багт нийт 11000 му тариа хагалбарласан байв. Үүгээр дамжин Шажинтохой оронд хятад монгол холилдон суурьших үзэгдэл бий болж, аажмаар Алшаа орны чухал тариалангийн суурин газар болж хөгжсөн билээ.

Сайшаалтай ерөөлтийн үед “Алшаагийн Өөлдийн засаг хойш чин вангийн харьяанд байсан Улаан мөрөн гол, Танькөү жич Шажинтохой зэрэг газар оронд арваад тариачин өрх түрээслэн авчирч, газар хагалбарлан тариа тарьсан, жил бүрийн хураасан амуугаа бүхнийг Жянь овогтод худалдан өгдөг” учраас Дөнкөү, Шажинтохой зэрэг газар орноор үргэлжлэн тариа тарих болсон билээ. Сайшаалтай ерөөлтийн хорьдугаар



## THE CULTURAL WAY

(1815) онд Алшаа хошой чин вангаас Дөнкөү, Шажинтохой зэрэг газар оронд тариа тарьсан иргэний хэрэг явдлыг дээшээ Шаньсы, Ганьсуйн ерөнхий захирагчид мэдүүлж, сүүлээр нь Яргайн хэрэг шийтгэгч яам (Яргайд сууж монгол хятад иргэдийн харилцан холбогдох хэрэг явдлыг шийтгэх яамны товчлол)-ны их түшмэл зарлигийг даган жил бүр тусгайлан биеэрээ Дөнкөү, Шажинтохой зэрэг оронд ирж, тариа тарьж байгаа иргэдийн хэрэг явдлыг байцаан шийдвэрлэх болжээ .

Хятад тариачдын монгол хошуунд орж ирэхийг дагалдан хүн амын тоо нь тасралтгүй нэмэгдэж, монгол хүн ба хятад иргэдийн хоорондох зөрчил хурцдаж, зөрчлийн шалтгаан нь ээдрээтэй мөртөө шийдвэрлэх арга байдал нь адил бус, шийдвэрлэх явцдаа үг хэл нэвтрэхгүй, монгол ноёд монгол хүнээ өмгөөлөх зэрэг олон зүйлийн шалтгаанаас болж Чин улсын засгийн газраас Алшаа Хошууд хошуу нь хятад монголын хоорондох хэрэг явдлыг шийдвэрлэхэд Яргайд сууж монгол хятад иргэдийн харилцан холбогдох хэрэг явдлыг шүүх яамнаас шийдвэрлэх хэрэгтэй гэж тогтоосон байна . Иймээс дээрх материалаас олж мэдэх нь Сайшаалтай ерөөлтийн үед, Дөнкөү, Шажинтохой зэрэг газар оронд хятад тариачдын хэрэг заргыг монгол хятад иргэдийн харилцан холбогдох хэрэг явдлыг шүүх яамнаас жил болгон тогтсон түшмэл томилж, тусгайлан байцаан шийдвэрлэдэг байжээ. Төр гэрэлтийн гуравдугаар (1823) онд “Тус хошуудаас Дөнкөү шянь-ий зах амсарын Юй му вэнь, Шажинтохой, Хар хоньт, Хатан голын ирмэг, Булаг тохой зэрэг газарт гүнжийг дагасан болон ядуу иргэд амьдрахын төлөв хагалбарласан гийн боловсруулсан газар нь 739 чи 34 му, Шажинтохой, Хар хоньт, үүнээс хятад иргэдээс боловсруулсан газрын хажууд сэмээр газар хагалбарлаж тарихыг дагалдан, удаандаа шинээр хагалбарласан газар нь 451 чи 33 му хүрэн” .

Иймээс Шажинтохой оронд тариалж байх хүмүүс зөвхөн гадна орны хөлсний тариачнаар барахгүй бас гүнжийг дагасан байж, жил явах тутам хүний тоо нь нэмэгдэхийг дагалдан, тариачдаас боловсруулсан тарианы хажууд шавар овоохой босгож, далдаар тариа хагалбарлах үзэгдэл тэнд орших болсон.

Төр гэрэлтийн арван зургадугаар (1836) онд “Алшаагийн өөлдийн хошой чин вангийн хошууны хэргийг шийтгэгч туслагч дэд зэрэг тайж хоёр зэрэг тэмдэглэсэн Дарли, туслагч дөтгөөр зэрэг тайж хоёр зэрэг тэмдэглэсэн Лхажав нарын хүсэн баглах бичиг гаргаж мэдүүлэхийн учир, байцааваас манай хошууны уг тарьсан Хар хоньт, Шажинтохойн зэрэг хаяа хөвөө барин бүхий хоосон сул газрыг гуйн хагалваас 420 чин 25 муу газар бүхий тул үүнд жил удаан угт монголчууд нутаглан суусангүй бас ч бэлчээртэй харшлах явдалгүй тул эдүгээ бүгдээр нийлж байцааваас цөм үнэн, угт бэлчээрт харшлахгүй учир хүсэн баглах бичиг үүнд өргөв”



## THE CULTURAL WAY

гэжээ. Дээрх материалаас үзэж гарах нь монгол тайж нараас Шажинтохой орон дахь малжаагүй нутаг бэлчээрийг дээшээ мэдүүлж, гадна орноос хятад тариачдыг хөлслөн тариулж, өөрсдөө харин тарьдаггүй байжээ.

Алшаа хошуудаас тухайн үеийн Шажинтохой, Хар хоньт, Долоонсухай гурван багт тэнүүл эрчүүдэд тариа тавих, түрээс хураах, торгох яллах зэргийн засаг ноёноос даалгасан ажлыг хариуцан гүйцэтгэдэг ерөнхийлөн захирах даамал тавьдаг байжээ. Бадаргуулт төрийн арван хоёрдугаар (1886) онд тариа тавих гурван багийн ерөнхийлөн захирах даамлыг Амаржаргал гэгч хүн үүрэглэж, хошуу засаг ноёны зарлигаар 100 му бүрээс гурван суулга амуу тариа хурааж, жилд 1200 шахам суулга амуу хурааж байлаа. Бадаргуулт төрийн хорин долоон (1901) он болоход нэмэгдэн 100 му бүрээс зургаан суулга амуу хураах болов, хожим Хэвт ёстын гуравдугаар (1911) он болоход зөвхөн амуу татварлаж байснаа бас мөнгө, хэвийн цай нэмэн татварлах болж, 100 му-аас дөрвөн суулга амуу татварлахаас гадна 13 лан мөнгө, дөрвөн хэсэг хэвийн цайг эрхбиш тус жилийн 8 сарын 15-наас урьд харьяа багийн даамалдаа тоо ёсоор тушаах хэрэгтэй. Үүнээс мэдэгдэх нь, Алшаа Хошууд хошуудаас тухайн үеийн хятад тариачдаас татварлах амуу тариан түрээс нь жил явах тутам нэмэгдэж, 100 му бүрээс гурван суулга амуу татварлаж байснаа нэмэгдээд зургаан суулга болж, цаашлан мөнгө ба хэвийн цай татварлах болсон байна.

Хэвт ёстын тэргүүн (1909) он, Шажинтохой багийн тариачдаас түрээс мөнгөө нэхэж авахын төлөө, заланы занги Сун хуань (манж үг-ерөнхий хамаарагч) Манхалайн захианд: “Шажинтохой зэрэг дөрвөн багийн тариачны ноднин жилийн түрээс зохих түрэлгэний мөнгөнд ирсэн захирагч Амаржаргалын удаа дараа хураан тушаасан гурван мянга хэр, уг газар хэмжээлсэн чин му-аар бодвоос үлдэх тогтсон түрэлгийн мөнгө долоон мянга илүү лан боловч, харьяат тариачин урьд хишиг гуйсан учир байх тул тухайд хэр зэргээс гадна хишиг хүртүүлж, урьд жил тогтсон түрэлгийн мөнгө долоон мянга илүү ланг тушаахыг хэлтрүүлээд, эдүгээ заланы занги Сун хуань Манхалайд тушааж хиа бичээч Уртнасан лугаа хамт хавсран томилж гучин гуравдугаар онд хэмжээлсэн чин му-ийн тоогоор чин бүр түрээс зохих чухам түрэлгийн мөнгө арван нэг зургаа, цай дөрвөн хэсэгтэйг дутагдалгүй тооны ёсоор хураалган ирүүлэхээс гадна, хэрэв тариачдын дотор мөнхүү хуучин мөрийг дагаж зүйлчилж зүслэн хуурмаглаж түрэлгийн дутагдуулах нь буй аваас ноднин жилийн дутагдуулсан мөнгө ба жич энэ жилийн түрэлгэтэйг хамтаар хураан аваад газрын хураан авч зөрсөн иргэдийг уг нутагт нь хөөн явуултугай, хэрэв нутагтаа харихгүй олтгойлон ойвоос тамгын газар дарангуйлан хүрч



## THE CULTURAL WAY

ирвээс өөрсдөө шийтгэх арга буйгаас гадна, данснаа байцааваас урьд хүлээн авсан зарлигт сургуулийн танхим байгуулж цагдах сэргийлэн тогтоон байгуулсугай” гэжээ. Дээрх дансыг ажиглавал, нэгд ерөнхий хамаарагчийн хамаарах хүрээ хэмжээ нь Шажинтохой зэрэг дөрвөн багаар гол болгож, түрээс мөнгө хураадаг, хоёрт тухайн үед нэг чин газрын татварлах мөнгө нь арван нэгэн лан зургаан зоос дөрвөн хэсэг цай байх хэрэгтэй, гуравт хэрэв тариачдын дундаас түрээс мөнгөө тушаахгүй буюу худал хэлж зайлж зугтаах үзэгдэл байвал уг нутагт нь хүргэнэ, дөрөвт хэрэв уг нутагтаа харихгүй бол бусад шийтгэх арга авна, даруй сургууль байгуулж цаг дагуу сэргийлэн сахиж хамаарна.

Дээрх хэдэн хувь данс эвхмэлээс үзэж гарах нь чин улсын сүүлч үеэс эхлэн нэг бүлэг хятад тариачдын хил даван Шажинтохой оронд орж ирэхийг дагалдан, Шажинтохой орон нь аажмаар Алшаа хошууд хошууны чухал амуу будааны суурин газрын нэг болсон байна. Мөн энэ үеэс эхлэн Шажинтохой орны монголчуудын улс төр, аж ахуй, соёлын талаарх байр суурь нь хувирч, хятад монгол холилдон суурьших буюу хятад үндэстнээр төвлөрөн суурьшсан нийгэм бүрэлдэж эхэлжээ.

### ДҮГНЭЛТ

Манж Чин улсын үеийн Алшаа хошууд хошууны Шажинтохой орноор нүүдэллэн ирсэн хятад иргэдийн нэмэгдэхийг дагалдан, тус орны нийгмийн бүтэц, амьдралын хэв маяг, соёл иргэншил, зан араншин, орчин ахуйн байдал аажмаар өөрчлөгдөн, тухайн орны аж ахуйн хөгжилтөд зохих хэмжээний нөлөө үзүүлсэн байна. Нэн илүү чин улсын үеийн Бортохой орон дахь үндэстний их нэгдлийг буй болгож, хятад монгол манж хотон зэрэг олон үндэстний хамтрал оршиход тун их ахиулах нөлөө үзүүлсэн байна.



# THE CULTURAL WAY

## ABSTRACT

Along with the increase of Chinese citizens who migrated to Shajintohei region of Alshaa Khosuud County during the Manchu and Qing Dynasty, the country's social structure, lifestyle, civilization, manners, and economy gradually changed, and had a significant impact on the country's agricultural development. During the Chinese period, Bortokhoi brought about a great unity of nationalities and had a great influence on the co-existence of many ethnic groups, including Chinese, Mongolian, Manchurian, and Chinese.

Keywords: *Manchu Da Qing, Chinese citizens*

## НОМ ЗҮЙ

1. Өвөр монголын Алшаа зүүн хошууны данс эвхмэл. 101-09-0007-136-0587-01
2. Өвөр монголын Алшаа зүүн хошууны данс эвхмэл. 101-05-0092-049-0261-02
3. Боржгид, Дорги. Алшаа хошууд. дээд дэвтэр, ӨМСХХ., 2002 т 270-271
4. 转引自胡日查: 《清代汉族移民在阿拉善地区的活动》, 《蒙古史研究》第十二辑, 2008 年
5. 转引自陈富玉: 《清代阿拉善和硕特额鲁特旗汉族移民若干问题研究》, 内蒙古师范大学 2010
6. 转引自布和: 《论清代阿拉善和硕特旗耕地的利用与保护》, 《青年文学家》第 18 期, 2013 年





КОЛЛЕЖИЙН МОНГОЛ ОЮУТНУУДАД ЗОРИУЛСАН ЕРӨНХИЙ ЯПОН ХЭЛ  
ЗААХ АРГЫН ТАЛААР ЗАРИМ АСУУДАЛ

Жао Хашэнь Гаова\*

ХУРААНГУЙ

Энэхүү нийтлэлд хэлний нийтлэг байдал, сургалтын хөтөлбөрийг оновчтой болгох үүднээс коллежийн Монгол оюутнуудад зориулсан ерөнхий Япон хэл заах арга зүйд зориулсан хэд хэдэн саналд дүн шинжилгээ хийсэн болно. Коллежийн Монгол оюутнуудад зориулсан ерөнхий япон хэлийг хятад үндэстний оюутнуудад зориулсан ерөнхий Япон хэл заах сургалтаас ялгаж, оюутнуудын эх хэлний монгол, япон хэлний авиа зүйн дүрмийн ижил төстэй байдлыг анхаарч, заах арга зүйг ялгах хэрэгтэй. Оюутнуудын япон хэл сурах сонирхлыг хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулахын тулд соёлын хүчин зүйлс, сургалтын хөтөлбөрийн үзэл суртлын болон улс төрийн хүчин зүйлсийг танхимын сургалтанд нэгтгэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ хичээлийн дизайныг оновчтой болгох, олон хэмжүүрээс хичээл заах, оюутнуудын хэрэглээний цогц чадварыг хөгжүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үгс: *Монгол оюутнууд; ерөнхий Япон хэлний сургалт; ялгаатай заах; хичээлийн дизайн*

---

\* Чифөн Их Сургуулийн багш, доктор



# THE CULTURAL WAY

## 关于蒙古族大学生公共日语教学方法的几点思考

赵哈申高娃

(赤峰学院·内蒙古·赤峰 024000)

**[摘要]** 本文从语言共性及课程优化的角度分析了蒙古族大学生公共日语教学方法的几点建议。蒙古族大学生的公共日语教学要与汉族大学生的日语教学相区分，抓住学生的母语蒙古语的语音语法与日语具有相似之处的特征，探索对比教学法。课堂教学中融入文化因素及课程思政，培养学生学习日语的兴趣，提高教学质量。同时要优化课堂设计，从多维度进行教学，培养学生综合运用能力。

**[关键词]** 蒙古族学生；公共日语课程；对比教学；课堂设计

中国是世界上学习日语人数最多的国家，日语也已成为国内高校的第二大外语语种。在国内很多高校不仅开设专业日语课，针对非专业学生也开设了公共日语课。从内蒙古自治区的高校外语授课情况看，学习公共大学日语的学生主要为音体美的学生和文科类专业的蒙古族学生，理科类的学生相对较少。近几年学习日语的蒙古族学生越来越多，再加上蒙古语和日语在语音、语法方面有很多共通之处，因此，开展蒙古族大学学生公共日语教学方法研究，成为了大学日语教师的一项重要任务。

### 一、提升日语教师的跨文化教育能力，培养学生学习兴趣。

日语作为第一外语的学生中，有很大一部分学生是因为他们英语学不会而不得不学习日语，其中多数为音体美专业的学习状态不佳的学生，考研和出国的学生占一定的比例。对日语感兴趣，真正想学的学生数量占的比例太少。这说明了学生选择日语作为第一外语，在主观上并非是出于感兴趣或者喜欢，而是认为与英语相比，日语简单，所以愿意选择日语。从以上学习日语的学生的构成和选择日语的原因出发，笔者认为教师必须努力对学生进行引导，从而激发学生学日语兴趣，并培养学习日语的自主能力。

激发学生的学习热情要从感兴趣的内容入手。大学生对文化感兴趣，更偏爱跨界文化。语言是文化的一部分，一种文化的想象，文化的载体。在外语学习的过程当中，应该注意对文化渊源的了解，因为单纯的外语学习，不能很好的掌握该门语言。外语教学中的文化导入首先要提升日语教师的跨文化教育能力。教师是知识的传播者，文化的传播者，而课堂教学是教师传播知识和学生学习和重要途径道与方式。在语言学习的过程中，教师的文化素养与教学水平对学生的课堂学习起到至关重要的作用，尤其是一门外语的学习，学生在日常生活中很少接触真实的场景和语境，便更加需要教师将学生带入到相应的场景之中，帮助进入更完备的学习状态。因此，跨文化视角下



的日语教学，首当其冲便是提升日语教师的跨文化教育能力。首先，聘请自身有着浓厚的日本文化底蕴和文化素养的日语教师。其次，日语教师在拥有日语专业学习经历和丰富的教学经验的同时，也需要不断增加自身对日本文化的认知与阅历，要不断更新自身的文化认知内容，做到与时俱进，时刻能够跟随上日语的发展与变迁。比如，通过在日本留学、游学，观看日本文化相关的电影、书籍等方式，深入地、真实地了解当地本土文化，对其语言发展、历史文化积累更加丰厚的底蕴，有着亲身体验会更有助于在教学过程中运用文化导入的方式将学生带入到高效率高氛围的课堂教学中。其次，教师自身需要有理性的思维和文化共荣和发展的意识，明确语言、文化的学习是帮助我们更好地提升自己、认知国家、了解世界的重要途径，形成一种理解、包容的心态，从而有能力在学生遇到文化冲突时，更好地帮助其化解心中的困惑和忧虑。

### 二、进行蒙古语和日语的对比教学，提高教学质量。

语言教学法主要分为“语法翻译法”和“直接法”两大类。“语法翻译法”是以语法为基础，将目标语言置换为母语的方法，从古至今都被广泛使用的教学方法。语法翻译法具有通过语法知识的理解和记忆来培养智力、通过学习者的母语赋予单词意思、母语和目标语言的翻译练习等特征。“直接法”是不使用学习者的母语的语法等特点进行说明，只通过目标语言的语法、文章理解等，谋求目标语言的学习的方法。蒙古语和日语都属于黏着语，语法结构相似，因此认为对比两种语言的语法进行学习是有较好的效果。笔者认为蒙古族学生的日语教学将语法教学作为优选选择，以“语法翻译法”为基础，进行“蒙日语法对比”教学方法。“蒙日语法对比”教学法是根据其相似性和差异性，将蒙古语、日语两种语言的语法进行对比。蒙古语和日语在语言结构方面有诸多相似之处。例如，语法顺序均为SOV结构；动词有词干，动词的语法意义，日语和蒙古语都采取动词词缀的变化方式来表达；名词格的附加形式也极其相似。日语和蒙古语在语音方面也有不少相似之处。例如，语音和音节的发音有相同活相似之处；存在用长短音表达不同词义的现象。另外，二者词汇中有不少同源词，其有利于单词的理解与背诵。由于两种语言的共性所在，蒙古族学生在学习日语的过程中，在语言的音准和语言表达的理解上掌握得更快、更准。在蒙古族学生的日语教学中，教师注重“直接教学法”的同时，归纳总结出蒙日语言的共性，采用“语法翻译法”，进行“蒙日语法对比”“汉日语法对比”教学方法，为实现母语的的正迁移打下坚实的基础。通过对比分析的方法总结蒙日词汇在概念意义、内涵意义、情感意义等方面的异同，帮助学生掌握词汇在不同语境中的不同词义变化，搭配特点，语用限制等词汇深层知识，提高学生的用词能力，最大限度地减轻蒙语负迁移对词汇应用的干扰作用。抓住蒙古族学生的蒙汉兼通的优势，进行蒙古语与日语、汉语与日语之对比教学，得到事半功倍的效果。

### 三、优化课堂设计，注重综合素养的培养。

提升跨文化教学的认知，以文化导入的理念优化课程设置，从多维度进行教学。学校如何科学地设置相关课程，如何将文化融入到语言学习的过程之中是十分关键，课程的设置决定着学生接受何种方式的教育、何种内容的教育。首先是认知层面的问



题，学校、教师、学生都需要认识到文化对于语言学习的重要性，只有意识层面重视起来，才会采取卓有成效的行动，实现真正的改革与发展。其次是行为层面的问题，需要将文化导入落实到课堂实践当中，适当增加日本文化类课程的课时，将日语理论知识教学与文化导入同时进行，不断丰富日语学习在上课课下的教学实践活动。日本文化课程要贯穿于整个教学过程的始终，从日本的发展历史、重大阶段的事件对其文化产生的影响、当前文化的内容和倾向等等角度，深度剖析其形成当下文化的原因，引导学生对语言文字的深刻认知。只有真正了解一个国家的文化，才能真正学好一门语言。在教授日语理论知识的过程中，不断融入日本的文化，让学生体验身临其境的感觉，更好地培养学生的语感，在实践中更加运筹帷幄、自由畅快。实践课程的部分也是十分重要、不可或缺的，语言的学习最终要依靠听、说、读、写的完美配合实现其实质的效果。而在实践的过程中，学生不仅仅在语言上能够得到不断地锤炼，还能够从神态、动作等各个方面去不断提升自己与日本人交流的真实能力。

教师讲课只有生动有趣才能吸引学生的注意力，才能使学生在轻松愉快的氛围中学习日语。这要求授课教师不能于味死板地讲解语法和单词，而是要更加灵活地讲解语法和单词，使语法和单词更贴近生活和文化。

#### 四、培养文化差异意识，提高语言交际能力。

日语教学中因文化差异引发的问题也日益凸显。因此，在平时的教学中，要根据学生自身文化和日本本土的风俗习惯，去了解和掌握有关的知识。但是，由于我国日语教育一直以来都是以传统的语言和语法的形式来进行，而且大部分的课程模式都是以这种形式来进行的，课程主要是针对的是学生日语阅读能力、应试能力的提高，语言构成能力的不断完善和语言结构的理解加深，而忽略了对语言交际能力和综合能力的培养。因为对日语的理解较为不足，造成了部分同学虽然会说一口流利的日语，在听到日语后可以根据自己积累的语言经验进行准确的理解和分析，但由于他们的文化交际方式往往会有偏差，从而造成很多的误会和偏差，进而产生一些不必要的麻烦。

目前来看，日语教学通常采取的是多练习句子形式，语法解析，一般采用的是传统的日语教学方式如词汇解释，而忽视了在日语教学中使用的词、句交流的问题，导致日语学习者在交流与应用中遇到了困难。另外在日语文化的教育中，老师们往往花费了很多的精力和时间在日本的人文、社会历史、诗歌等方面，而忽略了日语的语言沟通交流的学习，这就导致了学生在与日本人的交流中，往往会用本国的语言语境来评判日本语言文化，造成了不同国家文化上的分歧和矛盾。从相关机构研究结果可以发现，目前日语的语言教育问题多为注重掌握语言的字词、语句结构、语法等，而忽略了其日语交流实用的作用。因此在日常教学中，不断加强日语在具体语言环境下的沟通方式，促进学生可以更好的使用日语进行日常社交与交流。

### 结 论

蒙古族学生的公共日语教学需要教师打破传统的教学模式，导入文化因素及课程思政，优化课堂设计，抓住蒙古族学生的蒙汉兼通的优势，利用日语、蒙古语、汉语



## THE CULTURAL WAY

的共性，进行对比教学。把日本文化、日本人的日常生活习惯导入日语教学，创造学习日语语言的环境，激发学生学习的主动性，培养学生综合应用能力。将在日语教学过程中结合少数民族大学生的母语特点置于高等院校日语教学改革的重要战略地位，并给予足够的重视，制定出相应的外语教学改革方案，并督促实施，这样才能使高校少数民族学生的日语教学改革得到更好的健康发展。

### 参考文献:

- [1] 陈文静. 论日本文化与高校日语教学的共生效应[J]. 长春理工大学学报(高教版), 2009年第7期.
- [2] 杜江毅. 对日汉语教学的民俗视角[D]. 吉林大学, 2011年.
- [3] 孙延永、安桂芹. 蒙古族学生公共日语教学方法研究[J]. 内蒙古民族大学学报(社会科学版), 2015年第6期.
- [4] 孙有中、廖鸿婧、郑萱, 秦硕谦. 《跨文化外语教学研究》[M]. 外语教学与研究出版社, 2021年第3期.
- [5] 徐学福. 《探究学习教学策略》[M]. 北京师范大学出版社, 2010年7期.
- [6] 詹建红. 从中日文化差异谈日语教学[J], 外语教学. 2000年03期.
- [7] 中村涉. 母語の相違に対する日本語教授の開発に関する基礎的研究[J]. 『東北大学高等教育推進センター』紀要. 2009. 253-260.
- [8] 王冠华. 试谈跨文化交流在日语教学中的导入[J]. 北京第二外国语学院学报, 2004年, 06期.
- [9] 王静. 浅析日语教学中的深层文化导入[J]. 考试周刊, 2009年20期.
- [10] 赵冬玲. 也谈日本文化在日语教学中的渗透[J]. 考试周刊, 2011年58期.

### ДҮГНЭЛТ

Монгол оюутнуудад зориулсан ерөнхий Япон хэлний сургалт нь багш нараас уламжлалт сургалтын загварт өөрчлөлт хийж, соёлын хүчин зүйл, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, хичээлийн дизайныг оновчтой болгох, монгол оюутнуудын монгол, хятад хос хэлний давуу талыг ашиглах, япон, монгол, хятад хэлний нийтлэг шинж чанарыг ашиглаж харьцуулсан сургалт явуулахыг шаарддаг. Япон хэлний сургалтанд япон соёл, японы өдөр тутмын хэвшлийг нэвтрүүлж, япон хэл сурах орчинг бүрдүүлж, япон хэл сурахад сурагчдын идэвх санаачилгыг идэвхжүүлж, оюутнуудын хэрэглээний цогц чадварыг хөгжүүлнэ. Япон хэл заах явцад коллежийн цөөхөн тоот үндэстний оюутнуудын эх хэлний онцлогийг уялдуулан сургах нь коллеж, их дээд сургуулийн япон хэлний сургалтын шинэчлэлд стратегийн чухал ач холбогдолтой байхыг хүндэтгээн, шинэчлэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавихаар дамжуулан коллеж, их дээд сургуулийн цөөхөн тоот үндэстний оюутнуудад зориулсан япон хэлний сургалтын шинэчлэл нь илүү сайн, эрүүл хөгжиж чадна.



## БЭЛГЭДЭЛ ТЭМДГИЙН УРЛАГИЙН ЗОХИОН БҮТЭЭЛ ДЭХ ХЭРЭГЛЭЛТ

Сарнай\* (Sha ri na)

## ХУРААНГУЙ

Монгол үндэстний соёл урлаг бол нүүдлийн мал аж ахун амьдралын суурин дээр бүрэлдсэн байгалийн орчин тойрон лугаа эе зохицолтой нэгдсэн соёл урлаг болно. Өнөөгийн монгол үндэстний соёл урлагийг судлахад хүн төрөлхтний судлалын бүхэл цогцын судалгааны талыг хэрэглэн, монгол үндэстний өнөөгийн урлагийн бүтээлийн хэлбэр, бүтцээр дамжуулан үндэстний соёл урлагийн эх сурвалжийг сэргээх ба дахин эрж олох хэрэгтэй. Тус өгүүлэлд Шанхайн олон улсын бүжгийн төвийн урлагийн найрт сонгогдсон монгол үндэстний өнөөгийн бүжигт жүжиг “Шилийн гол”-оор жишээлж, бие махбодын үйлдлийн арга хэлбэрээр дамжин монгол үндэстний уламжлалт соёлын агуулахууныг хүлээн авсан суурин дээр өнөөгийн монгол үндэстний соёл урлагийн илтгэх шинэ хэлбэрийг эрэлхийлэхээр оролдов.

Түлхүүр үгс: *Монгол үндэстэн, өнөөгийн урлаг, өнөөгийн бүжиг, бие махбодын үйлдэл, хүн төрөлхтний судлал*

Хүн төрөлхтний судлалын зогсолтоос авч үзвэл, бүжиг бол үг хэлтэй адил солилцооны нэг зүйлийн мэдээ занги дамжуулах хэв загвар мөн, даруй онцгой соёлын бие махбодын хөдөлгөөн ба утга урлагийн систем дэх хүний биеийн цаг ба орон зайн хэрэглэлт мөн. Өөрөөр хэлбэл, бүжиг бол хүний биеийн цаг ба орон зай дахь бүтээлч чанартай хэрэглэлтээс буй болсон нэг зүйлийн соёлын хэлбэр юм<sup>1</sup>. Бие махбод бол соёлын ачаалагч мөн, бие махбод нь бүжгийн илтгэлтийн шууд үг хэл болсны хувьд нэн олон давхар элбэг баялаг соёлын утга агуулгыг ачаалж байдаг. Одоогийн хүн төрөлхтний судлал дахь бие махбодын судлал бол даруй аливаа бие махбодын үзэгдлийг бүхий л амьдралын системийн давхаргад оруулж өдөр тутмын амьдрал дундах бие махбодын үйлдлийг эрэлхийлнэ. Адил бус соёлд бие махбодын үйлдэл нь олон янзын мөртөө тогтворгүй байж, тунгаан бодолхийлэх чанартай байдаг, иймэрхүү бие махбодын үйлдэл нь хожуу өнөөгийн бие махбодын үзэл нь тайлбарлаж, биднийг сэнхрүүлж өнгөрсний тайлбарлалтад тасралтгүй засвар оруулахын хамт хүн төрөлхтний судлал дахь бие махбод хийгээд биечилсэн

\* Өвөр Монголын Урлагийн Дээд Сургуулийн багш

<sup>1</sup> Ван Жяньминь. Бүжгийн хүн төрөлхтний соёл дахь ухагдахууны задлалт ярилцлага.

Үндэстний урлаг судлал., 2015





## THE CULTURAL WAY

чанарын судлалыг тунгаан бодолхийлнэ<sup>2</sup>. Өнөөгийн урлагийн зохион бүтээлт дэх бие махбодын үйлдэл нь ч бүхий л зохион бүтээлтийн хүрээ царанд агуулагдсан соёлын орчин тойронд биеэрээ очиж ойлгох ёстой.

Нэг. Биечилсэн чанар бүхий бие махбодын үйлдэл

Биечилсэн чанар бүхий хэв маягийн улирал хувьсалтын нэгэн гол онцлог бол оюун санаа ба бие махбод, биеч цогц ба бусдач цогцын хоорондох хоёр ишт онолын сүйрэл болно. Энэхүү утга агуулгаас авч үзвэл, Мосын “Бие махбодын ур мэргэжил” нь биечилсэн чанар бүхий гэрчлэлтийн задлалт ба хэв томьёон бүрэлдлийг ахиулахад чухал үнэ цэнтэй. Мос нэг зүйлийгн бие сэтгэцийн хоёр ишт онолоос давсан хэлбэрээр өөрийн үзлээ илтгэж, бие махбодын ур мэргэжлийг адил бус нийгмийн ажиллагааны дунд хүмүүс бие махбодоо хэрхэн хэрэглэхийг мэдэх хэлбэр гэж томьёолов. Энэхүү ухагдахуун нь хүний бие махбод, оюун санаа ба нийгмийн бүх талыг нэгэн бүхэл цогц болгон холбогдуулсан байна. Мос бие махбодын ур мэргэжлийн олон тал дахь холбогдлыг “дадал”-аар утгачлав. Тэрбээр бие махбодын ур мэргэжлээ сургамж гэж тайлбарласан байна. Даруй үйлдлийн оюунч чанарын хэлбэр мөн, иймэрхүү хэлбэр нь нийгэм, сурган хүмүүжил, ёс журам, цагийн өнгө ба нэр хүндээс болж ондоошдог<sup>3</sup>. Шилийн гол бол хоёр хүний өнөөгийн бүжигт жүжиг бүтээл юм.

Тус бүтээл нь өнөөгийн бүжгээр монгол үндэстний соёл ба өнөөгийн монголчуудын амьдралын тухай бодолхийллийг өгүүлжээ. Бүтээл нь үзэл санаа, бие махбодын талаар уламжлал ба өнөөгийн мөргөлдөөнийг зохицуулж, нэг зүйлийн өөрийгөө мэдрэх сэтгэлгээний илтгэлтийг эрэлхийлэв. Удирдаачаас ээжийнхээ нутаг Шилийн голоор зохион бүтээлтийн ахуй байдал болгосон байж, Шилийн гол нь ч яг монгол үндэстний соёлын үүслийн орны нэг болно, хоёр үеийн монгол хүний ярилцлагаар дамжин өөр өөрийнх нь өөрийгөө илэрхийлэх аяныг тусгаж, аль олон мөргөлдөөн, эсэргүүцлийг өнгөрүүлсний дараа, харилцан ойлголцож, эвлэрэн, хамтаар оршсон байна. Үүний хамт энэхүү суурин дээр, өөрийн мэдрэмжээ дахин шинээр байгуулав. Судас “Биечилсэн чанар ба туршлага” гэх бүтээлдээ бид бие махбодоор задлалтын төв болгож, соёл өөр би ба өнгөрөлтийн онолыг шинээр байгуулах чухалтай гэж үзэв. Бие махбод бол биеч чанарын оршиж байгаа газар мөн, соёлын онолын өрсөлдөөн байж, соёлын онолын дахин бүтээлт дунд сэтгэхүй /биеч цогц/ соёл ба бие махбод/ бусдач цогц/ амьд бодисын ухаантай зэрэгцэж харьцангуй байдаг. Судаст авч хэлвэл, биечилсэн чанар бол соёл ба өөр бие-

<sup>2</sup> Ху Яньхуа. Өрнө дахины бие махбодын хүн төрөлхтний судлал. Судалгааны зам ба хэв хэлбэрийн солигдол. Улсын гадаадын нийгмийн шинжлэх ухаан., 2013

<sup>3</sup> Ху Яньхуа. Бие мах бод хийгээд биечилсэн чанар. Гуансы УИСС. Марксын үзлийн нийгмийн шинжлэх ухаан., 2021



## THE CULTURAL WAY

ийн оршихуйн суурь мөн<sup>4</sup>. Урлагийн зохион бүтээгчээс Шилийн голыг зохион бүтээх явцдаа биечилсэн чанарын оролцоо ба бие махбодын үйлдлийн зохион бүтээлтээр дамжин, соёлыг таних, ойлгох түүнийг дахин бүтээх гурван шатыг өнгөрүүлсэн бөгөөд энэхүү суурин дээр бодгаль биеийн мэдрэмжийн илтгэлтийг биелүүлсэн юм.

Хоёр. Бэлгэдэл тэмдгийн “Шилийн гол” дахь хэрэглэлт

Бэлгэ тэмдэг бол даруй “бодис, үйл ажиллагаа зэргээр ачаалагч болгон үүгээр ойлгогдохууны агуулгыг дэлгэн үзүүлэв. Соёл нь үнэндээ түүхийн хөгжилтийг дагалдан тэмдгийн утга агуулгыг дэлгэн үзүүлж, тэмдгийг уламжлан залгамжлахаар дамжуулан хүмүүсийн үзэл санаагаа илтгэх ба мэдлэгээ тодорхойлон өгүүлэхэд хавсрамж болдог” гэж хүн төрөлхтний бэлгэдлийн ухаантан Гелц дурдаж өнгөрсөн билээ<sup>5</sup>. Бүтээл “Шилийн гол”-д удирдаачаас 4 метр урт морины ташуур сунгаж багаж болгов. Монгол үндэстэн бол морины нуруун дээрх үндэстэн, ташуур бол монгол үндэстний чухал соёлын тэмдгийн нэг, мөн ч бүтээл дэх “ээж” ба “охин” хүний харилцааны холбоос байж, нэн ч хүмүүсийн дотоод сэтгэлийн зөрчил мөргөлдөөний бодит илрэл юм. Ташуурыг жүжигчлэхээр дамжин хоёр үеийн монгол хүний хайр сэтгэлийн холбогдол, хүн байгалийн холбогдол жич монгол үндэстэн лүгээ холбогдлыг байгуулсан байна. Уран бүтээл дэх ташуурын хэрэглээний хувиралтаар дамжин соёлын тэмдэг нь монгол үндэстний нүүдлийн соёл урлагийн тухай мэдрэмж ба сэтгэхүйн арга маягийг хэрхэн шууж байгааг мэдэж болно.

Уран бүтээл Шилийн гол дахь бие махбодын үг хэлний төсөвлөл ба илтгэл нь ч бэлгэдлийн утга агуулгаар дүүрэн байдаг. Жишээлбэл, ээжийн хамгийн сүүлчийн нэг хэсэг бэлгэн бүжиг нь хоёр гараараа хурайлж байснаасаа бүрэн тэнийлгэж, хөгжмийн доторх “хараацай”-н эх нутагтаа буцсан үлгэрийг дагалдан, нэг амь насыг бойжуулах бүрэн бүтэн явцыг дэлгэн үзүүлэв. Бүтээлийн нэгдүгээр хэсгийн хоёр орон зайд, охин нь ээжтэйгээ тэртээ цаг дахь уртын дууны аясаар ярилцаж, ээж нь дайсны өмнө хажууд нам жим сууж ташуур гөрөн, харин охиных нь бие ташуурын хөдлөл байдлыг дагаж тогтворгүй тасалдангуйгаар монгол үндэстний тэмдэг бүхий өнөө үеийн бүжгийн үг хэлийг илэрхийлж, яг л нэгэн орчин тойронд хашигдаад зугтаахын аргагүй болсон мэт байлаа.

Өнөөгийн дууны аялгуун хувиралтыг дагалдан ээж ба охин тасралтгүй ойртон, эцэстээ учирч, хоёр орон зайн соёлын мөргөлдөл ба давхацлыг бэлгэдсэн юм. Уран бүтээлийн хувцас хунар нь Шилийн голн сав газрын

<sup>4</sup> Ху Яньхуа. Бие мах бод хийгээд биечилсэн чанар. Гуансы УИСС. Марксын үзлийн нийгмийн шинжлэх ухаан., 2021

<sup>5</sup> Ү Фөнлин. Хүн төрөлхтний судлалын онолын бэлгэдэл жич түүний гол төлөөлөгчийн танилцуулга. Шашин шүтлэг ба үндэстний соёл., 2010





## THE CULTURAL WAY

Цахар аймгийн уламжлалт монгол үндэстний хувцас заслыг сонгон хэрэглэсэн бөгөөд энэхүү хувцас заншил нь ч Өвөр монгол орны бодисын бус соёлын өвийн нэг болох мөртөө монгол үндэстний соёлын онцлог тодхон байдаг. Тус бүтээлд ээжийн Шилийн голын хөвөөнд буцаж ирэхээр монгол үндэстний соёлын зан дадал дахь “гээг самнах ёслол”-ыг дахин илрүүлж, цагийн тонгоруу дарааллаар ээж нь эмэгтэй хүний харьд мордохоос өмнөх дүрийг байдлыг дэлгэн үзүүлжээ. Уран бүтээл Шилийн гол нь хувцас хунар, бүжгийн гоо сайхан, багаж хэрэгсэл, дуу хөгжим жич бүжгийн бие махбодын үг хэлний хөдлөлийн төсөвлөл ба дайсны жүжигчилсэн урлагийн шийдвэрлэлтээр дамжин тэмдэг нь соёлын ачаалагч болсны хувьд урлагийн зохион бүтээлтэд хэрхэн хэрэглэгдсэнийг мэдэж болно.

Соёл бол тогтмол бөгөөд зааг хязгаартай бодит цогц биш харин тасралтгүй хувирч, зохиож, ондоошин оршдог юм. Соёл бол нэгэн ерөнхийлсөн систем мөн бөгөөд бас ч хүн төрөлхтний дэлхий ертөнцөд зохицох арга маяг мөн<sup>6</sup>. Соёл нь өөр биетэй нягт холбоотой байж, соёл нь хүний үйл ажиллагааны бүрэлдлийг тогтоож, адил бус соёлын элементийн нөлөөг хүртэж, бодгаль биеийн өөрийн ухамсар нь зөрөөтэй байдаг. Монгол үндэстний өнөөгийн урлагийн зохион бүтээлтэд урлагийн зохион бүтээгч нь монгол үндэстний уламжлалт соёлын цөмийг хүлээн авсан суурин дээр шинийг үүдэх хэлбэрийн зохион бүтээлтийг хэрхэн хийж, биечилсэн бие махбодын үйлдлийн зохион бүтээлтэд оролцох явцаар дамжин бодгаль биеийн мэдрэмж ба үндэстний сөргөцлийн мэдрэмжийг олсон суурин дээр монгол үндэстний соёлын дахин бүтээлтийг биелүүлэх бол нэгэн өрсөлдөөний чанартай үүрэг мөн. Зохион бүтээгч хүн төрөлхтний судлалын бүхий л талаас зохион бүтээлтийн явцад тэмдгээс үүсгэсэн соёлын орчноос салахгүй, монгол үндэстний урлагийн эх үүслийн мөн чанарын онцлогийг хүндэтгэн ойлгосон суурин дээр өнөөгийн урлагийн илэрхийллийн арга хэлбэр жич агуулахууныг сэтгэн бодолхийлж, урлагийн зохион бүтээлтдээ “буцаж ирсэн” анхны уг санааг ажиглан шинжихээ марталгүй байж, нээлтэй сүвэгчлэлийн чанартай зохион бүтээлтийг баримтлан, урлагийн гоо таашаалын туршлагын мэдрэмжийг нэн илүү хүртэх хэрэгтэй.

---

<sup>6</sup> Ван Жяньминь. Соёл. Гуансы УИСС. Марксын үзлийн нийгмийн шинжлэх ухаан., 2003



# THE CULTURAL WAY

## ABSTRACT

Culture and art of the Mongolian nation is an integrated culture and art in harmony with the natural environment formed on the basis of nomadic herding life. To study the current culture and art of the Mongolian nation, it is necessary to use the research aspects of the whole complex of human studies, to restore and find the source of the culture and art of the nation through the form and structure of the current works of art of the Mongolian nation. In the article, the contemporary Mongolian dance drama "Glass River" selected for the Shanghai International Dance Center's Art Festival was used as an example, and an attempt was made to search for a new form of presenting Mongolian culture and art on the basis of accepting the traditional Mongolian cultural storehouse through physical action.

Keywords: *Mongolian nation, contemporary art, contemporary dance, physical activity, humanities studies*

## НОМ ЗҮЙ

1. Ван Жяньминь. Соёл. Гуансы ҮИСС. Марксын үзлийн нийгмийн шинжлэх ухаан., 2003
2. Ван Жяньминь. Бүжгийн хүн төрөлхтний соёл дахь ухагдахууны задлалт ярилцлага. Үндэстний урлаг судлал., 2015
3. Мандах. Хүн төрөлхтний судлалын уг цогцын онол ба монгол үндэстний соёл урлагийн үүсэл гарал. Утга урлагийн судалаа., 1998
4. Ху Яньхуа. Өрнө дахины бие махбодын хүн төрөлхтний судлал. Судалгааны зам ба хэв хэлбэрийн солигдол. Улсын гадаадын нийгмийн шинжлэх ухаан., 2013
5. Ху Яньхуа. Бие мах бод хийгээд биечилсэн чанар. Гуансы ҮИСС. Марксын үзлийн нийгмийн шинжлэх ухаан., 2021
6. Ү Фөнлин. Хүн төрөлхтний судлалын онолын бэлгэдэл жич түүний гол төлөөлөгчийн танилцуулга. Шашин шүтлэг ба үндэстний соёл., 2010



## АРИГ УРИАНХАЙН АЯЛГУУНЫ ТУХАЙ

Л. Чулуунбаатар\*

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сум бол Хөвсгөл аймгийн зүүн хойт хэсэгт байрлаж, Хангайн уулархаг мужийн салбар Саяны нурууны үргэлжлэл Булнайн Цагаан уул, Бусганы Цагаан уул, Сар өрх, Гархи, Бадар, Ушгарын нурууд зэрэг хөвч тайга хосолсон өндөр уулын нутаг бөгөөд баруун талаараа Хөвсгөл нууртай хил залгадаг.

НҮБ-ийн Хөгжлийн байгуулагаас Хөвсгөл аймгийн Урианхай аялгуут мөхөж байгаа хэл аялгууны бүлэгт багтаан оруулсан байдаг. Тийнхүү мөхөж байгаа болон халх аялгуунаа уусан шингэж байгаа Хөвсгөл нутгийн угсаатан, ястны хэл аялгууны үнэт хэрэглэгдхүүн болсон ардын аман билиг болох дуу, шүлэг, хууч яриа, домог, ерөөл магтаал зэргийг Улсын Их Хурлын гишүүн асан П.Цагааны санаачлага, хичээл зүтгэлээр тэдний багийнхан мөшгөн сурвалжилж, “Хөвсгөлийн Урианхайн аман билиг”<sup>1</sup> хэмээх бүтээл гаргасан нь ардын аман билгийг судлан сурвалжлах, нутгийн аялгууны хэрэглэгдхүүнийг сурвалжлан цуглуулагч нарт чухал хэрэглэгдхүүн болж байна.

Чандмань-Өндөр сумын нутаг болох Аригийн голын хөвөөнд нутгийн зон олны босгосон Алон-Гоа эхийн хөшөө сүндэрлэн байх нь буй. Нэрт эрдэмтэн Б.Ринчин нэгэн судалгааны өгүүлэлдээ “Ариг уснаа төрсөн Алон-гоа эхийн төрсөн нутаг бол Аригийн гол мөн” хэмээн дурдсан байдгаас үүдэж энэ хөшөөг босгожээ. Рашид-ад-дин Судрын чуулган хэмээх зохиолдоо “Бүгдийн эмэг ээжий Алон-Гоа”<sup>2</sup> хэмээн тэмдэглэжээ.

Урианхан нь Дарлиган монголчуудын өтгөч өвөг аймгуудын нэг бөгөөд Дарлиган Урианхан нар бүр Алон-Гоагийн өмнө үеэс Бурхан Халдун, Онон мөрний цутгал Балужн гол, Түнхлэг горхины орчим нутаглан суужээ. Монголын нууц товчоонд “Бурхан босгосон шинч баян Урианхан” хэмээн өгүүлсэн нь буй. Энэ нь Урианхан Х зууны дунд хүртэл “ээзэнтэй иргэн”

---

\* Монгол Улсын Үндэсний Их Сургууль, Доктор (Ph.D)

<sup>1</sup> Хөвсгөлийн Урианхайн аман билиг, УБ., 2019

<sup>2</sup> Рашид-ад-дин, Судрын чуулган, Т.1, 1952 т 78-79



## THE CULTURAL WAY

гэгдэж яваад мөн зууны сүүлийн хагаст Боржигон овгийг үүсгэгч Бодончарын мэдэлд захирагджээ. Түүнээс хойш Урианхан нар нь Нирун аймагтай дотно холбоо тогтоож, Монголын нэгдсэн төр улсыг байгуулахад хүч зүтгэлцсэн ажээ.<sup>3</sup>

Нирун улсын үед соёл боловсрол цэцэглэн хөгжиж, бичиг үсгийн өндөр соёлтой дундад Азиар нутаглах Согд нараас бичиг зсэг зээлэн өөрийн бичиг үсэгтэй болсон гэх үздийн сүүлийн үед хэлбигийн эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна. Энэ тухай Монголын нэрт түүхч Зава Дамдин гавж, төвдөөр бичсэн “Монголын түүх” (Hor-chos’ byun) зохиолдоо: Чингис хааны үеэс даруй 700 жилийн урдаас монгол, уйгар, согд нар их л ойр харилцаатай байсныг дурдаад “Согдын мэргэн багш нар Уйгар хийгээд Монголчуудад үсэг бичиг унших ба бурхны дээд зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургав. Бас Согд нар Энэтхэг орноос бурхны номыг Монгол оронд залж ирсэн бөгөөд энэ шалтгаанаар номын хэлэнд энэтхэг, уйгар, монгол үг холимгоор оршсоор байна”<sup>4</sup> гэжээ. Энэ нь Чингисийг хаан суусан оноос урагш хөөвөл Их Нируны ид мандан байсан 400-гаад оны үед очиж байгаа нь бичиг ном заадаг багш гэдэг үг идэвхитэй хэрэглэгдэж, монгол бичгийг согдоос авсан он цагийн давхар баталгаа болж байна. Энэ үеийн Согд, Монгол, Уйгар нарын харилцаа Уйгарын хаант улсын үе хүртэл үргэлжлэн байсан болтой. Энэ талаар Академич Б.Ренчин нэг өгүүлэлдээ “Монголчууд уйгар бичгийг Чингисээс бүр өмнө Буданцар дээдсийн үед мэддэг байсан”<sup>5</sup> гэж дүгнэсэн байдаг нь эрхбиш Зава Дамдин гавжийн үгийг давхар баталгаажуулан байна. Эндээс үзэхэд Алон-Гоагийн үед буюу Нируны үед бичиг соёл эрдэм ухаан цэцэглэж хөгжиж байжээ хэмээн үзэж болох талтай. Аливаа үндэстний хэл цэцэглэн хөгжих гол үндэс нь тэр хэлний бичиг үсэг байдаг болохоор монгол хэл цэцэглэн хөгжиж олон зууны турш идэвхтэй хэрэглэгдсээр байгаа нь Алон-Гоагийн үед зээлж авсан монгол бичгийн үр ач хэмээн бас хэлж болно.

Хөвсгөл аймгийн Чанмань-Өндөр сумын Урианхай ястнууд бол Урианхай омогтны гол цөм болсон онцгой нэгэн аман аялгуутан билээ. 1920-иод оны үед Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов “Хөвсгөл нуурын зүүн биеийн ардууд онцгой нэгэн аман аялгуутай” хэмээн цохон

<sup>3</sup> Монголын нууц товчоо, УБ., 2011, 58-р зүйл

<sup>4</sup> (Фл-к!λ. }#ψ-φ#|-ωΠ□λ. Rtam din Hor-chos’ byun)

<sup>5</sup> Yongsyiebu Rincen. Les inscription inconnues sur pierre et les plaques d’or ornementees du harnais de Toyoucouc. “Central Asiatic Journal” vol 4, No 4, p 20



## THE CULTURAL WAY

тэмдэглэж байсан хийгээд 1982 онд Д-р Ж.Цолоо “БНМАУ-ын нутгийн аялгуу” хэмээх ном бичсэн бөгөөд түүндээ ариг урианхайн аялгууны талаар “Ариг урианхайн салбар аман аялгууны тухай элдэв сурвалж бичиг зохиолд ойн урианхан, урианхай хэмээх хоёр нэр тэмдэглэгдсэн байна. БНМАУ-ын нутагт өөрсдийгөө урианхан, урианхай гэж нэрлэдэг хүмүүс бий. Ховд аймгийн Дуут, Мөст, Баян-Өлгий аймгийн Буянт, Алтай сумын урианхай ойрдын нэг салбар аман аялгуутан болно. Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Ховд, Хөвсгөл зэрэг аймагт хэсэг бусгаараа тархан суусан урианхан нь халх аялгууны бүлэгт багтана.

Эднийг их урианхан, бага урианхан, аданхан урианхан, урианхай гэж ялган хэлэлцдэг. X-XII зууны үеийн Дарлигин нэртэй монгол язгуурын арван найман аймгийн нэг нь урианхан байсан юм. Урианхан нар монголын нэгдсэн төр улсыг байгуулахад оролцож, Юань гүрний үед Бурхан халдуны Их хориг сахиж байлаа. Сүүлд феодалын бутралын үед зүүн монголын зургаан түмний нэг нь болсон гэх зэрэг түүхэн мэдээ байдаг. Халхын арван гурван отгийн халх түмний биеэ даасан долоон отгийн нэг нь урианхан нар бөгөөд хожим Засагт хан аймагт захирагдах болжээ.

Эдний тасархай нь Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Аригийн голоор нутаглаж байгаа ариг жарчиуд овогт халх ариг урианхай юм. Тэд эртний Бурхан халдуны Аданхан урианхайн удам салбар мөн. Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ариг урианханд *yāngi*, *arγamúd*, *dzelem*, *šawaršúd*, *oŋxod* ..... ясны хүмүүс байна. *šawaršúd* ясны хүмүүс Чандмань-Өндөр сумын II бригадын нутагт буюу Аригийн голоор, *arγamúd* ясны хүмүүс мөн сумын II бригадын нутагт буюу Даагаа голоор, *yāngi* ясны хүмүүс Цэгэр, Ёлгосоор, *dzelem* ясны аригууд уг сумын I бригадын нутаг Шивэрт, Цавчирт, Цахиуртаар, *oŋxod* ясны хүмүүс холимог сууж байна. Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр ариг урианхай аялгуугаар, Үүр голын урианхай нь угсаа ондоотой, түрэг хэлээр ярилцдаг.”<sup>6</sup> хэмээгээд Хөвсгөл аймгийн ариг урианхайн салбар аман аялгууны зарим онцлогийг дурьдаж оруулсан байдаг. Жишээлбэл: явтал хэмээхийг *yvtar* явтар хэмээн хэлнэ гэх мэтээр зарим онцлогийг товч дурьдсан байдаг. Д-р Л.Чулуунбаатар 1989 онд залуу монголч эрдэмтэдийн анхдугаар хуралд “Ариг урианхайн аялгуу” хэмээх илтгэл тавьж халх, буриад, дархад аялгууны дундын шинжтэйг онцлон аялгууны хэрэглэгдэх байдлыг нутгийн хүмүүсийн аман ярианы баримтаар, дээрх зүйлийг бага зэрэг дэлгэрүүлсэн билээ. Гэвч тэр цагаас хойш нарийн дэлгэрэнгүй судалгаа хийсэн ажил огт гараагүй байгаа бөгөөд Ариг урианхайн аялгуутай улбаа нэгтэй Говь-Алтайн Тонхил, Ховд аймгийн Цэцэг, Дарви

<sup>6</sup> Ж.Цолоо “БНМАУ-ын нутгийн аялгуу”, УБ., т 72



## THE CULTURAL WAY

сумынхны аялгуу, мөн ордосын аман аялгуутай харьцуулан судалгаа хийх нь чухал байгаа юм. Мөн нөгөөтэйгүүр энэ нутагт амьдаран сууж байсан Соёд урианхан нарын хэл аялгууны талаар академич Л.Болдын 70-аад оны судалгаанаас өөр судалгаа алга байгаа хийгээд энэ билингуал буюу тува урианхай, монгол хоёроор ярьдаг өвгөд насад бурхныхаа оронд халин одож өвлөж авсан хүн бараг үлдээгүй гэж хэлж болно. Чандмань-Өндөр, Цагаан-Үүр суманд 70, 80 гарсан хэдхэн хүн байх магадлалтай. Тэднээс хойч үеийн залуус сурвалжлан судалж, эрдмийн ажил хийх цаг одоо л байна.

### НОМ ЗҮЙ

1. Монголын нууц товчоо, УБ., 2011
2. Рашид-ад-дин, Судрын чуулган, Т.1, 1952
3. Хөвсгөлийн Урианхайн аман билиг, УБ., 2019
4. Ж.Цолоо “БНМАУ-ын нутгийн аялгуу”, УБ., 1976
5. (Фл-к!λ. }#ψ-φ#|-ωΠ□λ. Rtam din Hor-chos' byun)
1. Yongsiyebu Rincen. Les inscription inconnues sur pierre et les plaques d'or ornementees du harnais de Toyoucouc. “Central Asiatic Journal” vol 4, No 4, p 20

ШИНЭ ЗУУЧЛУУРЫН ОРЧИН ДАХЬ РЕНЧИНИЙ ЧОЙНОМЫН ЗОХИОЛ  
БҮТЭЭЛИЙН ДУНДАД УЛС ДАХЬ ДАМЖУУЛГЫН ХЭЛБЭРИЙН ХУВИРАЛТНаргил\*  
Л.Хасбаатар\*\*

## ХУРААНГУЙ

Монгол улсын төрийн соёрхолт яруу найрагч Ренчиний Чойномын зохиол бүтээл нь 1990 оноос эхлээд дундад улсад өргөнөөр дамжуулагдан, уншигчдын торгон мэлмийг мялаах болов. Шинэ зуучлуурын орчинд Р.Чойномын зохиол бүтээлийн дамжуулга нь уламжлат зуучлуурын хэвшлийг эвдэж, уншигчид найрагчийн зохиол бүтээлийг нэн хялбар, түргэн, амьд дүрслэг байдлаар хүлээн авах болсон байна. Тус өгүүлэлд шинэ зуучлуурын орчин дахь Р.Чойномын зохиол бүтээлийг дамжуулгын байдалд хуримтлал хийж, дамжигдан тархаж байх найраг шүлэг, бичлэг фильм, найрагчийн тухай илтгэл яриаг бүртгэн задлахаар дамжин шинэ зуучлуурын орчин дахь зохиол бүтээлийн дамжуулгын зам суваг өргөжлийг нотолж, мөн орчин дахь түүний зохиол бүтээлийн дамжуулгын хэлбэр нь цаг орон зайн хязгаарлалыг эвдсэн, тоочилсон, харилцан асуулцсан онцлогтой, мэдээлэгч нь олон янзат онцлогтой байдаг гэдгийг дүгнэн гаргажээ.

Түлхүүр үгс: *Р.Чойномын зохиол бүтээл, дамжуулгын хэлбэр, шинэ зуучлуур*

Р.Чойномын уран бүтээл нь 1991 оноос эхлэн дундад улсад цаасан хэлбэрээр дамжуулагдан тархаагдаад уншигчдын бахархлыг олж, сэтгэлийнх нь хөвчийг доргиулсан юм. Шинэ зуучлуурын орчинд Р.Чойном зохиол бүтээлийн дамжуулгын зам суваг нь өргөжиж, дамжуулгын мэргэжлийн шинийг үүдэн, зохиол бүтээлийн тархалт дамжуулгад нэн хялбар нөхцлийг бий болгосон байна. Шинэ зуучлуур newmedia-ийн ухагдахууныг 1967 онд АНУ-ын Колумбиягийн радио нэвтрүүлэг телевизийн сүлжээ CBS-ийн мэргэжлийн судалгааны газрын дарга Голдмарк Р.Goldmark хамгийн түрүүнд дурдан гаргасан байж, 1969 оноос эхлэн АНУ-д ихээр дэлгэрч эхэлжээ. Чинху их сургуулийн Шюн Чөнью профессорын дурдан гаргасан онолд: “Шинэ зуучлуур тоочилсон зуучлуур, эсвэл сүлжээний зуучлуур гэдэг нь даруй

\* Өвөр Монгол Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн 2022 оны магистрант. Судалгааны чиглэл: *Сонин мэдээ дамжуулгын ухаан*

\*\* Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн багш, доктор



## THE CULTURAL WAY

компьютерын мэдээ зангийг шийдвэрлэх мэргэжил ба цахим сүлжээний суурин дээрээс дамжуулах чадамжийг харуулах зуучлуурын ерөнхий нийлбэрийг заана” хэмээжээ.

Шинэ зуучлуурын орчинд Р.Чойномын бүтээл нь голдуу Эзэн эгшиг, Вичат тавцан, бичил бүлгэм, тик ток-ийн богино видео, вичатын видео дугаараар өргөн олон хүлээн авагчдад цацагдан хүрч, таашаал хүртээлийг нь олж байна. Дүрс шингээлт, үсэг бичиг, ая дуу, зураг сүүдрийн холилдсон хэлбэрээр дамжиж, зохиол бүтээлийг хүлээн авагчдад амьд дүрслэг хүргэж чадах болсон нь уламжлалт зуучлуурын хүрч чадашгүй өндөрц болох юм. Бид энэ удаагийн бүртгэл хуримтлалдаа шинэ зуучлуур дахь Р.Чойномын тухай илтгэл шүүмж 5, бичлэг мэдээлэл 15, ая дуу 7, яруу найраг 18 хувийг цуглуулжээ.

Нэг. Ренчиний Чойномын яруу найраг хийгээд ая дуу

Шинэ зуучлуурын цаг үе хүрч ирсэн нь утга зохиол урлагийн бүтээлийн зохион бүтээлт, тархалт, хадгалалт жич уламжлалт цөм маш их хэмжээний ач холбогдол гаргасан байдаг. Уламжлалт зуучлууртай харьцуулбал шинэ зуучлуурын тархалт хийгээд шинэчлэлтийн хурдац нь түргэн, уншигчдын Р.Чойномын зохиол бүтээлийг хүлээн авахад маш хялбар нөхцлөөр хангасан бөгөөд уншигчдын дур сонирхлыг ихээр татаж чаджээ.

1964 онд Мекалухан “Мэдээллийн хэрэгсэл бол хүний өргөтгөл мөн” гэсэн үзлийг дурдаж, аль ч мэдээллийн хэрэгсэл нь даруй хүний өргөтгөл буюу сонголт мөн. Үсэг бичиг ба хэвлэл дарамлалын мэдээллийн хэрэгсэл бол хүний харах чадварын өргөтгөл болно. Радио бол хүний сонсох чадварын өргөтгөл, телевиз бол хүний харах, сонсох, хүрэлцэх чадварын ерөнхийлсөн өргөтгөл болох юм. Мекалуханы энэ үзэл бол мэдээллийн хэрэгслийн хүн төрөлхтний сэрлийн төвд өнгө нөлөөг тодорхойлохын төлөө дурдсан байна. Иймээс түүний нүдээр үзвэл, мэдээллийн хэрэгсэл ба нийгмийн хөгжлийн түүх бол даруй хүний сэрлийн эрхтэн нийлэл-салал-дахин нийлэлд хүрэх түүх мөн<sup>1</sup>. Шинэ зуучлуур нь хүмүүсийн харахуйн сэрлийн захирлалыг хүлээх байдлыг хувируулж, харахуй ба сонсохуйн сэрлийг өргөтгөснөөр барахгүй, түүний тухайн талбарч чанар ба хүрэлцэхүй төрөгдөл нь хүн төрөлхтний хүрэлцүүрийн сэрлийг ч өргөтгөж чаджээ.

Шинэ зуучлуурын цаг үе нь Р.Чойномын бүтээл зөвхөн ном дэвтэр дээр хадгалагдаж байсан түүхийг бүрмөсөн эцэслэж, сүлжээ хийгээд тоочилсон мэргэжлийг ашигласнаар хадгаламжийн багтаамж их, уншихад хялбар, бүтээлийг хадгалах буюу уламжлан тархаахад маш амархан болсон байна. Шинэ зуучлуурын орчин дахь бүтээлийн дамжуулга нь сүлжээ тавцнаар суурь болгож, том дайт, үүлэн бодолт, зохиомол чадамж, тоочилсон

<sup>1</sup> Оюун. Мэдээлэл зүй. ӨМИСХХ., 2014, 4 сар





## THE CULTURAL WAY

чадамж, шилжих чадамж зэрэг өнөөгийн шинэ мэргэжлийн талын шинэ үүдэлтийг гаргасан байна. 2012.6 сард Эгшиг софт компьютерын хэрэглэгчидтэй залгаж, тухайн жилийн 11 сард android системд нийтлэгджээ. Эгшиг софт бол дундад улсын монголчуудын дунд нөлөөг тусгал ихтэй монгол хэлний хэрэглээний софт болно.

1. Эгшиг тавцнаар дамжуулагдаж байгаа яруу найраг: Миний шүтээн, Шүлэг минь, Залуу нас минь, Монгол бүсгүй, Үнэртэн оо тэргүүтний тухай, Миний үе, Диваажин, Миний нэр, Азийн тухай бардамнал, Охиндоо бичсэн захидал, Аав бид хоёр, Цөхрөл, Жаргал зовлон, Бага нас, Эхнэр, Ирээдүйд илгээх захидал, Гунигт сэтгэлийн дуу, Намрын тухай бодол зэрэг нь эгшиг тавцнаар дамжуулагдаж маш эрчимтэй сонирхогдож байгаа юм. Эдгээр шүлэг нь Сосорбарамын шингээлтээр дамжигдан өргөн олон сонсогчдод хүрч байна.

2. Эгшиг тавцнаар дамжуулагдаж байгаа дуу: Гунигт сэтгэлийн дуу, Нугасны дэгдээхэй олуулаа байлаа, Сайхан хүүхэнд хайртай, Цэнхэр шөнийн вальс, Дууг минь чи дуулаасай, Залуу нас зэрэг бүтээл багтана. Үүнд эгшиг тавцанд дамжуулагдаж байгаа Эхлэл гэдэг нь Сосорбарам Чойномын тухай танилцуулга хийгээд үнэлгээ болно. Шинэ зуучлуур нь уламжлалт зуучлуурын онцлогийг хадгалсан суурин дээр харилцан үйлдэлцэх чадвар хийгээд сураг зангийг тоочуулах чадвартай. Шинэ зуучлуурын орчинд Р.Чойномын бүтээлийн хүлээн авах хэлбэр маяг нь ганц текст унших ба дууг сонсож байснаасаа үсэг бичиг-зураг дүрс-дууны нийлмэл тэмдгийн текст уншлага болон хувирсан байна.

Тэмдгийн улирал хувьсал, текст хувирлын гаргаснаас үзвэл, утга зохиолын шинэ хэлбэр маяг нь зөвхөн Р.Чойномын бүтээлийн дамжуулгад үүсгэсэн хувирал биш харин зохиол бүтээлийн бүх хөгжилтөд ч хөшөө тэмдгийн ач холбогдолтой гэж магадлаж болох юм. Мэргэжлийн дэвшилтийн үүднээс үзвэл, шинэ зуучлуур нь зохиол бүтээлийн текст, зураг дүрс, тооны тэмдгийн уламжлалт суурь нөхцөл хийгээд тавцанг хангаж, уламжлалын агуулга нь хавтгай хэлбэрт байснаасаа биет хэлбэрт, тогтонгуй байдлаасаа хөдлөнгүй байдалд шилжихийг биелүүлж чадсан байна. Хураангуйлбал, мэргэжлийн дэвшилт ба тэмдгийн хувиралт нь Р.Чойномын бүтээлийг уламжлах, хүлээн авах явцад цөм алс хэтийн нөлөө үзүүлсэн байна. Шинэ зуучлуурын орчинд орсноос нааш анхаарлыг татахуйц үсэг зургийн хэлбэр бүхий зохиол бүтээл нь уншигчдын уншлагын урмыг хөгжөөж үүгээр зохиол бүтээлийн тархалтыг түлхэн ахиулж, Р.Чойномын бүтээлийн шинэ зуучлуурын доторх зохих орон зайг байгуулсан байна.

Хоёр. Р.Чойномын зохиол бүтээлийн бичлэг мэдээлэл

Шинэ зуучлуур бол уламжлалт зуучлууртай харьцуулж хэлсэн ухагдахуун байж, сонин сэтгүүл, радио нэвтрүүлэг, телевиз зэрэг уламжлалт



## THE CULTURAL WAY

зуучлуурын хожмын хөгжлийн шинэ мэдээллийн хэлбэр болно. Шинэ зуучлуурын ухагдахуунд улсын дотоод гадаадын тусгай мэргэжилтэд өөр өөрийн үзэлтэй байдаг. Эрт үед, олон улсын холбоот байгууллагын сурган хүмүүжил шинжлэх ухаан жич соёлын зохион байгуулалтаас шинэ зуучлуурт өгсөн томъёолол бол цахим зуучлуур болно. Үүнтэй адил шинж бүхий зуучлуур бол тоочилсон мэргэжлээр суурь болгож, сүлжээгээр ачаалбар болгон сураг занги дамжуулгын зуучлуур гэж заав. Шинэ зуучлуурын шинжлэх ухаанч томъёолол бол компьютерын чадвараар ачаалбар болгон мэдээ занги дамжуулах явдал мөн<sup>2</sup>.

Үүгээр үл барам уншигчид нь мэдээ зангийг уншихын хамт бас бүрэн бус мэдээнд засвар оруулан нөхвөрлөж болно. Уламжлалт зуучлуур нь сонин сэтгүүлээр голлож, дамжуулгын явц нь дан чиглэлт чанартай бөгөөд мэдээлэгч хийгээд хүлээн авагчийн байр суурь нь тодорхой бөгөөд тогтмол, хүлээн авагчид нь санаачилгагүй байрт оршдог юм. Шинэ зуучлуурын дамжуулгын явцын хос чиглэлт чанарын чангарал нь уламжлалт зуучлуурын дамжуулгын явцын хүлээн авагчийн санаачилгагүй байр суурийг ихээр сайжруулж, мэдээлэгч ба авагчийн үйлдэлцэх чанарыг нэмэгдүүлжээ.

web 1.0 – web 2.0, web 3.0 хүртэлх шилжилтээр Р.Чойномын зохиол бүтээлийн дамжуулга нь хүлээн авагчдад сэрлийн ерөнхийлөл олгож чадсаныг нотлохын үүднээс халууралтай дамжуулагдаж байгаа Р.Чойномын бүтээлийн бичлэг буюу мэдээллийн хамаа бүхий материалын хуримтлал хийж, вичатын энэ олон нийтийн тавцан ба видео дугааруудад шүүн байцаалт хийжээ.

1. “Чойном судлал” олон нийтийн тавцан, 2015.5.7-нд эхлэн нээгдэж, Р.Чойномын хамаа бүхий зохиол бүтээл, судалгааны ажлыг мэдээлдэг тавцан болно. Тус тавцан нь урьд хожид Гунигт сэтгэлийн дуу, Охиндоо бичсэн захидал, Монгол, Алтан тал, Шүлгийн тухай шүлэг, Хүн, Миний үгс, Миний монгол төрх, Архи, Залуу нас, Өнгөрсөн шөнө зүүдэнд яагаад ороо вэ, Миний нутгийн зун, Зүүд 1, Яруу найраг, Зүүд 2, Азийн магтаал, Миний шүтээн, Эхнэр зэрэг бүтээлийг дамжуулан хүргэжээ. Мөн найрагчийн зурсан зургийг тусгай нэгэн хугацаанд оруулан нийтэлсэн байна.

2. “Чойномын киноны тухай” – Чойном судлал, олон нийтийн тавцангаар 2017.6.19-нд нийтлэгдэж, Л.Хасбаатар доктор Чойномын киноны тухай тайлбарласан 9 минут 45 секундын фильмиг нийтэлжээ. 2023.10.31-ний өдөр хүртэл 285 хүн үзэн сонирхож, 9 хүнд таалагджээ.

3. “Зам” – Сэтгүүлч, олон нийтийн тавцан, тус хугацаа 2017.10.6-ны өдөр дуу шингээлтийн хэлбэрээр 5 минут 37 секунд нэвтрүүлжээ. Үүнд

<sup>2</sup>匡文波.《新媒体概论(第二版)》.[M]中国人民大学出版社.2015年,第3页。



## THE CULTURAL WAY

Сосорбарам Зам гэх найраглалыг уншсан байна. 2023.10.31-ний өдөр хүртэл 6233 хүн хүлээн авч, 71 хүнд таалагдсан байна.

4. “Жаргал зовлон-Чойном” – Сэтгүүлч, олон нийтийн тавцан, тус хугацаа 2018.2.6-ны өдөр видео шингээлтийн хэлбэрээр 6 минут 46 секунд нэвтрүүлжээ. Энэхүү видео шингээлтэд Сосорбарам Жаргал зовлон гэх найраглалыг уншсан байна. 2023.10.29-ний байдлаар 5812 хүн хүлээн авч, 143 хүнд таалагджээ.

5. “Ази тивд төрсөн” – Цайлган монгол хүн, олон нийтийн тавцан, тус хугацаа 2018.4.4-нд дуу шингээлтийн хэлбэрээр 6 минут 37 секунд нэвтрүүлжээ. 2023.10.31-ний байдлаар 2001 хүн хүлээн авч, 36 хүнд таалагдав.

6. “Амрагтаа бичсэн захиа” – Алгинч, олон нийтийн тавцан, тус хугацаанд шингээлт ба үсэг бичгийг хавсаргажээ. 2018.4.25-ны өдөр 7 минут 26 секунд нэвтрүүлсэн байна. 2023.10.31-ний байдлаар 973 хүн хүлээн авч, 19 хүнд таалагдсан байна. Дуу үсэг нийлсэн хэлбэрээр нийтэлж, сэрлийн ерөнхийллийн хувьд сонорын сэрэл ба харааны сэрлийн ерөнхийллийг биелүүлж чаджээ.

7. “Ану” тавцан Р.Чойномын өөрийнх нь дуу хоолойн шингээлтийг бүтнээр нь 22 минут 28 секундэд мэдээлсэн юм. Р.Чойномын тухай танилцуулгыг хятад хэлээр бичин нийтэлж, найрагчийн зураг сүүдрийг хавсаргасан байна. Сэрлийн ерөнхийллийн хувьд, сонорын сэрэл ба харааны сэрлийн ерөнхийллийг биелүүлжээ. Тус хугацаа нь 2018.8.16-ны өдөр нийтэлжээ. 2023.10.31-ний өдөр хүртэл 1.5 түм хүн хүлээн авч үзээд 120 хүнд таалагджээ.

8. “Маргааш” хэмээх шүлэг – Шүтээн монгол, олон нийтийн тавцан, Чойномын шүлэг гэсэн гарчгаар нийтлэн хуваалцав, тус хугацаа 2020.9.18-ны өдөр дуу шингээлтийн хэлбэрээр 6 минут 14 секунд нэвтрүүлэв. 2023.10.31-ний өдөр хүртэл 1226 хүн үзэж, 44 хүнд таалагдав.

9. “Р.Чойномын тухай ховор фильм” – Эгшиглэн олон нийтийн тавцан, тус хугацаа 2021.8.5-ны өдөр нийтэлж, Р.Чойномын гэх баримтад киног нэвтрүүлжээ. 2023.10.31-ний байдлаар 5556 хүн үзэж, 200 хүнд таалагдав.

10. “Жаргал зовлон – Чойном” – Монгол ардын дууны хураангуй, олон нийтийн тавцан, тус хугацаа 2021.8.29-ний өдөр видео шингээлтийн хэлбэрээр 6 минут 53 секунд нэвтрүүлэв. Үүнд видео шингээлтэд авсан үзэгдэл нь найрагчийн өөрийгөө зурсан зураг болон өөрийнх нь сүүдэр байж, дуу шингээлт нь Жаргал зовлон найраглалыг уншив, 2023.10.31-ний өдрийн байдлаар 1852 хүн үзэж, 75 хүнд таалагджээ.

11. “Р.Чойном” хэмээх баримтад кино – ХХ зууны хамгийн аугаа зохиолчийн нэгэн 2014” – Монгол сонгодог кино олон нийтийн тавцан, тус



## THE CULTURAL WAY

хугацаа 2021.9.14-ний өдөр видео шингээлтийн хэлбэр ба үсэг зураг хавсарган нийтэлжээ. Баримтад кино нь 37 минут, үсэг бичгийн хэлбэрээр найрагчийн намтрыг танилцуулж, өөрийнх нь хөрөг зургийг оруулсан байна. Сэрлийн ерөнхийллийн хувьд, сонорын сэрэл ба харааны сэрлийн ерөнхийллийг амжилттай биелүүлжээ. 2023.10.31-ний өдрийн байдлаар 2405 хүн үзэж, 19 хүнд таалагдав.

12. “Чойном ба Чулуунбаатар” – Ашид, соёл зуучлуурын тавцан, 2021.11.14-ний өдөр нийтэлсэн, агуулгын хувьд Л.Хасбаатар докторын яриа ба уянгалсан шүлэг болно. 2023.10.31-ний өдрийн байдлаар 1946 хүн үзэж, 47 хүнд таалагджээ.

13. “Үл мартахуйн дуу” – Соёмбо, нийтийн тавцан, 2021.12.18-ны өдөр Чойномын мэндэлсэн 85 жилд гэх гарчгаар Р.Чойномын бичсэн шүлэгт дөрөөлөн ая тааруулж дуучин Даваажав дуулсан, эсгэн урласан 5 минут 28 секундын фильмин хэсэглэлийг дагалдуулан нийтэлсэн байна. 2023.10.31-ний өдрийн байдлаар 2363 хүн үзэж, 70 хүнд таалагдав.

14. “Р.Чойномын уншсан шүлэг” – Монгол цэнгээний өртөө, олон нийтийн тавцан, тус хугацаа 2022.3.21-ний өдөр видео шингээлтийн хэлбэрээр 3 минут 33 секунд нийтлэв. Р.Чойномын өөрийнх нь дуу хоолойн шингээлтэд өөрөө уншсан шүлэг ба ард нь тоглосон гитарынх нь аяыг дагуулжээ. Тус хугацаанд зөвхөн шүлэг уншсан хэсгийг нь мэдээлсэн байна. 2023.10.31-ний өдөр хүртэл 1014 хүн хүлээн аван үзэж, 37 хүнд таалагджээ.

15. “Ашид” соёл зуучлуурын тавцан – “Р.Чойномын шүлгийн уянгалал” гэх тусгай булангаар Сосорбарамын уянгалуулсан Р.Чойномын бүтээлийг дамжуулав. Чойномын шүлгийн хураангуй 0001- 0018 хүртэл сонсож болдог байна. Шүлгийг нь жагсаавал: Монгол, Азийн бардамнал, Нүцгэн биеийг алдаршуулья, Амьдрал, Эрх чөлөө, Инээдэг хүмүүс, Миний шүтээн, Миний үе, Монгол бүсгүй, Уур минь хүрч байна, Эхнэр, Зам, Хүүр, Зүүд, Миний майгахан Дулмаа, Бага нас, Диваажин зэрэг багтжээ.

Шинэ зуучлуурын орчин дахь вичат тавцан нь Р.Чойномын бүтээлийн ачаалбар, тус тавцнаар дамжин зохиол бүтээлийн хамаа бүхий текст, дуу шингээлтийг хүлээн авагчдад дамжуулан хүргэж уламжлалт зуучлуурын хүлээн авагчдын хэрэгцээ шаардлагаар гол болгосон ажлын ойлгогдохууныг баримтлан, хүлээн авагчдын гоо сайхны хэрэгцээ шаардлага, үйлдлийн хэрэгцээ шаардлага, мэдээ зангийн агуулгын хэрэгцээ шаардлагыг нэн илүү чухалчлах болсон байна. Шинэ зуучлуурын орчин дахь дамжуулга нь уламжлалт зуучлуурын дамжуулгатай харьцуулбал нэн гүнзгий нийлэх хүчийг илрүүлж, мэдээлэгч хийгээд хүлээн авагчдын хоорондох завсардал ба хязгаарлалыг арилгаж чадсан бөгөөд уламжлах арга замын хувиралтыг биелүүлжээ.



## THE CULTURAL WAY

Шинэ зуучлуурын орчин дахь Р.Чойномын зохиол бүтээл нь агуулгын хувьд хуудас хэмжээгээр богино авсаархан, одоогийн бачим яаруу амьдралын айзам цохилгод хүмүүс хэсэг бусад цагаараа уншин сонирхоход нөхцөл үүдэж чадсан байна. Шинэ зуучлуурын орчин дахь Р.Чойномын зохиол бүтээлийн дамжуулгын хурдацын хувьд түргэн болжээ. Үүнийг хоёр талд салган тайлбарлаж болно. Нэг нь тархаалтын хурдац нь түргэн болсныг зааж, нөгөө нь дамжуулгын хурдац маш хурднаас болж хүлээн авагчдын гаргасан буцалтын хурдац нь түргэн болж, үг үлдээх буюу таашаах хэлбэрээр зохиол бүтээлийн тухай үзэл бодлоо илрүүлж дийлэх болсон байна. Энэхүү буцалтын хурдац нь уламжлалт зуучлууртай адилтгажгүй юм.

Уншлага бол хүмүүсийн тэмдгээс утга агуулга олох нэг зүйлийн нийгмийн үйлдийн ажиллагаа мөн, бас ч мэдээ зангийн мэдлэгийг үйлдвэрлэгч ба хүлээн авагчийн текстэд түшиглэн биелүүлэх нэг зүйлийн мэдээ зангийн мэдлэгийг дамжуулах явц мөн<sup>3</sup>. Дамжуулгын ухааны үүднээс уншлагад томъёолол өгөхөд хүрвэл, даруй мэдээ зангийг амжилттай дамжуулж чадсан байвал уншлагын зорилгодоо хүрсэн байдаг. Шинэ зуучлуурын орчинд хүмүүсийн амьдралын айзам цохилго түргэн болохыг дагалдан, хүмүүсийн сул сэлгүү цаг нь ч хэсэгчиж ирснээс төдий арвин цаг гарган уншлагад зарцуулахын аргагүй болсон байна. Уншигчид нь Р.Чойномын зохиол бүтээлийг сонирхох үедээ өөрийн ажил амьдралын хэсэг бусад цагаа ашиглах болжээ.

Шинэ зуучлуур нь Р.Чойномын бүтээлийг дамжуулан тархаахдаа бүх зохиолыг нь бүгдийг дамжуулсан биш харин уншигчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх үүднээс бүтээлийг нь хэсэглэл болгон нийтэлж мэдээлдэг байна. Угийн дамжуулгын мэргэжлийн хувьсалтын жишээнээс харвал, нэгэн шинэ зуучлуурын бий болох нь үйлдвэрлэлийн хүчний шинэчлэлтийг харуулж, угийн байсан дамжуулгын мэргэжлийг орлон угийн дамжуулгын мэргэжлийн хэрэглээний үнэ цэн нь буурдаг юм. Жишээ нь үсэг бичиг бий болсон нь зохиол бүтээлийн аман дамжуулгыг орлосон, хэвлэлийн мэргэжлийн бий болсон нь гар бичмэл дамжуулгыг орлосон, телевиз бий болсон нь радиог орлосон байна. Өнөөдөр болоход шинэ зуучлуур нь бий болсон боловч уламжлалт зуучлуурыг бүрмөсөн орлосон биш, үүний шинэ гэж хэлж байгаа нь урьдах зуучлуурын хөгжил хийгээд эдүгээчлэлт болно. Нийгэм ба мэргэжлийн хөгжлийг дагуулдаг дамжуулгын мэргэжил нь харилцан ярилцаж, Р.Чойномын зохиол бүтээл нь зөвхөн номын тавиур дээр илэрдэг байсан цаг үеийг эцэслүүлж, уншигчид нь цаг газар орны хязгаарлалыг тэвчиж чөлөөтэйгөөр хүлээн авдаг болсон байна.

Гурав. Р.Чойномын тухай илтгэл шүүмж

<sup>3</sup>王素芳.网络阅读的发展现状和前景探析[J].图书与情报, 2004 (3), 91-93 页.



## THE CULTURAL WAY

АНУ-ын online сэтгүүлд шинэ зуучлуурт ухагдахуун өгөхдөө: “Бүх хүмүүсээс бүх хүмүүст явуулсан дамжуулгын ажиллагаа communications for all by all гэж дурджээ. Шинэ зуучлуурын цаг үед хүн болгон хүлээн авагч мөртөө мэдээлэгч болж болно. Уламжлалт зуучлуур нь хүлээн авагч хийгээд мэдээлэгч гэж тодорхой хоёр хэсэгт хуваасантай адилгүй болжээ. Уламжлалт зуучлуурын удаашрах чанар, дам чанар зэрэг хүрэлцэхгүй талыг шинэ зуучлуур яг сайхан нөхвөрлөсөн байдаг. Үүгээр дамжин Р.Чойномын зохиол бүтээл нь шинэ зуучлуурын орчин дахь дамжуулгын хэлбэрийн хувиралт хийгээд дамжуулгын зам сувгийн өргөжлийг биелүүлж чаджээ.

Зуучлуурын мэргэжлийн дэвшилт нь шилжмэл интер сүлжээний цаг үед орж, 5G мэргэжил тасралтгүй түгээмэлжиж байгаа тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгээд дэвшилт нь зохиол бүтээлийн дамжуулгын хувиралтыг гаргаж байна. Шинэ зуучлуурт дамжуулагдаж байх хамаа бүхий зохиол бүтээлийг хуримтлуулан бүртгэхдээ вичат тавцангийн бүх нийтлэгдсэн мэдээлэл жич холбоо сүлжээнд бичигдсэн шүүмжид шүүн задалсан юм. Үргэжлүүлэн нарийн дэлгэрэнгүй өгүүлье:

1. “Чойном ба ард түмэн” – Mongolian brand олон нийтийн тавцан, тус сүлжээг Б.Цэцэнт 2014.4.29-ний өдөр бичиж, тус олон нийтийн тавцан 2021.5.15-ны өдөр зураг дүрс хэлбэрээр нийтэлжээ (6 хуудас зураг). 2023.10.31-ний өдрийн байдлаар 676 хүн хүлээн авч, 11 хүнд таалагджээ.

2. “Монгол улсын орчин үеийн яруу найраг дахь магтан дуулагч Ц.Гайтав, шүүмжлэн няцаагч Р.Чойном – Л.Хасбаатар” – Чойном судлал, олон нийтийн тавцан, 2017.11.16-нд явагдаж, хоёр хугацаа хуваан мэдээлжээ. Дуу шингээлт ба зураг сүүдрийг хавсаргасан байна. 2023.10.31-ний байдлаар 627 хүн хүлээн авч, 13 хүнд таалагдав.

3. “Монгол улсад үүсгэсэн Сэхээтний төөрөгдөл хийгээд Б.Ренчин – Л.Хасбаатар” – Чойном судлал, олон нийтийн тавцан, 2017.5.10-нд нийтэлж, 2023.10.31-ний байдлаар 94 хүн үзэж, 2 хүнд таалагджээ.

4. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуйг уншаад” – холбоо сүлжээ, тус шүүмжийг Гүйлс 2018.2.4-ний өдөр бичин нийтэлжээ. Нийт уншигдсан тоо 641.

5. “Нэгэн найрагчийн захидал чимээнээс монгол улсын уран зохиолын тухай өгүүлэх нь –Л.Хасбаатар” – Алгинч олон нийтийн тавцан, 2021.5.27-ны өдөр явагдаж, дууны шингээлт ба зураг сүүдрийг хангаж, Чойномыг хамгийн ойрхноос ойлгуулжээ. 2023.10.31-ний өдөр болоход 1283 хүн хүлээн авч үзэн, 34 хүнд таалагдсан байна.

Шинэ зуучлуур нь Р.Чойномын дамжуулгын орчныг өргөтгөжээ. Шинэ зуучлуурын орчинд Р.Чойномын зохиол бүтээлийн дамжуулга нь



## THE CULTURAL WAY

тоочилсон онцлогтой, шинэ зуучлуурын мэргэжлийг ашиглан, үсэг бичиг, дуу дүрс, бичлэг фильм зэрэг олон төрлийн мэргэжлийг уялдуулан ашиглаад дамжуулгын үр бүтээмжийг дээшлүүлэхийн хамт хүлээн авагчдад хялбар өгүүлж чадсан байна. Өнөөдрийн айзам цохилго маш түргэн амьдралын орчин ахуйд хүмүүсийн цаг нь хэсэг бусад болсон байдаг. Иймэрхүү амьдралын хэмнэл цохилго нь шинэ зуучлуурын орчин дахь Р.Чойномын зохиол бүтээлийн дамжуулгад нөхцөл үүсгэж өгчээ. Үүнээс шинэ зуучлуурын орчин дахь Р.Чойномын зохиол бүтээлийн дамжуулгын онцлогийг туршин дүгнэвэл:

Нэгд, Дамжуулгын дундах Р.Чойномын бүтээл нь хэсэгчилсэн (碎片化 fragmentation) онцлогтой. Хэсэгчлэх гэдэг нь угаасаа бүрэн бүтэн байсан хэрэг бодис нь дотоод хүч буюу гадаад хүчний үйлчлэлийг хүртээсний улмаас маш олон жижиг хэсэг болж нарийн хуваагдахыг хэлж байна<sup>4</sup>. Уламжлалт зуучлуурын дамжуулга нь нэг зохиол бүтээлийг бүтнээр нь хүлээн авагчдад хүргэх онцлогтой юм. Шинэ зуучлуурын орчин дахь дамжуулга нь фильм бичлэгийн хэлбэрээр дамжуулвал, их бага хэмжээний хязгаарлалаас болж богино авсаархан байх шаардлагатай байдаг. Мөн хүлээн авагчид нь одоогоор төдий урт цагийг гаргаж, нэгэн бүтээлийг сонирхох дуршил байхгүйгээс шалтгаалж хэтэрхий урт сунжирсан бүтээлийг дамжуулдаггүй онцлогтой, зохиол бүтээлийг нь хэсэг хуваан дамжуулахыг анхаардаг болсон байна.

Шинэ зуучлуурын орчинд зохиол бүтээлийг хэсэгчлэн дамжуулж байгаа нь хэрэглэгчдийн өөрийнх нь хөөцөлдөл, хүсэл шаардлагыг аядан дагаж, хэрэглэгчдийн бүлэглэл цогцыг нарийн оновчтой хуваахаар дамжуулан тэдэнд жагсаалын чанартай, өвөрмөц чанартайгаар уламжлан тархааж, адил бус хэрэглэгчдийн өөрийн биедээ тохирох арга маягаар зохиол бүтээлийг дамжуулан хүргэхийг үнэнхүү батална<sup>5</sup>. Шинэ зуучлуурын орчинд, зохиол бүтээл нь хэсэг бусгаар уламжлагдах нь уламжлалт зуучлуурын орчин дахь албадлагын чанартай хүлээн сонсохтой адилгүй, хүлээн авагч даруй уншигчдын зохиол бүтээлийг сонирхох дадалтай нь нийцэж, түүнийг биеч хүсэлд амьдлаг бөгөөд хялбар дөт арга маягаар тархай бутархайгаар хүлээн авч чадах болгожээ.

Хоёрт, Мэдээлэгч нь олон янзат онцлогтой. Уламжлалт зуучлуурын цаг үед мэдээлэгчийн байр суурь маш өндөр бөгөөд хүлээн авагч ба мэдээлэгч нь ил тодорхой зааг шугамтай байдаг. Шинэ зуучлуурын цаг үед энэхүү байдлыг эвдэж, ямар ч гэсэн цөм мэдээлэгч болж болохыг биелүүлсэн байна. Мэдээлэгч нь хүлээн авагч, хүлээн авагч нь мэдээлэгч болж чадсан байна. Шинэ зуучлуурын цаг үед, мэргэжлийн дэвшилт болон хөгжил нь хийсвэр орон зай болон бодит нийгмийг харилцан асуулцуулж, мэдээ занги нийтлэх нь тусгай зуучлуурын байгууламжийн “онц эрх” биш болгож, мэдээ занги

<sup>4</sup> 吴楠. 智媒体环境下新闻产品的碎片化传播与智慧引导[J]. 南阳理工学院学报, 2021, 13 (05)

<sup>5</sup> 吴楠. 智媒体环境下新闻产品的碎片化传播与智慧引导[J]. 南阳理工学院学报, 2021, 13 (05)





## THE CULTURAL WAY

дамжуулах арга хэлбэрт ч хувиралт гарч, угийн олон нийтийн дамжуулга байснаас бий болсон хүмүүсийн бий болсон хүмүүст дамжуулах болгон хувирган, голчилсон чанар, дан чиглэлт чанарыг үгүйсгэх хандаш илэрсэн байна<sup>6</sup>.

Гуравт, Дамжуулгын зам суваг нь асуулцсан онцлогтой. Уламжлалт зуучлуурын үед, зөвхөн үсэг бичгийн хэлбэрээр Р.Чойномын зохиол бүтээлийг сонирхдог байсан бол шинэ зуучлуурын цаг үед үсэг, зураг, дуу, дүрс шингээлт цөм нэг л газарт асуулцсан хэлбэр бүхий дамжуулгын онцлогтой юм. Уламжлан тархаах хэлбэрийн хувьсгал нь цул мэргэжлийн давхаргын ачаалбарын солигдол төдий биш. Үүний зэрэгт бас хүмүүсийн сэтгэхүйн хэв загвар болон авах хэлбэрийг дахин бүтээж байдаг<sup>7</sup>. Шинэ зуучлуурын цаг үе нь газар орны хязгаарлал чанарыг гүйцэд үгүйсгэсэн бөгөөд хүлээн авагчдад Р.Чойномын зохиол бүтээлийг нэн амьдлаг, нэн гүн суудалтай хүргэж чадах болгосон байна.

### ДҮГНЭЛТ

Шинэ зуучлуур нь хүмүүсийн амьдралын хэлбэр маяг жич үзэл танилтын хэлбэр маягийг хувирган өөрчилсөн төдийгүй хүмүүсийн сэтгэхүйн хэлбэрт ч хувиралт гаргаж чадсан байна. Р.Чойномын зохиол бүтээл нь шинэ зуучлуурын орчин нөхцөлд шинэ нэгэн дамжуулгын сувгийг хайн олжээ. Уламжлалт зуучлуурын үеийн найрагчийн зохиол бүтээлийн дамжуулгатай харьцуулбал шинэ зуучлуурын орчин дахь найрагчийн зохиол бүтээлийн дамжуулга нь нэн олон янзат шинж ба үйлдэлцэлт шинжтэй, зохиол бүтээлийн тархалт дамжуулгад маш сайн нөхцөл бололцоог бий болгож чадсан байна. Шинэ зуучлуурын орчинд найрагчийн зохиол бүтээлийн дамжуулга нь өнгөрсөн үеийн уламжлалт зуучлуурын хэвшлийг эвдэж, нэн хялбар, нэн түргэн, нэн амьд дүрслэгээр зохиол бүтээлийг хүлээн авах болгожээ. Дамжуулгын хэлбэр нь цаг орон зайн хязгаарлалыг эвдсэн, тоочилсон, харилцан асуулцсан маягийн дамжуулгын хэлбэр тийш амжилттай хувирсан гэдгийг дүгнэн гаргажээ.

<sup>6</sup> 谢妍.新媒体环境下反转新闻的成因研究[J].传播与版权,2020(05):14-16.

<sup>7</sup> 陈伟军.媒介融合环境中的阅读文化转型[J].国际新闻界,2012(4):90-94.





# THE CULTURAL WAY

## ABSTRACT

In the early 1990s, the works of Renqin Quenuomu, the winner of the Mongolian National Prize, were favored and sought after by the readers in China. With the development and popularization of new media, his works have evolved from paper communication to network communication, covering a wide range. Therefore, Renqin Que Nuomu's works have more readers in the new media era, and his works touch the heartstrings of the readers. In the new media environment, Renqin Que Nuomu's works communication mode breaks the traditional media communication mode, and readers can accept the works more conveniently, quickly and vividly. Based on the statistics and analysis of Renqin Quenuomu's works in the new media environment, this paper discusses the dissemination of works under the background of the development of new media, and demonstrates that the expansion of communication channels in the new media era and the dissemination of Renqin Quenuomu's works in the new media environment have the characteristics of breaking the time and space constraints, digitalization and mutual integration.

Keywords: *Rinqin Choinom 's works, Communication channels, New media*

## НОМ ЗҮЙ

1. Оюун. Мэдээлэл зүй. ӨМИСХХ., 2014
2. 匡文波.《新媒体概论(第二版)》.[M]中国人民大学出版社, 2015 年
3. 王素芳.网络阅读的发展现状和前景探析[J].图书与情报, 2004 年
4. 吴楠.智媒体环境下新闻产品的碎片化传播与智慧引导[J].南阳理工学院学报, 2021 年
5. 谢妍.新媒体环境下反转新闻的成因研究[J].传播与版权, 2020 年
6. 陈伟军.媒介融合环境中的阅读文化转型[J].国际新闻界, 2012 年



## 17 ДУГААР ЗУУНЫ СУРВАЛЖ БИЧИГ ДЭХ ОН САРЫГ ИЛТГЭХ АРГА

Мишээл\*

## ХУРААНГУЙ

Монгол үндэстэн бол урт удаан соёлын боловсон түүхтэй үндэстэн болно. Монголчууд эрт дээр үеэсээ нүүдлийн амьдралын явц дундаа байгаль дэлхийгээ шинжин, тэнгэр од эрхэсийг судалж, орчин тойрондоо зохицон аж төрсөөр ирэв. Ийнхүү өөрийн судалж шинжлэн илрүүлсэн байгаль дэлхийн жам хууль, цаг улирлын онцлог шинжийг ажиглаж, он жил сар өдрийг илтгэх нэр буюу аргыг тогтоосон байдаг. Бидний өвөг дээдэс үсэг бичигтэй болсон цагаас эхлэн өөрийн үндэстнийхээ түүх соёлыг тэмдэглэн үлдээсээр ирсэн бөгөөд эдгээр сурвалж бичгүүд нь өнгөрсний түүх, тухайн үеийн монгол амьдрал соёл зэрэг аливаа зүйлсийг судлахад хязгааргүй их үнэ цэнтэй. Тус өгүүлэлд бид голдуу 17 дугаар зууны үеийн “Хаадын үндсэн хураангуй Алтан товч”, “Асрагч нэртийн түүх”, “Эртний монголын хаадын үндэсний Их шар тууж”, “Хаадын үндэсний Эрдэнийн товч”, “Эртний хаадын үндэслэсэн төрт ёсны зохиолыг хураасан Алтан товч хэмээх оршвой” гэх таван сурвалж бичгээр материал болгож, түүнд илэрсэн он, жил ба сарыг илтгэх аргын тухай судалгаа хийв.

Түлхүүр үгс: *17 дугаар зууны сурвалж бичиг, он ба жилийг илтгэх арга, сарыг илтгэх арга*

Аль нэгэн цаг үе дэх бүтээлд илэрч байгаа үг хэл нь тухайн цаг үеийнхээ улс төр аж ахуй, соёл боловсрол зэрэг түүхийн нарийн тусгал болдог. Сурвалж бичигт хэрэглэсэн товч хэдэн үгээс бид тухайн үеийн бүх үндэстний харилцаа, соёлын солилцооны байдлыг үзэж гарч болно. Тухайн үед монголчууд он сарыг хэрхэн илтгэж байсан, монгол үндэстний зурхайн ухаан хэр зэрэг хөгжлөө олсон жич бусад үндэстний зурхайн ухааны соёл нь монголчуудын дунд хэдий хэр нэвчин орж байсныг судлан, үүний улмаас түүхэн үйл явдалд нэн илүү гүн ойлголттой болох хэрэгтэй юм.

Нэг. Он ба жилийн тухай

17 дугаар зууны сурвалж бичигт “он” болон “жил” гэх хоёр үгийг дундад эртний монгол хэлний тулгуур бичигтэй адил мөн хамтаар хэрэглэж

\* Өвөр Монгол Багшийн Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн 2023 оны магистрант.

*Судалгааны чиглэл: Дундад улсын үг хэл утга зохиолын мэргэжлийн харьцуулсан утга зохиол хийгээд дэлхийн утга зохиол*



## THE CULTURAL WAY

байв. Үүнд он ба жил гэх хоёр үгийн хэрэглэгдэх арга жич илтгэх зүйлс нь зөрөөтэй байсан бөгөөд одоогийн илтгэх аргатай ч бага бус зөрөө оршиж байна. Доор бид 17 дугаар зууны сурвалж бичигт илэрсэн он ба жил гэх үгийн илтгэх аргыг тус бүр танилцуулж, тэдний ялгаа зөрөөг товч дурдья.

*(Нэг). “Он” гэх үгийн хэрэглэгдэх байдал*

17 дугаар зуунд бичигдсэн монголын таван их сурвалж бичгийг шүүж үзвэл, он гэх үгийг хэрэглэсэн давтамж нь харьцангуй цөөн байна. Сурвалж бичиг дэх “он”-ы илрэх байдлыг бид доорх мэт хэдэн талаас нь хураангуйлан үзэж болно.

1. Он гэх үгийг араб тооны дараа хэрэглэж, 2021 он гэх зэргээр ямар нэгэн он тооллыг илтгэх биш, харин үйл хэргийн үргэлжилсэн хугацааг илтгэхэд хэрэглэж байна.

Есөн он болж тавин дөрвөн насан дур аа Чин Енгү нэрт хотод тэнгэр болов. Хураангуй Алтан товч (35b12)

Чингис хаан Жамуха хоёр нэгэн он хамт явав. Асрагч нэртийн түүх (10b23)

Тэр хан Хузун хааны орныг ану булааж аван арван найман он болохуяа хан урагт Гэлү Гүнбү хэмээх хаан болж ... Эрдэнийн товч (33r31) гэх мэт. Ингэж хэрэглэгдэх арга нь дундад зууны монгол хэлний тулгуур бичигтэй адил байсан ч одоо үеэс илт ялгаатай болсон байна. Бид дундад эртний монгол сурвалж бичигт оны хэрэглэгдсэн байдлаас хоёр товч жишээ дурдвал: Долоон ууд явж – Монголын нууц товчоон 264. Хоёр зуун оны урьд Ажасири гэх мэт<sup>1</sup>, дээрх МНТ-д гарсан жишээнд долоо гэх үгийн дараа “ууд” гэж оны олон тооны дагавар залгаж тодотгол тодотгуулагчийн олон тооны зохицлыг журамлажээ. Дундад зууны монгол хэлэнд иймэрхүү зохицол маш олон тохиолдоно. Гэвч энэхүү үзэгдэл нь 17 дугаар зууны монгол хэлэнд харагдахгүй болжээ. Дээр жишээн дэх байдалтай харьцуулбал өнөөгийн монгол хэлэнд үргэлжилсэн хугацааг илтгэхэд “жил” гэх үгийг хэрэглэдэг. Жишээ нь “хоёр зуун жилийн өмнө” гэх мэт, энэ нь аль цаг үеэс эхлэн хувиралт гарсан тухай бодитой судалгаа хийгдээгүй байсаар байна.

2. Тухайн жилийн дотор үүссэн учир явдлыг дурдан тоочиход “он” гэх үгийг хэрэглэж байна. Жишээ нь: Түүний хойно мөн он хонин жил Хүлэг хаан хорин дөрвөн насандаа их хан ор суув – Хураангуй Алтан товч (35b10). Түүний хойно мөн он Гэгээн хаан мичин жил арван найман насандаа Дайдуд их ор суув – Хураангуй Алтан товч (36b27). Тус илтгэх арга нь мөн л дээрхтэй адил 13-16 дугаар зуун хүртэл адил бусаар хэрэглэгдэж байсан ч өнөөгийн

<sup>1</sup> Хасбагана. Дундад зууны монгол хэлний судлал. ӨМСХХХ., 1996 т 444



## THE CULTURAL WAY

монгол хэлэнд хэрэглэхгүй болжээ. Тухайлбал, Монголын нууц товчоонд “тэр он гарав 26”, “он халуун болов 259” гэх зэргээр хэрэглэгдэж буй. Өнөөгийн монгол хэлэнд иймэрхүү утгыг энэ жил, тус жил гэж жилээр илтгэх болсон байна.

3. Он гэх үгийг хаадын нэрийн он тоололд хэрэглэсэн байдал харагдаж байгаа боловч сурвалж бичигт тун цөөн илэрнэ. Жишээ нь: Тэднээс Сэцэн хунтайжид Луньчин хааны дөрөвдүгээр он шинэ хонин жил их төрд хүчээ өгөв – Эрдэнийн товч (79v8) гэх мэт. Үүнд Луньчин хаан бол Мин му зун хү зай жиэ болно. Луньчин-ий дөрөвдүгээр он гэдэг нь НТ 1570 оныг илтгэнэ. Ингэж хэрэглэх арга нь 14 дүгээр зууны үеийн монгол сурвалж бичигт илэрдэг онцлогтой адил байна. Жишээ нь: “(Жи шүнь 至順) хоёрдугаар он, Юань тун (元统) гурван он” гэх<sup>2</sup>, үүнд Жи шүнь гэдэг нь Юань улсын үеийн Юань вэнь зун хаан Төгстөмөрийн оны цол байж, Жи шүнь хоёрдугаар он гэдэг нь НТ 1331 оныг заана. Энэхүү илтгэх арга илэрсэн нь Хубилай сэцэн хаан тухайн үед хятад эрдэмтдийг хүндэтгэн хэрэглэж хятад соёлын нөлөөг их хүртсэнээс болсон байна.

*(Хоёр) Жил гэх үгийн хэрэглэгдэх байдал*

17 дугаар зууны монгол сурвалж бичигт “жил” гэх үгийн хэрэглэгдсэн хүрээ хэмжээ нь маш өргөн байна.

1. Арван хоёр жилтэй холбож он жилийг тэмдэглэхэд хэрэглэгдэх байдал олон илэрнэ. Тухайлбал, Мичин жилд дөчин долоон насандаа Дайдуд тэнгэр болов – Хураангуй алтан товч (36a22). Тулуй эзний их хөвгүүн Гэгээн хааныг гахай жил Хөдөө аралнаа их ор суулгав – Асрагч нэргийн түүх (25a6) гэх мэт. Энэ нь дундад зууны монгол хэлний сурвалж бичиг дэх хэрэглэгдэх байдалтай адил байна. Жишээ нь: Монголын нууц товчоонд “Хулгана жил 193, 197, 269, 282”, “Тахиа жил 141, 264” гэх зэрэг. Үүгээр үл барам 12 жилийн тооллыг ганц монгол үндэстэн хэрэглэсээр ирсэн биш, дэлхийн олон үндэстэн цөм энэхүү аргыг хэрэглэсээр иржээ. Тухайлбал, хятад, төвөд, япон, солонгос, вьетнам, камбож, малайз зэрэг зүүн Азийн улс, алтай хэлний системийн казах, монгол, орцон, эвэнк нар цөм арван жилийн тооллыг хэрэглэдэг<sup>3</sup>. Энэхүү тооллын үүслийн тухай олон эрдэмтэд урт хугацаа сониучлан судалсаар ирсэн ч тус тооллын үүсэл чухам хэзээнээс эхэлсэн нь цаашид судлууштай асуудал юм.

2. Арван хоёр жилтнийг жилтэй холбож хэрэглэхдээ төвөд зурхайн таван махбодоор он тооллыг илтгэх аргыг хэрэглэсэн байдаг. Жишээлбэл, Усан барс жилд хорин нэгэн насанд нь огторгуй газраа хүч нэмэгдэж

<sup>2</sup> Хасбагана. Дундад зууны монгол хэлний судлал. ӨМСХХХ., 1996 т 444

<sup>3</sup> Боржгин, Ванчиг. Монголчуудын шинжлэх ухаан техникийн түүх-од зурхайн ухаан. ӨМАХХ., 2008 т 88



## THE CULTURAL WAY

Чингисийг хаан болгов – Асрагч нэртийн түүх (12a18). Арван сар болоод шороо үхэр жил далай лам хувилж төрөв – Алтан товч (17a5). Төмөр туулай жилд Түмэдийн хаан золгохоор ирэв – Алтан товч (172a6). Эр гал бичин жилд Чингис хааны байгуулсан их төрийг алдав – Асрагч нэртийн түүх (27a23). Эр гал бичин жил – Шар тууж гэх мэт. Иймэрхүү арга нь дундад зууны монгол хэлний материалд харагдсангүй бөгөөд одоо ч ингэж хэрэглэгдэхээ больжээ. Энэ бол таван махбод хийгээд эр эмийг өнгөтэй харгалзуулан хэрэглэхээс бий болжээ. Тухайлбал, монгол зурхайн таван өнгийн эш эрхтэн нь тус тусдаа төвөд зурхайн таван махбодтой харгалзаж байдаг. Даруй “хөх, хөхөгчин” өнгө нь модтой, “улаан, улаагчин” өнгө нь галтай, “шар шарагчин” өнгө нь шороотой, “хар, харагчин” өнгө нь устай, “цагаан, цагаагчин” өнгө нь төмөртэй тус тус харгалзана. Үүнээс гадна монгол зурхай дахь арга билиг таван өнгийн “хөх, улаан, шар, хар, цагаан” нь төвөд зурхайн “эр” эрхтэнтэй харгалзаж, “хөхөгчин, улаагчин, шарагчин, харагчин, цагаагчин” нь “эм” эрхтэнтэй харгалзаж байдаг. Иймээс эр гал мичин жил гэх нь даруй “улаан мичин жил”-тэй харгалздаг.

3. Арван хоёр жилтнийг жилтэй холбож хэрэглэхдээ монгол зурхайн арга билиг өнгийн эш эрхтэнтэй холбож хэрэглэх үзэгдэл буй. Энэ нь тоолох арга барилаараа өнөөгийн билгийн тоололтой бүрмөсөн адил байна. Тухайлбал, Сод Чингис хаан хар могой жилд буюу дөчин таван настайдаа ... хаан их ор суув – Хураангуй алтан товч (15a11). Улаан морь жилд Түмэнхэн авай төрөв – Асрагч нэртийн түүх (48a22). Хөхөгчин могой жилд Мингал авайг төрөв – Асрагч нэртийн түүх (48a21) гэх мэт. Монголчууд хөх, улаан, шар, хар, цагаан таван өнгө дээрээ “-гчин” дагавар нэмж хөхөгчин, улаагчин, шарагчин, харагчин, цагаагчин зэргээр хамт арван өнгө болгон хувиргаж, дахин арван хоёр жилтэйгээ улируулан хэрэглэнэ. Үүнд –гчин дагавартай өнгө нь үхэр, туулай мэтийн хос тоонд таарах бөгөөд хөх хулгана жилээс эргэн орчин дахин хөх хулгана жил болтол яг жаран жилийг өнгөрөөнө. Монголчуудын энэхүү –гчин гэх дагавартай өнгө нь үхэр, туулай, могой зэрэгтэй харгалздаг ёсыг журамласангүй үзэгдэл бас оршно. Жишээ нь Улаан үхэр жил ... тэнгэр болсон ажгуу – Алтан хааны тууж (5a19). Цагаан туулай жил ... аялж – Алтан хааны тууж (6a1) гэх мэт. Тус зүйлийн илтгэх арга нь мөн ч нэгэн судлууштай асуудал болно.

4. Тухайн үеийн сурвалж бичигт арван хоёр жилтнийг жилтэй холбож хэрэглэхдээ хятад тооллоор тодотгож илтгэх нь маш илтэд нэгэн онцлог болно. Жишээлбэл, Сод Чингис хаан хар могой жилд буюу дөчин таван насандаа бин барс жилд тэргүүнээ ... хаан их ор суув – Хураангуй алтан товч (15a11). Энэ мэт шажин урьд дэлгэрсний эцсийн шинь тахиа жилийн хойд, шим нохой жилдээ тин гахай жил хүртэл найман зургаан жил болсон хойно шажин хойд дэлгэрсэн нь, жич хойно өөр нэгэн, вү хулгана жилээс тэргүүлжүхүй – Эрдэнийн товч (24r20 – 24r25) гэх мэт. Эрдэнийн товчид “ка, и, бин, тин, вү,



## THE CULTURAL WAY

гө, гөн, шинь, шим, гүй” гэх арван нэрс бүгдээрээ илэрсэн байна. Энэ нь даруй хятад хэлний “甲, 乙, 丙, 丁, 戊, 己, 庚, 辛, 壬, 癸” болно. Үүнд ка нь эр модтой, и нь эм модтой, бин нь эр галтай, тин нь эм галтай, вү нь эр шороотой, гө нь эм шороотой, гөн нь эр төмөртэй, шинь нь эм төмөртэй, шим нь эр устай, гүй нь эм устай тус тус харгалзана. Үүнийг дахин өнөөгийн он саргы илтгэх аргын арван өнгөтэй улируулан бодвол “бин барс жил” гэдэг нь улаан барс жилийг заана, шинь тахиа жил нь цагагчин тахиа жилийг илтгэнэ. Шим нохой жил нь хар нохой жил, тин гахай жил нь улаагчин гахай жил, вү хулгана жил жил нь шар хулгана жилийг тус тус зааж байна. Тус илтгэх арга нь 14 дүгээр зууны сурвалж бичигт ч түгээмэд илрэх бөгөөд илтгэх арга мөн ч Хубилай сэцэн хааны хятад эрдэмтдийг хүндэтгэн хэрэглэж, хятад соёлын нөлөөг гүн хүртсэний илрэл болно.

5. Цагийн хүрдний ёсоор жаран жилийн нэрээр нэрлэн хэрэглэсэн байдал нилээд цөөн харагдана. Үүнийг бас сайтар гарсны он тоолол, сайтар гарсны жаран жил буюу машид гарсан жаран гэх адил бусаар дууддаг. Энэ бол улаан барс жил энэтхэг хэлнээс төвөд хэлэнд орчуулан авсан нэгэн зүйлийн он тооллын арга болно. Төвөд хэлэнд равжун гэдэг бөгөөд эдгээр хэрэглэж байгаа нэр нь тус үгийг монголоор орчуулан хэрэглэсэн төдий юм. Тус он тооллыг улаагчин туулай жил бүхнийг орчуулан гаргасан тул улаагчин туулай жилээр сайтар гарсны эхний жил болгосон байна<sup>4</sup>. Дээрхээс жишээлбэл:

Олбой шар могой жилийн гиртиг сарын идэр өдрөө – Асрагч нэртийн түүх (65a21). Арван нэгдүгээр сайтар болсны гал могойд жаран гурван жил болов – Асрагч нэртийн түүх (52b) гэх мэт. Үүнд олбой шар гэдэг нь сайтар гарсны тавин нэгдүгээр жилийг илтгэнэ. Асрагч нэртийн төгсгөлд зохиогчоос “Олбой шар могой жилийн гиртиг сарын идэр өдрөө улам хойдош ухахын тул Асрагч нэрт түүх болгон бичив” гэсний олбой шар могой жилийг сайтар гарсны жаран жилээр даган бодвол энэ нь 11 дүгээр жарны 51 дүгээр жилийг зааж байгаа тул яг тус сурвалж бичгийн гадар хавтсан дээр зурхайн тоогоор бичсэн 1677 он хэмээсэнтэй яв цав харгалзаж байна. Ийм аргыг одоо нэгэнт хэрэглэхээ больжээ. Үүнээс гадна Саган сэцэн Эрдэнийн товчийн уг номын гаргалгаандаа тус номыг бичсэн цагаа тодорхой тушаасан тэмдэглэлийг бид сийрүүлвэл: “ургамал түрсэн жил есөн улаан хилэнт хэмээхийн тавин есдүгээр, ургасан огторгуйн жил найман цагааны үүсгэгч хоёрдугаар, удирапэлгүни сарын арван нэгэн модон гараг ялгасан одон өдөр эхлэн, учирч бурвасад сарын нэгэн сини гадас гараг бус одон өдөр төгсгөв” гэжээ. Үүнд есөн улаан хилэнт гэдэг нь есөн улаан хилэнт эх жилийг зааж байна. Хилэнт эх хэмээх жил бол равжуний жаран болгоны гучин наймдугаар жилд таардаг, монголоор хилэнтэй гэх буюу хилэнт эх гэнэ, заримдаа товчлон хилэнт гэдэг. Үүнд үүсгэгч гэсэн үг ба тус сурвалж бичгийн сүүлд дагалдуулсан далан есөн бадаг

<sup>4</sup> П.Дугар. Монгол одон орон зурхайн шастир. ӨМШУТМХХ., 2003 т 316



## THE CULTURAL WAY

сургаал шүлгийн тохиролцох газар дахь буян үүсгэгч гэсэн үг бол равжуний жарны гучин зургадугаар жилийн монгол хэллэг болно<sup>5</sup>.

*(Гурав) Он ба жил гэх үгийн ялгаа зөрөө*

Дээрхээс үзвэл 17 дугаар зууны сурвалж бичигт жил гэх үгийг он гэх үгнээс нэн чөлөөтэй хэрэглэж байхыг амархан үзэж гарна. Он гэх үг нь зөвхөн үргэлжилсэн хугацааг илтгэх, тухайн жилийг илтгэх буюу хааны оны цолоор он тооллыг илтгэхэд хэрэглэж байжээ. Жил гэх үг нь арван хоёр жилтэнтэй холбон он тооллыг илтгэх, зурхайн таван махбод, таван өнгө хийгээд эрхтэн зэргийг нэмж он жилийг тодорхой тодотгож байсан бөгөөд төвөд маягаар он тооллыг илтгэх буюу хятад маягаар он тооллыг илтгэхэд мөн хэрэглэж байжээ. Жил гэх үгийг бас онтой адил үргэлжилсэн хугацаанд ч хэрэглэж байна. Энэ нь дундад зууны монгол хэлэнд хэрэглэгдэх байдлаас илт ялгагдах нэгэн онцлог болно. Дундад зууны монгол хэлэнд жил гэх үг нь зөвхөн монголчуудын дунд нилээд өргөн хэмжээгээр хэрэглэгдэж байсан арван хоёр жилийн тоололд арван хоёр зүйлийн амьтны нэртэй холбогдон илэрч өөр байдалд ер илэрсэнгүй. Үүнээс жил гэх үг нь тухайн үед бусад төрөл хэлнээс зээлдэн орж ирсэн үг гэж эрдэмтэд таамаглажээ. Харин он гэх үг нь нэн эрт бусад төрөл хэлнээс зээлдэн орж ирээд нэгэнт идээшсэн буюу тэрэ чигээрээ монгол хэлний үг болохоор дундад зууны үед нэн чөлөөтэй хэрэглэгдэж байсан гэж эрдэмтэд үзжээ<sup>6</sup>.

Хоёр. Сарын тооллын тухай

17 дугаар зууны монгол хэлний сурвалж бичигт сарыг дөрвөн улирлын нэрийдлээр хуваарилан нэрлэх, монгол тусгай сарын нэрийдлээр нэрлэх, монголын сар (хур сар)-аар нэгчлэн нэрлэх буюу төвөдийн сарын нэрийдлээр нэрлэх гэх зэрэг аргаар илтгэж байжээ.

1. Сарын дөрвөн улирлын нэрийдлээр хуваарилан тоолох нь сурвалж бичигт тун олон харагдана. Жишээлбэл, Тайчууд зуны тэргүүн сарын арван тавнаа дэлгэр өдрөө их хурим хийж ... Хураангуй алтан товч (12b9). Гал гахай жилийн хаврын адаг сарын арван хоёронд, жаран зургаан насанд Түрэмгий балгасанд нөгчив – Асрагч нэртийн түүх (22a18) гэх мэт. Энэ нь дундад эртний монгол сурвалж бичигт хэрэглэгдэх байдалтай адил байна. Тухайлбал, Монголын нууц товчоонд Тэмүжин Жамуха хоёр янаг найртай байж нэг жил хагас хамт сууж зуны тэргүүн сарын улаан тэргэл өдөр нүүв – 118 гэх мэт. Тус арга нь нэг жилийг хавар, зун, намар, өвөл гэж дөрвөн улирал хувааж, дахин улирал бүрээ гурван сар хувааж тоолон тэмдэглэхийг заана. Үүнд хаврын эхэн сар нь нэгдүгээр сар, хаврын дунд сар нь хоёрдугаар сар, хаврын эцэс сар нь

<sup>5</sup> Улаан. Эрдэнийн товчийн судлал. ЛяоҮнХХ., 2005 т 39

<sup>6</sup> Хасбагана. Дундад зууны монгол хэлний судлал. ӨМСХХХ., 1996 т 447





## THE CULTURAL WAY

гуравдугаар сарыг заадаг. Зун, намар, өвлийн улирлыг ч ингэж гурав хуваариалан дараалан тоолно.

2. Монгол тусгай сарын нэрийдлээр сарыг илтгэх нь ч маш олон илэрчээ. Жишээлбэл, Хувь сарын хорин хоёроо наян нэгэн насандаа Дайдуд тэнгэр болов – Хураангуй алтан товч (35b24). Вү хулгана жилийн өөлжин сарын хорин зургааны өдрөө – Эрдэнийн товч (84r9) гэх мэт. Энэхүү тусгай сарын нэрийдэл нь нэгдүгээр сараас арван хоёр сар хүртэл тус тус хувь сар, хужир сар, өөлжин сар, хөхөө сар, улару сар, өйрү сар, хулан сар, буга сар, хуц сар, гэлэвтэр сар, идлэх сар, хөөлөр сар гэдэг. Эдгээр нэрийдлийг бүх монголчууд өдөр тутмын амьдрал орчноо ажиглан шинжиж, жигүүртэн шувуу, араатан амьтны нэр буюу сарын онцлог шинжээр сарыг нэрлэн тогтсон юм. Жишээ нь гуравдугаар сар бол газар гэсэж хужир хөөрөх үе болохоор хужир сар хэмээн, дөрөвдүгээр сард хөхөө шувуу донгоддог болохоор түүнийг хөхөө сар, наймдугаар сард буга урамддаг болохоор буга сар гэж нэрлэн, есдүгээр сард хуц ухнаа сүрэгт нь нийлүүлдэг болохоор хуц сар хэмээжээ.

3. Монголын сар буюу хур сараар нэрлэх гэдэг нь их төлөв араб тооны хойно сарыг хэрэглэхийг зааж байна. Хур гэдэг нь төвөд хэлэнд монгол гэх үг байж, хур сар нь монгол сарыг илтгэнэ. Үүнд материалаас эрж мэдсэн нэг адил бус зүйл гэвэл нэгдүгээр сарыг цагаан сар гэж тэмдэглэж байна. Жишээлбэл, Өлзийт хаан гучин насандаа дөрвөн сарын арван шинэд Чихэр нуураа их хаан ор суув – Хураангуй алтан товч (36a1). Дөчин долооны үхэр жил хан орноо сууж зургаан сар найман өдөр болоод мөн тэр жил халив – Эрдэнийн товч (34v9) гэх мэт.

4. Зарим сурвалж бичигт санскрит төвөд сарын нэрийдлээр сарыг тэмдэглэх байдал бас олон тохиолдоно. Тухайлбал, Улбар шар нохой жилийн гиртиг сарын идэр өдрөө – Асрагч нэртийн түүх (65b21). Вү луу жилийн удирапэлгүни сарын тэргэл наран мандахад – Эрдэнийн товч гэх мэт. Сарын нэрийдлийг санскрит төвөдөөр илтгэх байдлын тухай дурдвал нэгдүгээр сарыг мен сар, хоёрдугаар сарыг удирапэлгүни, гуравдугаар сарыг зөүрэ сар, дөрөвдүгээр сарыг шошаг сар, тавдугаар сарыг зестэ сар, зургадугаар сарыг бурвасад сар, долдугаар сарыг сираван сар, наймдугаар сарыг бурвабадирабад сар, есдүгээр сарыг ашувани сар, аравдугаар сарыг гиртиг, арван нэгдүгээр сарыг маргаши сар, арван хоёрдугаар сарыг бүс сар гэдэг. Үүнд гиртиг сар нь арван сарыг заах учраас улбар шар могой жилийн гиртиг сар гэдэг нь сайтар гарсны тавин нэгдүгээр жилийн аравдугаар сарыг заана. Удирапэлгүни сар нь хоёрдугаар сарыг заах тул вү луу жилийн удирапэлгүни сар гэдэг нь шар луу жилийн хоёрдугаа сарыг илтгэнэ. Саган эцэн Эрдэнийн товчийн уг номын гаргалгаандаа тус номыг бичсэн цагаа тодорхой тэмдэглэснээс дахин үзвэл “ургамал түрсэн жил есөн улаан хилэнт хэмээхийн тавин есдүгээр, ургасан огторгуйн жил найман цагааны үүсгэгч хоёрдугаар, удирапэлгүни сарын арван нэгэн модон гараг ялгасан одон өдөр эхлэн, учирч бурвасад сарын нэгэн сини





## THE CULTURAL WAY

гадас гараг бус одон өдөр төгсгөв” гэх мэт. Энд сарыг илтгэ байгаа аргыг санскрит төвөдөөр илтгэх байдлаас улируулан бодвол, удирапэлгүни сар нь хоёрдугаар сарыг зааж, бурвасад сар нь зургадугаар сарыг зааж байна.

Эртний сурвалж бичигт илэрсэн он сар өдрийн илтгэх аргад “улаан тэргэл өдөр, тэргэл өдөр” гэж олон гарна. Жишээлбэл, Монголын нууц товчоонд “Зуны тэргүүн сарын улаан тэргэл өдөр нүүв – 118 гэх зэрэг. Үүнд арван зургааны өдөр сар тэргэлших тул тэргэл өдөр гэж арван зургааг заадаг. Зурхайн ёсонд сар бүрийн шинийн нэгнээс арван таван хүртэл цагаан зүг гэж, арван зургаанаас гучин хүртэл улаан зүг гэх<sup>7</sup> болохоор зарим үед бас улаан тэргэл өдөр гэж хэрэглэдэг.

Үүнээс гадна онцгой нэгэн сарыг тэмдэглэх арга Асрагч нэртийн түүхэнд ганц удаа илэрсэн байна. Тухайлбал, Үхэр жилийн усан сард монгол орноо – Асрагч нэртийн түүх (45a7) гэх мэт. Энд яагаад ингэж хэрэглэсэн хийгээд усан сар гэдэг нь чухам аль сарыг зааж байгаа нь одоогоор хараахан судалж амжаагүй асуудал билээ.

Эртний үед арван хоёр жилийн амьтны нэрээр сарыг нэрлэх байдлыг бид тус таван сурвалж бичгээс эрж олсонгүй. Энэхүү арга нь арван хоёр жилийн амьтны нэрээр сарыг нэрлэн илтгэхдээ барс сараас эхлэн нэгдүгээр сарыг илтгэдэг. Үүнд барс сараас эхлэн жилийн эхний сарыг нэрлэхийг Чингис хаан тогтлоо гэж бусад материалд дурдаж өнгөрсөн юм<sup>8</sup>. Тус аргаар сарыг илтгэж байсан жишээг 16 дугаар зууны сурвалж бичиг болох Арван буянт номын цагаан түүхээс олж харна. Тухайлбал, “Басабар дөрвөн цагийн хуримыг үйлдсээр хэмээж, хаврын эцэс өөлжин луу сарын хорин нэгнээ Чингис хаан ерэн есөн гүүдээ уяж цагаан сацлаа сацсанаар хаврын цагаан сүргээ хуримыг тэр өдөр үйлдэнэ. Зуны дундад морин сарын арван зургаанаа ертөнцийн шүтээн дэлгэр дэлхий эх тоногийг тавьж ерэн есөн цагаанчуудаа уураг үрсийг гаргаснаар зуны нуурын хуримыг тэр өдөр үйлдэнэ. Намрын эцэс нохой сарын арван хоёрноо унаганы чягт шилбийг нь эвхсэнээр ногт ширгийн хуримыг тэр өдөр үйлдэнэ. Өвлийн дундад хулгана сарын гунан синид Чингис хаан мялаагаадыг хийснээр өвлийн тасам тавиурын хуримыг тэр өдөр үйлдэнэ<sup>9</sup> гэж төвөд цагийн хуримын үйлдэх өдөр сарыг илтгэсэн байдаг. Үүнд луу сар бол гуравдугаар сарыг, морин сар бол тавдугаар сарыг, могой сар бол есдүгээр сарыг, хулгана сар бол арван нэгдүгээр сарыг заадаг. Мөн ч хаврын эцэс хийгээд өөлжин сар нь бүр гуравдугаар сарыг, зуны дунд сар нь

<sup>7</sup> Боржгин, Ванчиг. Монголчуудын шинжлэх ухаан техникийн түүх-од зурхайн ухаан. ӨМАХХ., 2008 т 418

<sup>8</sup> Боржгин, Ванчиг. Монголчуудын шинжлэх ухаан техникийн түүх-од зурхайн ухаан. ӨМАХХ., 2008 т 186

<sup>9</sup> Лю Жиньсуо. Арван буянт номын цагаан түүх. ӨМАХХ., 1981 т 87



## THE CULTURAL WAY

тавдугаар сарыг, намрын эцэс сар нь есдүгэр сарыг, өвлийн дунд сар нь арван нэгдүгээр сарыг заах аргатай яв цав таарч байна.

17 дугаар зууны сурвалж бичигт энэхүү аргыг хэрэглэсэн байдал харагдахгүй байгаа нь тухай үед монголчуудын дунд төвөд сарын нэрийдэл нь нэн илүү хэрэглэгдэж, монгол зурхайн ухаан нь төвөд зурхайн ухааны нөлөөг хүртсэн нь илэрхий буюу бусад илтгэх арга нь нэн илүү дэлгэрч байснаас болсон байж магад. Өнөө сарыг илтгэхэд зөвхөн араб тооны хойно сарыг нэмж илтгэх аргыг хэрэглэж, хаяа уран зохиол зэрэгт улирлын хувирлаар илтгэж байгаагаас гадна монгол тусгай нэрийдлээр нэрлэх зэрэг арга нь онц зарим газар орныг гаргавал үндсэндээ мартагдан гээгдсэн байна.

### ДҮГНЭЛТ

17 дугаар зууны монгол сурвалж бичигт тухайн үед он сарыг илтгэх байдал нь одоогийн он сарыг илтгэх аргаас нилээд зөрөөтэй байжээ. Эртний хаад өөрийн үндэстний эрдэмтдээр барахгүй бас харь үндэстний эрдэмтэн мэргэдийг ихээр хүндэтгэн хэрэглэж байсан бөгөөд үүнд зурхайн ухааны эрдэмтэд ч маш олон байв. 17 дугаар зууны сурвалж бичигт жил гэх үг нь он гэх үгнээс нэн өргөн хэрэглэгдэж байсан байна. Монголчуудн он сарыг илтгэх уран арга, оновчтой нэрийдэл нь тэдний урт удаан хугацааны нүүдлийн соёлын амьдрал ахуй орчинтойгоо эелдэг зохицон, байгаль дэлхийг оюун ухаанаараа шинжин судалсны үр дүн болох бөгөөд өнөөдрийн судалгаа шинжилгээ хөгжсөн цагт ч гэсэн мундашгүй нөлөө үзүүлж байна.

### ABSTRACT

The Mongolian nation is a nation with a long cultural history. Since ancient times, Mongolians have studied the nature and the stars in the midst of their nomadic life, and have lived in harmony with their environment. In this way, he observed the laws of nature, time and season that he had researched and discovered, and established the name or method to indicate the year, month, and day. Our ancestors have been recording the history and culture of their nation ever since they learned to write, and these records are invaluable for studying things such as the history of the past and Mongolian life and culture at that time.

Keywords: *historical documents of 17th century, year and month*

### НОМ ЗҮЙ

1. Лю Жиньсуо. Арван буянт номын цагаан түүх. ӨМАХХ., 1981
2. Хасбагана. Дундад зууны монгол хэлний судлал. ӨМСХХХ., 1996
3. П.Дугар. Монгол одон орон зурхайн шастир. ӨМШУТМХХ., 2003
4. Улаан. Эрдэнийн товчийн судлал. ЛяоҮнХХ., 2005
5. Боржгин, Ванчиг. Монголчуудын шинжлэх ухаан техникийн түүх-од зурхайн ухаан. ӨМАХХ., 2008

МОНГОЛ ГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТОЙМ БА ГЭРТЭЙ ХОЛБОГДОХ ЗАРИМ  
ЗАНШИЛ

А.Ариунболд\*

## ХУРААНГУЙ

Гэр нь одоогоос олон мянган жилийн өмнө үүсэн бие болж хөгжсөөр өнөөдрийн түвшинд хүрчээ. Тэр дундаа монгол гэрийн үүсэл хөгжил, түүнтэй холбогдох ёс заншил, зан үйлийн олон дэг бий болсон бөгөөд тэр урт удаан түүхийн хугацаанд монголчуудын өдөр тутмын амьдралыг зохицуулсаар ирсэн байна.

Түлхүүр үгс: *Монгол гэр, үүсэл хөгжил, ёс заншил*

Гэр бол Төв Азийн нүүдэлчин ард түмний уламжлалт гэр сууц юм. Монгол гэр 3000 орчим жилийн тэртээгээс одоогийн хэв шинж нь бүрэлдсэн гэж судлаачид үздэг бөгөөд хүний амьдралын гол хэрэгцээ болсоор өнөө цагт уламжлагдан хүрч иржээ. Нүүдэллэн аж төрөхөд хамгийн сайн зохицсон гэр сууц нь бүтэц зохиомжийнхоо хувьд ихээхэн сонирхол татдаг билээ. Хөнгөн, авсаархан, удаан эдлэгддэг, зохиомжийн онцгой шийдэлтэй дэлхий дээрх нүүдэлчдийн өв соёл ажээ. Нүүдэлчид анхны төрт улс Хүннүүгийн үеэс гэрийнхээ үүдийг наран мандах зүг буюу зүүн урд зүгт харуулан барьдаг байжээ. Энэ уламжлал нь өнөөдөр хүртэл бидэнд уламжлагдан хүрч иржээ.

Монгол гэрийн талаарх анхны мэдээ нь эртний Хятад сурвалжид МЭӨ 629 онд тэмдэглэжээ. Уг түүхэнд бичихдээ "Умард зүгийн Ди, Жун (хүннүгээс өмнө монгол аймгийг нанхиадууд ди жун гэж нэрэлдэг байсан) нар лу жан сууцанд суудаг" гэжээ. Лу жан хэмээх нь хөшиг майхан гэсэн утгатай үг ажээ. Харин Хүннүгийн гэр сууцны тухай анхны мэдээ МЭӨ 174 онд Цзя И-гийн "Шинэ бичиг" хэмээх сурвалжийн мэдээнд Хүн-лү гэж гардаг бол Сыма Цяны "Түүхэн тэмдэглэл"-д Хүннү нар нар хун-лу сууцанд амьдардаг гэх зэргээр тэмдэглэсэн байна. Түүнчлэн МЭӨ 81 онд зохиогдсон хятадын түүхч Хуан Куны зохиолд хүннүгийн сууцыг хун-лу гээд бургас шүлжин эсгийгээр бүрдэг гэжээ. Хан улсын эзэн хаан Хүннүчүүдийн нэгэн газрыг гуйхад Учжулуй

---

\* ШУТИС-ийн БУХС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын багш, доктор



## THE CULTURAL WAY

шаньюй хун-лу хийдэг модтой газар хэмээгээд өгөхөөс татгалзжээ гэж Хан улсын төрийн түүх “Цянь хан шу”-д бичжээ. Үүнээс гадна эртний Хятадын Вэй, Тан, Сүн улсын төрийн түүхүүдэд гэрийн талаар бас дурджээ<sup>1</sup>. Мөн Нирун монголчууд анх их тэрэм буюу гэр тэргийг хэрэглэж байсан мэдээ байна. Эзэнт гүрний үед монголын их хаадуудад бараалхахаар ирсэн Францийн вангийн элч Плано Карпино, Ромын папын элч Гилиом де Рубрук, Марко Поло нарын аян замын тэмдэглэлд тухайн үеийн Монголчуудын аж байдал, соёлын талаар бичихдээ гэрийг онцгойлон дурдсан байдаг<sup>2</sup>.

XIII зууны Монголчуудын гэр тэрэг хэмээх нэгэн сууцны тухай дундад зууны жуулчдын тэмдэглэлд “Гэр тэрэгтэй нүүдэл нь их хот нүүж яваа мэт сүртэй” харагддаг тухай тэмдэглэсэн нь бий. Байнгын хэрэгцээний гэр сууцыг хийц, гадаад хэлбэрээр нь Монгол, Түрэг гэр гэсэн хоёр үндсэн ангилалд хамруулна. Монгол гэрийг дотор нь Халх, Өмнөд монгол, Ойрад монгол, Буриад монгол гэр гэж ялган үздэг. Монгол гэр нь монголчуудын ахуй амьдралд зохицсон зөөж, буулган барихад хөнгөн авсаархан бөгөөд уламжлалт гар урлалын олон төрөл зүйлийг цогцоор нь агуулсан байдаг. Гэрийн урлалд гэрийн яс мод буюу хана, унь, тооно, хаалга, багана урладаг мужаан, түүнийг хээлэн чимэглэгч будагчин, зүмбэрчин, сийлбэрчин, гэрийн эсгий бүрээс урлаач оёдолчин, гэрийн оосор, бүслүүр хошлон томогч, ширэгч уран үйлчин зэрэг маш олон хүний хүч хөдөлмөр шингэж бүтдэг. Олон үе дамжин боловсорсон технологийн чанд горим, ур ухаан, цаг хугацаа шаардсан энэ урлал удам дамжин үеэс үед өвлөгдөж, цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцэн баяжиж, хөгжиж ирсэн түүхтэй. Монголд гэрийн багтаамжийг ханын тоогоор тогтоодог. Дээр үед гэрийн ханыг сондгой тоогоор тогтоодог байсан бол орчин үед тэгш тоотой хийдэг болжээ. Жишээ нь, Монгол гэрийн багтаамж нь 4, 5, 6, 8, 10, 12 ханатай байдаг. Монгол нутагт эртнээс нааш нүүдэлчин овог аймгууд оршин амьдрах хугацаандаа тухайн цагийн байдлаас шалтгаалж олон төрлийн хэлбэр загвар бүхий гэрт амьдран суусаар ирсэн.

Монгол нутагт эртнээс нааш нүүдэлчин овог аймгууд оршин амьдрах хугацаандаа тухайн цагийн байдлаас шалтгаалж олон төрлийн хэлбэр загвар бүхий гэрт амьдран суусаар ирсэн. Үүнд:

Эрүкэ буюу нүхэн гэр

Урц

Алачуг

Өвсөн эмбүүл

Бургасан гэр

Дэглэй гэр

<sup>1</sup> Монгол ардын уламжлалт ёс, зан үйлийн дээж -1, 2. УБ.,1991. т.31-32

<sup>2</sup> Гилиом де Рубрук. Монголчуудын түүх- Дорно этгээдэд зорчсон минь. УБ., 1988 т. 105-107



## THE CULTURAL WAY

Хошлог  
Жолом  
Гишгүүр гэр  
Шалан гэр  
Зараан тов  
Сүйжин гэр  
Булгаасан гэр  
Холтсон гэр  
Тэрэгт гэр/Гэрлүг  
Орд гэр  
Өргөө гэр

Гэр гэсэн олон төрөл байжээ .

Монгол гэр нь өөрийн хөгжлийн эцэст голлох хийц хэсгүүдээр амархан нийлж салгах боломжтой ба зөөж барих, буулгахад хамгийн хялбар болжээ. Монгол гэр жилийн дөрвөн улиралд бороо, цас, хүчтэй салхи шуурганаас хамгаалах, гэрийн гэрэлтүүлгийг тохируулах зорилгоор тооныг бүтээх өрхтэй болгожээ. Дээр үеийн зарим Монголчууд өөрийн гэрийн эсгий бүрээсийг хэе угалзаар чимэглэдэг байсан бол эдүгээ гэрийг голдуу цагаан даавуугаар бүрж, мөн хэе угалзаар зээглэдэг болжээ.

Монгол гэрийг барих, буулгах нь нарийн дэс дараалалтай байдаг. Иймд гэрийг барих ба буулгах дэс дарааллыг дурдвал:

- |                           |             |               |
|---------------------------|-------------|---------------|
| 1.Шал тавих               | 14.Оосор    | бүслүүр,      |
| 2.Хаалга босгох           | даруулагаар | бэхлэх зэрэг  |
| 3.Ханаа дугуйлах          | дараалалтай | байдаг байна. |
| 4.Бүслүүр татах /дотуур/  |             |               |
| 5.Тооно ба багана босгох  |             |               |
| 6.Унь хатгах              |             |               |
| 7. Цаваг тавих /дотуур/   |             |               |
| 8.Туурга нөмөргөх         |             |               |
| 9.Дотуур бүрээс тавих     |             |               |
| 10.Дээвэр тавих           |             |               |
| 11.Гадуур бүрээс нөмөргөх |             |               |
| 12.Өрх тавих              |             |               |
| 13.Хаяавч татах           |             |               |



## THE CULTURAL WAY

Монголчуудын гэр сууц нь эртний уламжлалтай бөгөөд хөгжлийн олон үе шатыг туулан өнөөгийн хэлбэрийг олжээ. Монгол гэрийн доторхыг хоймор, үүд, эзэгтэйн тал, гэрийн эзний тал гэж ялгах нь гэрийн дотор баримтлах ёс, зай талбайн журмыг тогтоосон хэв ёс болно. Монголчууд гэрийнхээ гол дунд гал голомт тулгаа байрлуулдаг. Гал голомт буюу галын өр нь ертөнцийн төв, газрын өр байдлаар төсөөлөгдөх болжээ. Галын өрийг тойрсон орон зайн баруун тал нь эрэгтэй хүний эд зүйл, зүүн талд эмэгтэй хүний эд зүйлийг байрлуулдгаас уламжлан эзэгтэй тал, эрэгтэй хүний тал хэмээх болсон байна. Гал голомт, галын өрөөс гэрийн доторх орон зайг 12 жилээр хуваан нэрлэх, зүг чиг заах, өнгөөр ялган бэлгэдэх гэрийн бүхий л зүйл нь монголчуудын зан заншилтай холбогдох бөгөөд энэ нь цаанаа ямар нэгэн бэлгэдэлт утга агуулдаг байна. Монгол хүн гэрт орохоос эхлээд монгол ахуй амьдралын онцлог, ёс заншлыг харж болно. Гэрт орж байгаа хүн баруун хөлөөрөө эхэлж орох ёстой бөгөөд өр нэхэх, хэл ам, хэрүүл тэмцэл хийх хүн зүүн хөлөөрөө ордог байна. Халх, Ойрад, Буриад, Өмнөд монголчууд гэрийн эсгий үүдийг зөв талаас нь зөв гараараа сөхөж гэртээ орно. Харин хасагууд гэрийнхээ эсгий үүдийг буруу талаас нь солгой гараараа сөхөж гэртээ ордог байжээ<sup>3</sup>.

Монгол гэрийн үүд хаалгыг өрх гэрт буян хишиг оруулах утгаар хүний ам байдлаар төсөөлөн бэлгэддэг байна. Гэрийн үүдийг шовх хадан хясаа, уулын ам, хөндий жалга харуулан барихыг цээрлэдэг. Сэт оноо тааруулж баривал хүн малын гарзтай гэж үздэг байна. Гэрийн үүдийг уулын ар, тэгш талыг тааруулж барьдаг уламжлалтай. Үүнтэй зэрэгцэн босго, тогтогны бэлгэдэл гарч ирнэ. Босгон дээр суух, гишгэхийг “Үүд багалзуурдаад” гэж машид цээрлэдэг. Эсгий үүдтэн Монгол хүмүүсийн амьдран суух орон гэрийг ялгаруулах угсаатны ялгаа олон байдаг. Тиймээс Монгол гэрийг Халх, Ойрад, Буриад, Өмнөд монгол, Хасаг гэр хэмээн ялгаж болно.

Тооно нь гэрийн орон зай ихэсгэх, багасгах, гэрт гэрэл гэгээ орох, гэрийн модны бүтэц, тогтолцоог урлан бүтээхэд их үүрэгтэй. Тооныг монголын тоонолжин буюу чагт тэмдэгтэй холбон хэлэлцэж болно. Монгол гэрт гэрэл гэгээ оруулж, утаа уурыг гаргах, унь тогтоох голдоо хөндлөн гулд чагт тэмдэгтэй дугуй цагираг хүрээг тооно гэнэ. Тооныг Ойрад монголын Дөрвөд, Баядад хараач, Өөлд, Торгууд, Урианхай, Захчинд гараац гэдэг. Хараач нь од, эрхэс, гэгээ гэрэл, гэгээн тэнгэрийн оронг нүдээр үзэх qaraq, qarabci, qaraci-тай нэг язгууртай. Гараац, гараадсан нь нүүдэлчдийн задгай гал, голомтын утаа, цай идээний дээж уур гэр дотроос гадагшлах, гарах гэдэг үгтэй нэг язгууртай байж болно. Баяд, Дөрвөдөд хар, харахаас хараач,

<sup>3</sup> Монгол ардын уламжлалт ёс, зан үйлийн дээж -1, 2. УБ.,1991 т.31-32



## THE CULTURAL WAY

Захчин, Торгуудад гар, гарахаас гараач болжээ. Монгол гэрийн тооныг нараар төлөөлүүлэн улаан, улбар шар өнгөөр дүрсэлсэн нь нарны бэлгэдэлтэй холбоотой юм. Тооныг нараар төлөөлүүлэн бэлгэдэхийн улмаас гэрийн унийг нарны цацраг байдлаар төсөөлөх болжээ.

Монголын уламжлалт ёсонд гэрийн тоонон дээгүүр алхах, гишгэхийг цээрлэдэг нь утгаа тооныг гэрийн толгой тэргүүн буюу хүний тэргүүнтэй холбон үздэгтэй холбоотой юм. Тооно дээгүүр бүтээж нар, салхи, цас, бороо, шороо, хурц гэрэл гэгээнээс хамгаалах, мөн гэрт тусах нарны гэрэл гэгээг тохируулах зэрэг үүрэгтэй гэрийн нэгэн зүйл бүрээс бол өрх юм. Өрхийг бүтцээр нь гурвалжин, дөрвөлжин, хошуут гэж гурав ангилна. Монголчууд гэрийн өрхийг тоононы малгай байдлаар төсөөлдөг байна. Гэрийн тооно, өрхөн дээгүүр алхах, гишгэхийг цээрлэдэг нь монголчууд малгайн дээгүүр алхвал хийморь доройтно гэж үздэгтэй нэгэн адил юм.

Халх монголчууд ханыг шорон хана, хөлт хана, хатгуур хана, сараалжин хана, морин хана, хонин хана, хурган хана гэж ялгаж нэрлэдэг нь халх ястны нутгийн аялгууны хувилбар дуудлага юм. Шаг тэрэм, мөрөн тэрэм гэдэг нь ойрад аялгууны дуудлага болно. Гэрийн хана, туурганы ёроол хэсгийг хаяа гэнэ. Гэрийн хаяагаар тойруулан ороох эсгий, мод зэргээр хийсэн хэрэглэл хаяавчийн Халх-монгол, Ойрад-монгол дуудлага нь иргэ болно. Гэрийн хаяавч, иргэний өнгө нь тухайн ястны нэгэн зүйл зан үйлийн бэлгэдлийг илэрхийлдэг байна. Ховдын Мянгад ястан гэр, гал голомтоо дээдэлж хар эсгий хаяавчин тойруулгатай байдаг нь ид хав, хүчин чадал, овор жин, сүр байдал ихтэйг бэлгэдсэн утгатай байна.

Гэрийн голд багана гал голомт байна. Гэрийн баганаар дамжин өвөг дээдсийн сүнстэй холбогддог гэж үздэгээс багана түших, барих ялангуяа алдлахыг цээрлэдэг заншилтай. Мөн монголчууд баганыг гэрийн зовлонг үүрч явдаг гэж үздэг учраас хүүхдийг багананы зовлон авна гэж үздэг байна. Монголчууд баганыг ертөнцийн босоо тэнхлэг, мөн хүний хөл, тулгуур эрхтнээр төсөөлдөг байна. Монгол гэрийн бэлгэдэл нь:

1. Орчлон ертөнцийн бичил загвараар бэлгэдэх
2. Хүний хувилбар дүрсээр бэлгэдэх
3. Найман тахилаар бэлгэдэх гэсэн гурван зүйлийн давхар байдлаар уламжилсан байх бөгөөд үүнийг Монголын аман зохиол, уламжлалт ёс заншил, гэрийн зан үйл хийгээд цээрийн ёсноос сэргээн харж болохоор байна. Монгол гэрийн язгуурын бэлгэдэл болох ертөнцийн бичил загвар байдлаар төсөөлөн бэлгэдэх нь илүү орон зайн утгыг шингээж, хүний биеийн хувилбар дүрсээр бэлгэдэх нь цаг хугацааны утгыг шингээж уламжилсан байх ажээ.



## THE CULTURAL WAY

Монгол гэр нь монголын эд өлгийн болон оюуны соёлын асар нандин өвийг хадгалан уламжилж ирсэн зүйл юм. Тиймээс Монгол гэрийг ёс заншил, аман зохиол, угсаатны судлал, хэл шинжлэлийн үүднээс илүү нарийвчлан судлах шаардлагатай байна.

Монгол ардын уламжлалт гэртэй холбоотой дараах зан заншлууд байна:

Айлд орж яваа хүн гадаа нь бууж ирээд хоолой засаж чимээ өгч байж гэрт ордог. Орохын өмнө хувцас хунараа янзалж, бие засч, товч шилбээ бүрэн товчилж, малгайны халхавчаа сөхөж орно.

Айлд орохдоо эхлээд баруун хөлөөр босго алхаж ороод, айлын эзэн суудал зааж өгтөл нь түр зогсоод заасан суудалд нь сууна.

Айлд ороод, энгэр ташааныхаа товчоор оролддоггүй. Тэгвэл тэнд байгаа аль нэг эмэгтэйд санаархсан болдог.

Үдээс хойш ирсэн хүн малгайгаа авч тавьбал тэндийд хоноё гэсэн санааны илэрхийлэл юм байна.

Гэрлээд гарсан хүү, охин нь аав ээжийндээ зочилж ирэхдээ ирэнгүүт шүтээнд нь мөргөж, явахдаа бас мөргөөд ухарч гардаг ёстой. Энэ бол удам угсаагаа хүндэтгэсэн хэрэг.

Монголчууд гэртээ өөр өөрийн аягатай, явуулын хүн аягаа авч явдаг, тэр хүний аяганд нь цай, хоол хийж өгдөг ёс байжээ.

Монголчууд гэрт чанга, хашгирч ярилцах, ялангуяа хоол, ундны үед ярьж шуугилддаггүй ёстой байв.

Хол ойрын том хүмүүс цуглаад ярилцаж байхад хүүхдүүдийг гадагш гаргадаг, томчуудын ярианд хүүхэд оролцдоггүй.

Цай буцлаад уудалж байхад, хонины гэдэс чанаж байхад хүн ирвэл их аз, билэг дэмбэрэлтэйд тооцдог. Ер нь айлд орсон хүн болсон идээнээс амсч, явдаг ёстой.

Айл гэрийн зуухны дэргэд байдаг аргал түлээний авдрыг тэр айлын “галын сан” гэж үздэг учраас түүн дээр сандайлж суух, хог хийхийг цээрлэдэг ёстой.

Айл гэрийн унь, баганаас хоёр гараар атгаж, зүүгдэж барьдаггүй, бурхан шүтээний өмнүүр гардаггүй нь тэр айлын тусгаар байдлыг хүндэтгэсэн сайхан ёс юм.





## THE CULTURAL WAY

Хэн ч байсан айлд орохдоо энгэр заамаа товчилж, ханцуйгаа шамладаггүй. Мөн буу, саадаг, ташуур барьж ордоггүй, харин хутгаа бүснээсээ авч унжуулж ордог.

Айлд орсон, 18 нас хүрээгүй хүн тоононы голоос дээш суудаггүй. Эр хүн баруун талд, эм хүн зүүн талд, олуулаа орвол насны эрэмбээр суух ёстой.

Орыг эзэнгүй хонуулдаггүй, эзэнгүй хоноход хүрвэл орон дээрээ сүх, хайч, нүдүүр тавьдаг нь орон гэрийн заяа хаяхаас болгоомжилсон ёсон ажээ.

Лам хүний ор олбог дээр эмэгтэй хүн, эмэгтэй хүний орон дээр эр хүн суудаггүй.

Гэрээ барьсан хэвээр нь эр хүний ажилсагийг, ороо зассан хэвээр нь эм хүний ажилсагийг шинждэг.

Айл, үйл оёж байхад эмэгтэй хүн орвол хамжилцаж заавал нэг учиг дуусгадаг. Хашаа барих, ноос савах, хонь хяргах ажилтай үед тэр айлд эр хүн ирвэл ажлаас нь хамжилцаж туслалцдаг.

Гэрийн хаалганы тотгоны дээд тушаа унинд ирийг нь гадагш харуулан хөрөө хавчуулдаг ёс бий. Энэ нь тухайн айл гэрт хар хэл ам орохоос сэргийлсэн бэлэгдэлтэй юм.

Мөн гэрийн хаалганы баруун унинд хонины чанаж мөлжсөн богц чөмөгний яс хавчуулан тавьдаг ёсон байдаг. Энэ нь айлын хишиг буян аривдан тогтох, мал сүрэг өсөж үржих гэсэн бэлэгдэлтэй.

Гэрийн хаалганы баруун ханны нүдэнд хайчны ам боож хавчуулан тавих ёс байдаг. Энэ нь тухайн айлын мал сүрэг хээр гадаа хонох, уул хаданд алдсан үед хангай, хээрийн амьтан чононоос хамгаалж бүрэн бүтэн, аюулгүй байлгаж өгөөсэй гэсэн дом бэлгэдлийн ёсон ажээ.

Ардын уламжлалт эдгээр ёс заншлууд нь тусч, хамтач, ах захтай байхад чиглэгдсэн ардын сурган хүмүүжүүлэх арга, ухааны илрэлүүд юм.





## THE CULTURAL WAY

### ДҮГНЭЛТ

Нүүдэлчид эрт дээр цагаас байгаль орчин, амьдралын нөхцлөөсөө шалтгаалан гэр хэмээх сууцыг зохион бүтээжээ. Гэр нь урт удаан хугацааны явцад улам сайжирч хөгжсөөр ирсэн бөгөөд тухайн газар орон, ард түмэн, ястан, угсаатны соёлын ялгамжтай байдлаасаа болоод Монгол гэр, Түрэг гэр хэмээх хоёр үндсэн хэсэг болон хөгжиж ирэв.

Гэр нь нүүдэлчин ард түмний амьдралын хэрэгцээг бүрэн хангаж ирсний зэрэгцээ тэдний соёлын томоохон төлөөлөл болсон төдийгүй, түүнтэй холбогдох ховор нандин ёс заншлуудыг ч бий болгов. Тэр дундаа нүүдэлчдийн өдөр тутмын амьдралын хэм хэмжээ, болно болохгүйг бүрэн цохицуулахын зэрэгцээ хөх мөнх тэнгэр, хөрст алтан дэлхийгээ хайрлан орших, аав ээж, ахас эхсээ хүндлэх, дүү, үр хүүхдээ зөв сургах эх сурвалж, заншил болон хөгжиж ирсэн нь Монгол гэрийн бидэнд өвлүүлж ирсэн аугаа их өв соёл билээ.

Тиймээс монгол гэрийн хөгжиж ирсэн түүхэн замнал, гэрийн бүтэц бүрэлдэхүүн, хийх арга барил, бас Монгол гэртэй холбогдсон ёс заншлуудыг ирээдүйн үр хойчдоо танин мэдэхүй, судалгаа шинжилгээний түвшинд зааж сурган, тахин мэдүүлж, өвлүүлэх нь та бидний эрхэм зорилго гэлтэй...

### ABSTRACT

Since ancient times, nomads have invented houses called homes due to their environment and living conditions. Ger has improved and developed over a long period of time, and due to the differences in the country, people, bones, and ethnic culture of the area, it has developed into two main parts, Mongolian ger and Turkic ger.

The house not only fulfilled the needs of the nomadic people's life, but also became a significant representation of their culture, and also created rare and precious customs associated with it. In particular, it has developed as a source and custom of living with love for the eternal blue sky and the golden earth, respecting parents, brothers and sisters, and educating children properly. It is a great cultural heritage. Therefore, it is our mission to teach, teach and pass on the historical development of the Mongolian house, the structure of the house, the way of doing it, and the customs related to the Mongolian house at the level of knowledge and research to our future generations.

Keywords: *Mongolian ger, origin and development, customs*

### НОМ ЗҮЙ

1. Гилиом де Рубрук. Монголчуудын түүх- Дорно этгээдэд зорчсон минь., УБ., 1988.
2. Нэвтэрхий толь — Википедиа
3. Монгол ардын уламжлалт ёс, зан үйлийн дээж -1, 2. УБ., 1991



## ХУУРЫН ҮҮСЭЛ ГАРЛЫН ТУХАЙ МӨШГӨХ НЬ

Ө.Хасмөчир\*

## ХУРААНГУЙ

Хуурын үлгэр нь Монгол үндэстний оюуны соёлын нэгэн зүйлийн бүтээл юм. Энэ нь хүний оюун санаанаас бүтээсэн дуу хуураар дамжин илэрч гарч ирдэг биет бус өв билээ. Энэхүү өгүүллийг бичихдээ хуурын үлгэрийн үүсэл хөгжлийн тухай судалгааны материалыг эмхэтгэн цуглуулж судалгачдын үзэл хандлагыг гурван талаас ангилан шинжилжээ. Хуурын үлгэрийн үүсэл хөгжлийн шалтгааныг дотоод, гадаад хоёр талаас задлан судалж соёлын тайламж хийсэн байдаг.

Түлхүүр үгс: *Хуурын үлгэр, үүсэл гарал, судалгааны байдал*

Хуурын үлгэр бол Өвөр монголын зүүн оронд өргөн дэлгэрсэн ардын урлагийн илэрхийлэл бөгөөд Монгол ардын хуурч дөрвөн утаст хуурыг хөгжимдөн ярьж, дуулахаар дамжуулж бүтээсэн өвөрмөц аман урлагийн нэг төрөл юм. Хуурын үлгэр нь үндэстний соёл, оюун ухаан дээр илрэн гарч ирсэн үзэгдэл болохын хувьд түүний тухай судалгаа хийх нь Монголчуудын бодисын бус соёлын судалгааны хөгжилтөд тун их ач холбогдолтай ажээ.

Нэг. Хуурын үлгэрийн үүсэл гарлын тухай судлагдсан байдал

Хуурын үлгэрийн судалгааны ажил ХХ зууны 20-иод оноос эхэлсэн бөгөөд тэр дундаа 1990 ээд оноос нааш Өвөр монгол оронд хуурын үлгэрийн судалгаа ихээр өрнөн хөгжжээ. Өнөөдөр энэ талын судалгаа нь нэг төрлийн биеэ даасан системчилсэн тусгай эрдэм шинжилгээний салбар болсон байна. Цаашлаад судалгааны цар хүрээ өргөн дэлгэр, судалгаачид нь өөр өөрийн чиглэлээр хуурын үлгэрийн судалгааг нарийн хянамгай судалж байна. Үүний үр дүнд өндөр чанартай судалгааны бүтээлүүд, магистрын судалгааны ажилууд, докторын зэрэг хамгаалсан диссертаци, илтгэл өгүүлүүд олон гарчээ. Харин энэ удаа бид хуурын үлгэрийн үүсэл гарлын тухай хайн мөшгөж өмнөх хүмүүсийн судалгааны байдлын тухай ангилал хийв. Хуур үүсч хуурчид бий болсон гэх үзэлт:

Хуур үүсч хуурчид бий болсон тэр цаг үеэс эхлэн хуурын үлгэр бий болсон гэх үзэлтэй судлаачид гэвэл Алтанбагна, Чимэддорж зэрэг хүмүүсийг

\* ШУТИС-ийн БУХС-ийн Хүмүүнлэгийн салбарын Соёл судлалын докторант



## THE CULTURAL WAY

дурдаж болно. Хуурын тухай түүхэн тэмдэглэлүүдийг шүүж үзвэл Чингис хааны үед хуур нэгэнт төрийн хөгжмийн зэмсгийн өндөр байранд хүрсэн байжээ. “Монголын нууц товчоо”, “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, “Эрдэнийн товч” зэрэг олон түүхэн сурвалжид хуурын тухай мэдээнүүд нилээдгүй байх юм. Энэ бүхнээс үзвэл хуур нь маш эртний хөгжмийн зэмсэг болох нь тодорхой байна. Одоогийн Юньнаны Монголчууын дунд хадгалагдаж байгаа луун толгойтой дөрвөн утаст хуур нь үүний тод нэгэн жишээ болно.

Монголчууын дунд үлгэр, тууж ярьж хэлэх заншил эртээс уламжлалтай ажээ. Чингис хааны үед шидэт үлгэр, домог үлгэр, баатарлаг туульсийн үлгэрээс гадна цуурын үлгэр, хуурын үлгэр зэрэг олон хэлбэр төрөлүүд байсан байна. Монголын нэрт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршивой” хэмээх номондоо “Сүн улсын хүйтэн уулын бичгийн хорин гуравдугаар бүлэг”-т Паажээийн хэлсэн хуурын үлгэрийг сийрүүлж ар талд нь хадсан тайлбардаа “Үргэлжилсэн үг ба шүлэг ээлжлэн явах энэ зохиолын хэлбэр нь нууц товчоотой их адил бөгөөд гүн уламжлалтай гээд. XIII зууны үед Паажээ шиг ийм нэгэн сэцэн хуурч Монголын түүхэн тэмдэглэлийг зохиосон болов уу гэж санагдуулж амуй”<sup>1</sup> гэж тэмдэглэжээ. Хэдийвээр түүхийн бичигт дурдсан “Хуур, цуур хөгжим” гэх үсэг баримт байвч энд ярьж байгаа хуур нь морин хуурыг зааж байна. Хуурч хэмээн бас морин хуур татаж тоголдог хүмүүсийг хэлж байгаа бололтой. Адил бус үлгэрийн хэлбэрээс үүсэлтэй хэмээх үзэлт:

А) “Бэнзийн үлгэр”- ээс<sup>2</sup> үүсэлтэй:

Монгол улсын эрдэмтэн Д.Цэрэнсодном “Бэнзийн үлгэрийн үүсэл хөгжил нь Хятадын сонгомол зохиолыг Монгол хэлнээ орчуулж нийтлсэн үетэй холбоотой юм” гэж хэлсэн нь маш зүйтэй ажээ. Хятадын туужисийн зохиол нь Сүн улс, Юань улсын үлгэрийн дэвтэрийн суурин дээр хөгжөөд Мин улс, Чин улсын үед хэлбэржин тогтсон байна. XVIII зуунаас эхлэн Монгол үндэстний орчуулагын ажил хөгжин мандаж Энэтхэгийн “Ганжуур” “Данжуур”- аас эхлэн Хятадын “Дөрвөн ном” “Таван бичиг” мэтийн сонгодог зохиолууд бүр Монгол хэлэн дээр орчуулагдаж эхэлжээ. Үүнээс гадна “Сахиус өргөмжилсөн шастир”, “Гурван улсын үлгэр”, “Тан улсын үлгэр” гэх мэт Хятадын үлгэрийн зохиол (бүлэгт роман) нилээдгүй орчуулагдан хуурын үлгэрийг авч уламжлан дэлгэрүүлж байв. Ялангуяа Тан улсын “Таван жуан” зохиолыг орчуулсан явдал бол “Бэнзийн үлгэр” Монгол оронд тархан дэлгэрсэн оргил үе нь байсан юм.

Б) Явган үлгэрээс үүсэлтэй:

---

<sup>1</sup> Н.Хөхшугуй. Тал нутгийн нүүдэл малжилын соёлын тэмдэг цуврал бичиг. Жарууд хошууны боть, ӨМШУТХХ, Хөххот., 2018 т 77



## THE CULTURAL WAY

Монгол газарт хуурын үлгэрийн үүсэл хөгжилд их гавьяа байгуулсан хүний нэг бол дархан хуурч Паажээ юм. Хуурын үлгэр нь түүний үзэхээр Чин улсын үед Хятадын түүх судар Монгол хэл дээр ихээр орчуулагдан тархагдсанаас Өвөр монголын зүүн орны хуурч ба үлгэрч нар Хятадын үлгэр түүхийг дөрвөн чихтэй хууртай хавсарган дуулах болжээ. Ингэж ярихдаа түүхийн гол агуулга баатар эрсийг тогтоон авч түүн дээрээ Монгол амьдралын ахуй, зан заншилыг шингээн баатарлаг туульс болгон өгүүлж, уран яруу айзамт холбоог гойд сайхнаар хослуулан хэлэх болов<sup>3</sup>.

В) “Бэнзийн үлгэр” болон цуурын үлгэрээс хойш бий болсон гэх үзэл:

Хуурын үлгэрийн бий болсон явц нь Монгол үндэстний уламжлалт дуу хөгжимтэй уусан нэгдэж бусад үндэстний хэрэглэж болох элементийг шингээн авч өөрийн үндэстний өвөрмөц урлагийн гэв намба төрхийг бий болгожээ.

Ци Жан Жу ( QI ZHAN ZHU ) Профессор “Хуурын үлгэрийн үүсэлийн явцыг шинжлэх нь” гэх өгүүлэлдээ “Бэнзийн үлгэр”, “цуурны үлгэр” болон “хуурын үлгэр” энэ гурвын үүсэл гарал нэгтэй гэсэн боловч хуурын үлгэрийн бий болсон цаг хугцаа нь “Бэнзийн үлгэр” ба цуурны үлгэрээс хойш үүссэн гэж үзжээ. Мөн энэ гурвын элементийн хоорондах дотоод харилцааг задлан шинжилжээ<sup>4</sup>. Ялангуяа цуурын үлгэр болон хуурын үлгэрийн ялгааг тайлбарласан байна. Хятадын дуурлиг урлагын төрөл зүйлтэй харьцуулсан үзэлт:

Хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийг Хятадын дуурлиг урлагын төрөл зүйлтэй харьцуулан судалсан эрдэмтэнд бол Дулаан, Хувьсгалт нар юм. Анх удаа харьцуулал хийсэн хүн бол Дулаан профессор ажээ. Түүний өгүүлэл “Зүүн Монголын Бэнзийн үлгэрийн тоглолтод Хятад үндэстний үлгэрт өгүүлэх урлагийн магтаал шүлэг ба ший жүжгийн үзүүлсэн нөлөө” гэсэн нэртэй ба “Монгол бэнзийн үлгэрийн тоглолтын уламжлал нь хэдийгээр Монгол баатарлаг туулийн аман уламжлалын суурин дээр бий болсон боловч үүсэн бүрэлдэх явц дундаа Хятадын үлгэр өгүүлэх урлагийн уламжлал болон ший жүжгийн нөлөөг зохих хэмжээгээр хүртсэн юм. Монгол бэнзийн үлгэр болон Хятадын үлгэр өгүүлэх урлагийн магтаал шүлэг нь өөр хоорондоо нөлөөлсөн байдал байх бөгөөд Хятад үндэстний ший жүжгийн тоглолтын урлагтай эх үүсэлийн холбоотай” гэж үзэв.

Тэгвэл харин Хувьсгалтын “Хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийн судалгаа” хэмээх докторын өгүүлэлд хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийн

<sup>2</sup> “Бэнзийн үлгэр” 本子故事- “Дэвтэрийн үлгэр” гэсэн утгатай хятад үг

<sup>3</sup> Н.Хөхшугуй. Тал нутгийн нүүдэл малжилын соёлын тэмдэг цуврал бичиг. Жарууд хошууны боть, ӨМШУТХХ, Хөххот., 2018 т 78

<sup>4</sup> Хятад үндэстний нэгэн төрлийн хэнгэрэг /Бөмбөр/ цохиод үлгэр ярьдаг урлагын нэгэн төрөл



## THE CULTURAL WAY

асуудлыг Монгол Хятад хоёр үндэстний аман болон бичгийн уран зохиолын харьцаан дээр гүн гүнзгий системтай судалгаа хийсэн юм. Түүний үзэхээр “XVIII зууны 30-аад оноос Хятадын олон бүлэгт роман тууж олон тоогоор Монгол хэлэнд орчуулагдсан нь хуурын үлгэрийн үүсэл хөгжилд ашигтайгаар нөлөлсөн бөгөөд XIX зууны сүүлч, XX зууны эхэн болоход олон тооны хуурч бий болж хуурын үлгэрийн хөгжлийн оргилд хүрсэн юм” гэжээ. Мөн өгүүлэлдээ өнгөрсөн үеийн эрдэмтдийн хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийг Хятад бичгийн уран зохиол, аман уламжлалын хэлбэрээр дэлгэрсэнтэй холбон судалж байсан уламжлалын суурин дээр Хятад аман уламжлалын өөр төрөл зүйлүүд болох үлгэр үглэх урлаг, хэнгэрэг дэлдэн хэлж дуулах урлаг, ший жүжгийн ая дан, сэдэв, хэвшсэн хэллэг зэрэг олон талаар хуурын үлгэрийн үүсэл бүрэлдэлд нөлөөлсөн гэдгийг анх дурьдаж, бодитой жишээнүүдийг дэлгэн үзсэн бөгөөд хуурын үлгэрийн судлалыг Монгол Хятад утга соёлын нэн өргөн хүрээнд авч үзэх боломжийг нээжээ<sup>5</sup>.

### Хоёр. Хуурын үлгэрийн үүсэл хөгжлийн соёлын тайламж

Соёл бол зөвхөн хүний нийгэмд байдаг онцгой үзэгдэл юм. Орчин үеийн Германы соёлын антропологич Ландманы үзэхээр "Хүн бол соёлын оршихуй юм. Даруй хүн бол соёлын бүтээгдэхүүн мөртөлөө соёлыг бүтээгчид" гэв. Хуурын үлгэр нь үндэстний соёлын үзэгдэл болохын хувьд түүний үүсэл хөгжлийн тухай соёлын тайламж хийх нь дамжггүй.

Соёлын үзэгдэл гэдэг нь цаг хугацаа, газар орон, зохих хүмүүсийн хамтаар илрүүлдэг соёлын онцлогийг хэлж байгаа бөгөөд эдгээр соёлын онцлог нь хүмүүс зохих түүхэн нөхцөлд хязгаарлагдан хөгждөг ажээ. Соёлын үзэгдлийг тайлбар хийхэд бид түүний үүссэн учир шалтгаан, нөлөөлөх хүчин тухайн болон түүний нийгэм, хувь хүнд үзүүлэх нөлөөг ойлгох хэрэгтэй. Хуурын үлгэрийн үүсэл хөгжлийн учир шалтгаан:

А) Гадаад шалтгаан - газар зүй, улс төр, нийгэм, аж ахуй, нүүдэлчин иргэдэд. Хуурын үлгэрийг танилцуулаад тэр бол Өвөр монголын зүүн оронд (Харчин, Горлос, Монголжин, Хорчин нутаг) зэрэгт өргөн дэлгэрчээ. Яагаад гэвэл орон зайн хувьд эдгээр газар нь Хятадын дотор оронтой хил залган оршдог юм. Чин улсын төрөөс хошуу чуулганы Хятад болон Монголын хэргийг хамаарах тэнхмийг байгуулсан ба атар газар хагалбарлах шинэ засгийн төрийн бодлоготой шууд холбоотой байжээ. Тус бодлогоор Монгол газар Хятад хүмүүс нэн өргөн хэмжээгээр нүүдлэн суурьшихын дагуу нийгмийн бүтэц, улс төрийн зохион байгуулалт, аж ахуйн хэлбэрийн талаар хувиралт гарсан бөгөөд үндэстэн хоорондын харилцаа холбоо хүссэнч эс хүссэнч олон

<sup>5</sup> Хувьсгалт. “Хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийн судалгаа. ( докторын өгүүлэл). Төвийн үндэсний их сургууль. Бээжин., 2013 т 12



## THE CULTURAL WAY

талаар явагдаж, соёлын хоорондох мөргөлдөөний дараа соёлын шинэ нэгэн үзэгдэл бий болж тэр нь улам бүр төгөлдөржин хөгжсөн байна.

Б) Дотоод шалтгаан - хувь биеийн хувират, хөгжлт, өөрчлөлт: Монголчууд эрт дээдийн үеэс хэлж дуулж ярьдаг уламжлалтай. Жишээлбэл: “Монголын нууц товчоо”-д Чингис хаан тэнгэрт хальж, түүний алтан шарилыг эх нутагт нь буцаан авч явах замд хасаг тэрэгний бул нь шаварт шигдсэнд Сөнөдийн Гилүгэтэй баатарын өчсөн үгэнд “Хуур цуур хөг дуу чинь, Хотол бүгд улс чинь” бий. Хуурын үлгэр нь үндэстний урлагийн уламжлалын суурин дээр Хятад аман уламжлалын өөр төрөл зүйлүүдийг шингээн авч өвөрмөц аман урлагийн хэлбэр болсон юм. Үүнээс гадна холилдон суурьшисны үр дүнд үндэстний хоорондох харилцаа олширч Монголчуудын хүлээн авах чадвар болон сэтгэлгээний тал дээр тун их өөрчлөлт гарсан байна.

### 2. Хуурын үлгэрийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйл

Хуурын үлгэрийн үүсэл хөгжлийн шалтгааны тухай дотоод, гадаад хоёр талаас нарийн шинжилгээ хийсэн зүйл бас байна. Олон тооны өөр үндэстний сонгодог бичиг, түүхэн бичмэл, ном судар зэргийн орчуулах ажил нэмэгдсэн ба бас соёлыг холбогч, уламжлагч нарийг дурдахгүй байж болохгүй юм.

XVIII зуунаас эхлэн Монголчуудын орчуулагын ажил хөгжин манджээ. Олон янзын бичиг үсэгээс (Санскрит, Төвд, Хятад) Монгол хэлэнд булган туурвив. Жишээлбэл: “Ганжуур”, “Данжуур”, “Дөрвөн ном” “Таван бичиг” “Сахиус өргөмжилсөн шастир” “Гурван улсын үлгэр” “Тан улсын үлгэр” гэх мэт байна.

Монгол хэлэнд орчуулагдсан Хятад зохиол болон түүхэн уламжлалт яриаг дэлгэрүүлэгчдийн нэг нь лам хүмүүс байсан байдаг. Монголжин Гайхамшигт зохицуулагч сүм буюу "Гэгээн сүмийн" бичиг соёлтой лам нарын хийсэн ажлуудыг дурдаж болно. Бүр зарим нь өөрсдөө хуурч хүмүүс байжээ. Мэргэн цэцэн Монгол ардын хуурчдын идэвхи санаачилгаар өөр үндэстний уран зохиол, түүхэн бичиг, тууж, баатарлаг туулсийг орчуулж бүтээлчээр шингээн авч дөрвөн утаст хуураар хөгжимдөн, ярьж, дуулахаар дамжуулн өвөрмөц аман урлагийн хэлбэрийг бий болгожээ.

### ДҮГНЭЛТ

Аливаа соёлын шинэ үзэгдэл бий болоход заавал зохих соёлын нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Монгол нутаг дахь хуурын үлгэрийн хөгжилт нь 200 гаруй жилийн түүхтэй ажээ. Түүний үүсэл хөгжил нь ямар нэгэн тогтсон цагт гэнэтээр бий болсон биш, харин зохих соёлын нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр алгуур аажмаар үндэстний соёлын тогтолцоо болон төлөвшжээ.



# THE CULTURAL WAY

## ABSTRACT

The Tale of Khur is the work of something in the intellectual culture of the Mongolian people. It is an intangible heritage that manifests itself through sounds created from the human mind. In writing this article, a research materil on the origin and development of the fiddle tale was compiled and analyzed by categorizing the views of the strikers from three perspectives. Cultural reports have been made by dissecting the causes of the origin and development of the fiddle from both internal and external aspects.

Keywords: *The Tale of Huur, origins, state of research*

## НОМ ЗҮЙ

- 1.XIE XIU YUN. “Хуурын үлгэрийн хорчин нутагт үүссэн учир шалтгаан”. Улаахадын дээд сургуулийн сэтгүүл. 2008
- 2.ZHAO YU HUA. “Хуурын үлгэрийн судалгааны шинэ хандаш”. Өвөр монголын үндэстний их сургуулийн сэтгүүл. 2016
- 3.QI ZHAN ZHU. “Хуурын үлгэрийн үүсэлийн явцыг шинжлэх нь”. Өвөр монголын их сургуулийн урлагийн дээд сургуулийн сэтгүүл. 2016
- 4.JU BAO. “Монгол улсад хадгалагдаж байгаа мин чин гүрнийн туужийн орчуулга болон түүний судалгааны өртөг”. Манжийн судалгаа. 2016
- 5.CHEN GANG LONG. “Зүүн монголын Бэнзийн үлгэрийн тоглолтод Хятад үндэстний үлгэр өгүүлэх урлагийн магтаал шүлэг ба ший жүжгийн үзүүлсэн нөлөө”. Өвөр монголын их сургуулийн сэтгүүл. Хөххот. 2005



ХАРЬЦУУЛСАН УТГА ЗОХИОЛЫН ТАЛ ДАХЬ Н.ӨЗЛИЙБАТЫН НАЙРУУЛЛЫН  
ЕРТӨНЦ

Кань Хай Ин\*

## ХУРААНГУЙ

Харьцуулсан утга зохиол судлал хийгээд монгол найруулалд харьцуулсан утга зохиолын тухай, монгол найрууллын тухай, соёлын харьцууллын тал дахь “Холын цэнхэр Токио”-г эд өглөгийн соёл, үйл ажиллагааны соёл, оюуны соёл, байгууламжийн соёлын харьцуулал зэрэг талаар задлан өгүүлж, өнгөрсөн ба өнөөгийн харьцуулал – “Аав нутаг хоёр”-ыг өнгөрсний дуртгал ба өнөөгийн тусгал болсон намтарчилсан шинжтэй найруулал – Аав нутаг хоёр, өнгөрснийг эдүгээ шиг болгосон дүрст найруулал – “Мөөрүү Мөөрүү шүрэн хад” гэх хэдэн талаас шинжлэх болно.

Түлхүүр үгс: *Харьцуулсан утга зохиол, монгол найруулал, Н.Өзлийбат, урлагийн ертөнц*

Нэг. Харьцуулсан утга зохиол судлал ба монгол найруулал

*(Нэг) Харьцуулсан утга зохиолын тухай*

Харьцуулсан утга зохиол бол соёл судлал ба соёл судлалаар суурь болгосон уран зохиолын судлал болно<sup>1</sup>. Харьцуулал бол товчлон хялбарчилсан чөлөөтэйгээр ямарваа хоёр зүйлийн бодисыг зэрэгцүүлэн тавиад харьцуулдаг биш, харин нэг зүйлийн эдүгээч соёлын шаардлага хийгээд эдүгээч шинжилгээний үзэл санааны аргын хэлбэрлийг төлөөлж байдаг<sup>2</sup>. Өнгөрсөн зууны 70-аад оны сүүлч, 80-аад оны эхээр харьцуулсан утга зохиол дундадын их хуурайд дахин шинээр хөгжихийг дагалдан, дундад гадаадын утга зохиолын харьцаа улсын дотоод дахь харьцуулсан утга зохиолынхны дундад улсын утга зохиолынхны жич гадаадын утга зохиолынхны судалгаанд маргаантай асуудал болж байв<sup>3</sup>. Харьцуулсан утга зохиолын агуулга нь даруй

\* Өвөр Монголын Их Сургуулийн, Монгол судлалын дээд сургуулийн багш

*Судалгааны чиглэл: Харьцуулсан уран зохиол ба дэлхийн уран зохиол*

<sup>1</sup>黎跃进著:《比较批评与比较文学》, 东方出版社, 2002年, 第24页。

<sup>2</sup>陈跃红著:《比较诗学导论》, 北京大学出版社, 2005年, 第24页。

<sup>3</sup>谢天振:《中国翻译文学史实践与理论》,《中国比较文学》, 1998年第二期, 第2页。



## THE CULTURAL WAY

“хоёр төрөл буюу олон төрлийн утга зохиолын хоорондох харьцааны судлал болно<sup>4</sup>.”

Харьцуулсан утга зохиолд хатуу нямбай баг нотлолыг хүндэтгэдэг францын “Нөлөө судлал”-ын бүлэг ба огтлолцол үүсдэггүй хоёр өөр утга зохиол дахь адилавар элементийг судалдаг АНУ-ын “Зэрэгцээ судлал”-ын бүлэг гэх хоёр том сургаалын бүлэг байдаг<sup>5</sup>. Жие Шяньлин: “Цөөн тоот үндэстний утга зохиолыг улсын гаднахтай адилтган судлахаар барахгүй бас дундад улсын дотоодын бүх үндэстний хооронд нь адилтган судалвал зохино. Дундад улсын хил хязгаар дотор байгаа бүх үндэстний утга зохиол нь хоорондоо салшгүй нягт харьцаатай байдаг<sup>6</sup> гэжээ. Харьцуулсан уран зохиол бол шинэ цаг үеийн хүмүүнлэг үзлийн бэлгэ тэмдэг ба хошууч мөн. Харьцуулсан уран зохиол нь бодит хэрэг явдлын холбоог хувь хүний үе бүтэмжийн түүх болгон тоочдог. Иймээс онтологи нь оршиху олдог учраас тусгаар биеэ даасан шинжилгээний салаа болсон байна<sup>7</sup>. Харьцуулсан уран зохиол бол хүүрнэл зүйн бодитой хэрэглээ мөртөө түүний амьдлэг жишээ болно.

Харьцуулсан утга зохиол нь үндэстний утга зохиолын судлалаас салж дийлэхгүй, үндэстний утга зохиолын судлал нь мөн харьцуулсан утга зохиолын судлалаас салж чадахгүй. Иймээс харьцуулсан утга зохиолын судлалаас салвал цөөн тоот үндэстний утга зохиолын бодгаль чанарын үнэ цэн хийгээд нийгмийн утга агуулгын сүвэгчлэл гүнзгийрэхийн аргагүй болдог. Харьцуулсан утга зохиол 19 дүгээр зууны сүүлч үед үүсэж, орчуулгын ухаан 20 дугаар зууны 30-аад оны үед үүсэж, 50-аад оны сүүлээр чухал байр суурийг эзлэх болжээ<sup>8</sup>. Харьцуулсан уран зохиол нь бодитоор авч хэлбэл, харьцуулсан уран зохиолын арга барилыг багтаасан бүх зүйлийн судалгааны арга нь судалгааны ай саваар дамжвал сая, онцгойлон их бага бүх талын судалгааны төрөл жанр нь нэн сайнаар судалгааны барилдахуундаа үйлчлэх болно. Харьцуулсан уран зохиол нь нийгмийн шинжлэх ухааны нэг зүйлийн бодит салаа мөчир учраас нийгмийн шинжлэх ухааны бүхий л зураг сүүдэр болно.

Соёл алсалсан судлал, онцгойлон өрнө дахин, дорно дахин, өөр бусад үндэстний өөр чанар бүхий соёлын судалгаа бол харьцуулсан утга зохиолыг хямралаас эргэлтийн шатанд хүргэх нэгэн удаагийн маш чухал сэдэвлэлт мөн. Мөн бүх дэлхийн харьцуулсан утга зохиол судлалын нэг удаагийн гүн хол утга агуулгатай сөргөлдөх бодлогын шинж чанартай аугаа их эргэлт мөн. Харьцуулсан уран зохиол бол хоёр зүйл буюу олон зүйлийн уран бүтээлийн ялгаа зөрөөг ялгах төдий биш, харин уран зохиолын харьцууллын аргын онол мөн. Эн тэргүүнд нэг зүйлийн судалгааны төрөл жанрын бүрэлдэх нь зохих судалгааны арга барилтай цус махан харьцаа холбоотой болдог. Харьцуулал бол хүн төрөлхтний сэтгэхүйн үндсэн арга барил бөгөөд энгийн судалгааны

<sup>4</sup> (美) 勒内 韦勒克 奥斯汀 沃伦著: 《文学理论》, 江苏教育出版社, 2005 年, 第 42 页。

<sup>5</sup> 陈 惇、孙景尧、谢天振主编: 比较文学, 高等教育出版社, 2004 年, 第 62 页。

<sup>6</sup> Намжил. Монгол домгийн харьцуулсан судлал. БЭҮНХХ., 2001 т 12

<sup>7</sup> 陈跃红、张辉、张沛主编: 《乐在其中 乐黛云教授八十华诞弟子贺寿文集》, 北京大学出版社, 2011 年, 第 317 页。

<sup>8</sup> 谢天振著: 《译介学》, 上海外语教育出版社, 1999 年, 第 2 页。



## THE CULTURAL WAY

аргын нэг зүйл болно. Харьцуулсан уран зохиолын шинжилгээний салаа нь 20 дугаар зуунд бүрэлдэж, харьцуулсан задлалын ухаан, физиологийн ухаан, гүн ухаан, шашны ухаан, хэл шинжлэл зэрэг хамаа бүхий шинжилгээний нөлөө тусгал ба сэнхрүүллийг хүртсэн байна. Хэдийгээр дан ганц энэ шинжилгээний нэрийдэл тус бие, харьцуулсан уран зохиол лугаа нягт чанга харьцаа холбоог таньж чадна. Хэрэг дээрээ харьцуулсан уран зохиол бий болсон цагаас эхлэн судалгааны төрөл зүйл нь харьцуулал судлалаар цорын ганц судалгааны арга болгодоггүй. Яриангүй үндэстэн, соёл, хэл хийгээд шинжилгээний салаа алсалсан судалгааны төрөл зүйл болсны хувьд харьцуулсан уран зохиол нь бодит судалгааны үйлдэл дунд үргэлж адил бус талыг хөөцөлдөх харьцуулсан судлал гэх хэрэгтэй.

Харьцуулсан утга зохиолын үндсэн нэг үүрэг бол даруй бүх үндэстний утга зохиолын хоорондох харилцаа холбоо, харилцан нөлөөлөхийг судлах явдал болно<sup>9</sup>. Бодит арга барилын давхаргаас үзвэл, харьцуулсан уран зохиол судлал нь уран зохиолын судалгааны чухал нэгэн ай сав мөртөө түүнд шууд орох арга зам мөн. Энгийн уран зохиол судлалын арга бол голдуу улс ялгалын утга зохиолд тохиролцох судалгааны арга болно. Үүнд уран зохиолын түүх, онол, шүүмжлэл зэргийн судалгааны арга барил ба зарчим байдаг. Дараа нь харьцуулсан уран зохиолын судалгаа болсны хувьд, судлаачдыг соёл алсалсан, дэлхийн хэмжээнээс асуудлыг шинжлэх, судлах хэрэгтэй. Харьцуулсан уран зохиолын арга барилаар асуудлыг шийдвэрлэх, үүнд бүх зүйлийн харьцуулах арга барилыг багтаана. Жишээ нь, хэлний харьцуулал, хүүрнэл хэлэхүй хийгээд найруулгын харьцуулал, санаа дүрийн харьцуулал, стиль төрлийн харьцуулал, гол сэдэвлэхүүний харьцуулал, шинжилгээний салаан харьцуулал ба хэрэглээ, онолын гэдрэг ажилалтын хувь биеийн тодорхойлол ба харьцуулал зэрэг багтдаг. Олон төрлийн харьцууллын явцад, адил бус үндэстэн ба адил бус соёлын уламжлалын зарим уран зохиолын ялгаа зөрөө ба онцлог, урлагийн хэлбэр, өртгийн хэлбэрэл, гоо сайхны таашаал зэрэг нь тодорхой ялгаран гарч ирдэг. Эдгээр зөрөө хийгээд онцлог нь цул улс ялгалын утга зохиол судлалыг мэдэж чадахгүй. Хамгийн эцэст, гүн утгын харьцуулсан уран зохиолд авч хэлвэл, тэр нь ялгаа ба онцлогийг илэрхийлэхэд ханах биш, адил бус соёлын уран зохиол лугаа зарим зууч хэлэхүй ба онолын хамтач чанар 共相性, хүн төрөлхтний хөгжилтийн хамтач чанартай хамаа бүхий уран зохиол ба соёлын жам ёс ба нийтийн чанартай онцлогтой байдаг.

Харьцуулсан уран зохиол нь шинжилгээний салаа болсны хувьд европоор төв болгосон газар орон ба соёлын тойргоос даван гарч, бүх дэлхийн олон ишт соёл хийгээд уран зохиолын харьцааны сүвэгчлэл жич соёл алсалсан шинжилгээний салаа сундалсан хандлага жинхэнэ харьцуулсан уран зохиолын утга агуулгаас дэлхийн бүх үндэстний уран зохиолтой холбогдол бүхий уран зохиол ба соёлын асуудлыг судлах болно<sup>10</sup>. Өөр соёл бүхий уран зохиолын хоорондох соёл солилцоо, нэвтрэлцэл ба харьцууллын зорилго нь түүхийн бодит хэргийг тэмдэглэснээр барахгүй, адил бус уран зохиолын хоорондох харилцан зөвшөөрөл, ойлголцол, толь болгох, нөхвөрлөх, адил бус соёлын ар

<sup>9</sup> 乐黛云、王向远著：比较文学研究，福建大学出版社，2006年，第5页。

<sup>10</sup> 黎跃进著：比较批评与比较文学》，东方出版社，2002年，第188页。



## THE CULTURAL WAY

үзэгдлээс гардаж, хүн төрөлхтний халамжилж байгаа хамтын асуудалтай нүүрдэх хэрэгтэй байдаг<sup>11</sup>. Дундад улсын харьцуулсан уран зохиол нь үндсэндээ нэг зүйлийн соёлын үзэгдэл, хүн соёлын үзэгдэл, харьцуулсан уран зохиол ба дундад улсын уран зохиол нь уламжлалаас эдүгээч эргэлтэд хүрэхтэй нягт харьцаатай байж, нэг зүйлийн үзэлт, харц, хараас, түүний бий болсон нь дундад улсын уран зохиолын битүүмжилсэн байдал эцэслэж, дундад улсын уран зохиол ухамсартайгаар дэлхийн уран зохиол дунд уусах, дундад улсын уран зохиол дэлхийн уран зохиолтой адил тэгшээр ярилцах болсон байна<sup>12</sup>. Харьцуулсан уран зохиол бол нэг зүйлийн төрөлжүүлсэн хэлбэрэл товойм уран зохиолын шинжилгээний салаа болно<sup>13</sup>. Харьцуулсан уран зохиол бол уран зохиолын харьцуулал биш, харин тэдгээрийн хоорондын харьцаа, бодит хэргийн харилцаа зэргийг судалдаг<sup>14</sup>. Харьцуулсан утга зохиолын аргын онол ба судалгааны арга барил нь монгол уран зохиолын бодитой судалгааны үйлдэл дунд өдөр ирэхүйеэ чухалчлагдан хүндэтгэгдэх болов. Харьцуулсан утга зохиолын үзэлт бол уран зохиолын дэлхийн солилцоо, харилцан харилцаа, уран бүтээлийн задлан тайлбарлахыг улам гүнзгийрүүлэх явдал<sup>15</sup> болно.

Дундад улсын орчин үеийн хятад найрууллын талаар 1921 онд Жөү Зуорэнь “Гоё зохиол”-сул тэмдэглэл, шог найруулал, энгийн найрууллыг нийтэлсэн байна. 5.4-ийн үед Жөү Зуорэнь-ий найруулал нь өвөрмөц онцлогтой байдаг. Үүнд нэг хэсэг нь бодит ахуй, нийгмийн тухай шүүмжлэл юм. Нөгөө нэг хэсэг найруулал нь тэмдэглэлт чанартай шог найруулал болно. Түүний дотор бас шилдэг бүтээл бий. Уужуу талбиу багс бийрээр нутаг усны хайр сэтгэлийг илтгэж, тунгалаг эхүүн амтаар 5.4-ийн найруулал дунд өөрийнхөө өвөрмөц онцлогтой байдаг. Түүний тэмдэглэл нь ч элбэг мэдлэгт чанартай, эвтэйхэн хэлж зүйд нь нийцүүлэх онцлог бий. Харин эдгээр шог найруулал нь үргэлж зарим нутгийн эрх бүхий ангийн сул ярилцах өнгө аяс ба эртнийг дурсах гүн сэтгэлгээг хөдөлгөдөг<sup>16</sup>. Гоё зохиолын хэлний гоё нь гоё үгсийг цуглуулж хэрэглэхэд байх биш, утгаа зөв оновчтой илтгэж чадах аль тохиромжтой үгсийг эрж олоод санаагаа тодорхой сайхан бичиж илтгэсэнд байх юм<sup>17</sup>. Жү Зычин-ий “Лянхуат нуурын сарны туяа” нь найрууллын амин сүнс болох – сэтгэлгээгээр ялах бодлого авсан байна. Уянгалахаар үндсэн хөг аяс болгож, бодит ахуйн тайван бусаас гардаж, эрхэм ариун лянхуа цэцэг ба гоонь цэвэр сарны гэрлээр хүний амьдралын гуниг уйтгараас ангижрах сэрэгдэл, нам жим үзэмжээс түр зуур ч гэсэн зугтах хэтийдлийн үзэл сэтгэлгээг илтгэсэн байна. Лү Шюнь-ий “Зуун өвсөт цэцэрлэгээс амтат бичгийн бүүрэг хүртэл”, Мао Дунь-ий “Цагаан улиасны магтаал”, Ян Шуо-ийн “Биржгэр луун нүдний бал”, Лю Байюй-ийн “Наран мандахуйяа” зэрэг

<sup>11</sup> 黎跃进著：《比较批评与比较文学》，东方出版社，2002年，第81页。

<sup>12</sup> 乐黛云、王向远著：《比较文学研究》，福建大学出版社，2006年，第6页。

<sup>13</sup> 黎跃进著：《比较批评与比较文学》，东方出版社，2002年，第142页。

<sup>14</sup> 杨乃乔主编：《比较文学概论》，北京大学出版社，2006年，第175页。

<sup>15</sup> (日) 渡边洋著，张青编译：《比较文学研究导论》，中国社会科学出版社，2007年，第15页。

<sup>16</sup> 张菊香著：《鲁迅、周作人、胡适》，南开大学出版社，2017年，第109页。

<sup>17</sup> Линсе. Найрууллын тухай. ӨМСХХХ., 1997 т 33



## THE CULTURAL WAY

олон найрууллууд бий. Найруулал богино бөгөөтөл гүн, энгийн бөгөөтөл далд, зөрчилт дүргүй бөгөөтөл тамирлаг байдаг гүн агууламжтай байна.

Зэрэгцээ судлал нь уран зохиолын гол сэдэв, зохиолын баатар, үйл явдал, арга мэргэшил, санаа дүр, хэм хэмжээ бас уран зохиолын төрөл зүйл, уран зохиолын түүхэн дээрх цаг хугацаачлал, үзэл урсгал, хөдөлгөөний харьцуулал нь зохиогч, зохиол бүтээлийн бүх талын харьцуулал болно<sup>18</sup>. Зэрэгцээ судлал нь нэгд-адилтгал, хоёрт-харьцуулал, үүнд гол сэдэв, сэдэвлэхүүн, баатар, үйл явдал зэрэг хэлбэр, онтологи, хэв маяг, хүүрнэлийн загвар гэх мэт багтана<sup>19</sup>. Харьцуулсан уран зохиолын зэрэгцээ судлалын харьцаа дунд, адил бус үндэстний уран зохиолын хоорондох харьцаа бол нэг зүйлийн үндсэн эхлэлтийн цэг юм. Иймээс адил бус үндэстний уран зохиолын зэрэгцээ харьцаа зэргийг тодолсны суурин дээр адил бус хэлний төрлийн уран зохиолын хооронд адил бус соёлын уран зохиолын хооронд, адил бус улсын уран зохиолын хооронд өөр өөрөө зэрэгцээ мөн чанарын харьцаа болж бүрэлдэж болдог гэдгийг мэднэ. Уран зохиолын зэрэгцээ мөн чанарын судлалын хүрээ хэмжээнд багтааж, харьцуулсан уран зохиолын хүрээ хэмжээнд багтааж ойлгоно. Доор монгол найрууллын үүсэл төлөвшил, хөгжлийн тухай ажиглаж болно.

### *(Хоёр) Монгол найрууллын тухай*

Найруулал бол сэдэв материал өргөн хэлбэр чөлөөтэй байдаг. Мөн амьдралын үнэн ба сэтгэлгээний үнэнийг тусгахаараа бусад стиль төрлийн зохиолоос ялгагдана. Найруулал нь хэлбэрийн талаар хүлээсгүй чөлөөтэй, үнэнийг тэмдэглэх мөртөө санаа ахуй ба сэтгэлгээний уянгаллыг эрхэмлэдгээрээ уншигчдад гоо таашаалын сонирхлыг өгдөг<sup>20</sup>. Монгол найрууллын үүсэл төлөвшлийн талаар Монголын нууц товчоонд бичсэн түүхэн хүн ба хэрэг явдлыг бичсэн Наху хуны байлдаан, Алунгуа зэрэг нь биеэ даасан найрууллын зохиолоор сонгож болно гэж үздэг. 19 дүгээр зууны дунд үеийн Инжинаашийн Чулуун дэрийн шүүмжлэл, Номчийн хуурмаг, Буяндэлгэрийн Үйлийн үр, Монгол хүн буянаар, Эрдэнэтогтохын Ирээдүйн монгол ийм бололтой, Ролгаржавын Үзэмчний давсан нуур гэх мэт, 20 дугаар зууны 30-аад онд Сайчунгаан өдрийн тэмдэглэлийн хэлбэрт Элс манхны эх нутаг, захидлын хэлбэрт Манай монголын мандах дуу гэх хоёр найруулал бол монгол найрууллын бүрэлдэн төлөвшсөний бэлгэ тэмдэг болно. Монгол найрууллын хөгжлийн шат үе хуваарилалын талаар:

1. Буянтогтох, Б.Сүхийн Орчин үеийн уран зохиолын орчин 2008, Соёлын их хувьсгалаас өмнөх 19 жилийг нэгдүгээр шат, хувьсгалын 10 жилийг хоёрдугаар шат, дараах шинэ цаг эринийг гуравдугаар шат гэж хуваана.

2. Жаргалын Утга урлагийн алтан намар, өөртөө засах орон байгуулагдсан анхны 10 жилийг нэг, 1957-1966 он хүртэлхийг хоёр,

<sup>18</sup> 陈惇, 刘象愚: 《比较文学概论》, 北京师范大学出版社, 2004年, 第124页。

<sup>19</sup> 孟昭毅: 《比较文学通论》, 南开大学出版社, 2003年, 第167页。

<sup>20</sup> Вэнь Лань, Дорнотэнгэр. Шинэ эриний монгол найруулал. ӨМБИСЭШС., 2020 №1 т 18



## THE CULTURAL WAY

хувьсгалын 10 жилийг гурав, дөрвөн хүний бүлгийг бут ниргэснээс нааш шинэ үеийн 10 жилийг дөрөвдүгээр шат гэж хуваажээ.

3. Н.Өлзийбатын Монгол найрууллын тухай сэтгэгдэл гэх өгүүлэлд монгол найрууллын хөгжлийн талаар, улс байгуулагдсанаас соёлын их хувьсгал хүртэл, хувьсгалаас 80-аад он хүртэл, 80-аад оноос өнөө хүртэл гэж гурав хуваав.

Найруулал бичихэд орон зай, цаг хугацааны системд төдий баригддаггүй харин сэтгэлгээний систем “сүүгээс сүрэг, сүргээс бэлчээр, бэлчээрээс цэцэг” буюу эндээс тэнд, тэндээс энд гэх мэт үсрэлтийн шинжээр хатуу байх чөлөөт сэтгэхүйн зай дотор хэлбэржүүлдэг билээ<sup>21</sup>. Найруулал нь утга санаагаа тогтоох, зохиомж найруулгаа төлөвлөж, арга барилаа хэрэглэх ба хэл хэллэгээ найруулах энэ бүхэнд тав чөлөөтэйгээр шинийг өгдөг<sup>22</sup>. Монгол найруулал нь утга сэдвийн талаар хүрээ хэмжээ нь ихээхэн тэлэлт ба гүнзгий байдаг.

Нэг, Эгэл хүний жирийн амьдрал, ороо бусгаа он жилүүдийн зөвхөн хөвөх хувь заяа, дотоод сэтгэлгээний баяр жаргал, гуниг уйтгарыг үнэн мөнөөр нь нэн агуучаар бичих болсон. М.Асарын Суга таяг чичүүр мод, Лигдэний Миний гэрийн бууц, Б.Зоригтын Тариан үзүүрийн нэг годил тамхи зэрэг болно. Хоёр, Үндэстний хувь заяа, монгол соёлын мандал бууралд тунгаалт бодлогошрол хийсэн хүнд чихмай түүхэн найруулал ба соёлын найруулал, гүн ухаанч найрууллууд, Мянгад Эрдэмтийн Ертөнцийн хязгаар дахь сарны гэрэл, Тэнгэр газрын дунд босоо явсан монголчууд, Алтанбаганын Цахар найман хошуу, Монгол ван, Б.Пэрлээгийн Хулганаас зугтах муур ба туулайнаас зугтах нохойн учир зэрэг. Гурав, элсэргээцэл амь ахуйн тэнцүүр алдал, монгол соёлын хүчирдэл гачигдал зэрэг нийгмийн асуудалд чиглэгдсэн ба үндэс шалтгааны тухай задлан шинжилж, санаа алгассан найруулал, Р.Эрдэмтийн Гурван зуун жил хожимдсон ухаарал, Эрдэнэбаганын Өвөр монголын элсэн шуурга, Д.Баатарын Эх улс буюу нэгэн говь зэрэг. Дөрөв, хурц ширүү дайчин зориг санаатай, ёс ярьж, шүүмжлэн хэлэлцсэн шүүмж найрууллууд, Г.Шаравжамцын Монголчууд ирэх зууны босгон дээр, Жигдийн Адил сэтгэлгээн цуурай, Боржгин Хурцын Үг хэл ба монгол соёлын оршин тогтнол зэрэг. Тав, өөрчлөлт хийж чөлөөтэй харилцах болсноор гадаад гүрэнд ажиллаж суралцах завшаантай болж, харь соёлыг хүлээн хөгжсөн нийгмийн харцаар нутаг орноо тольдсон найрууллууд бичигдэв. Эдгээр нь өнгөрсний гадаад гүрнээр айлчилж зугаацсан аяны тэмдэглэлээс огт өөр бичиж, голдуу үндэстэн ба улс орны хоорондын соёлын харьцуулал байдаг. Н.Өлзийбатын Холын цэнхэр токио, Төгсбаяр Бөхчулуу Номинтой нарын найрууллыг дурдаж болно. Зургаа, Хүний дотоод сэтгэлийн гүн зүг нэвтэрч, дотоод сэтгэлийн зөрчил мөргөлдөөн нууцлаг эмзэг нарийн далд мэдрэмжийг бичих болсон<sup>23</sup>. Өлзийбатын найруулал нь оюуны солонгон цэцэгсийн дунд өөрийнхөө хэв маягийг бүрэлдүүлсэн байна.

<sup>21</sup> Одон. Найруулал судлал хийгээд зохион бичлэг. ЛяҮнХХ., 1996 т 258

<sup>22</sup> Линсе. Найрууллын тухай. ӨМСХХХ., 1997 т 12

<sup>23</sup> Н.Өлзийбат. Хайр ба харилцаа-Монгол найруулын тухай сэтгэгдэл, т 95





Хоёр. Соёлын харьцууллын тал дахь Холын цэнхэр Токио

Соёл бол хүн төрөлхтний оюун ухаан болон үйл ажиллагаагаараа аливаа барилдахууны жам хуулийг илүүлэн зохицож, түүнийг ашигласан хэмжээ жич үр бүтээлийн органик бүтэн цогцыг хэлнэ. Өнөө болоход соёл судлал нэгэнт шинжилгээний салбар болж тусгаар биеэ даасан судалгаа болж тогтнов. Нэлээд их дээд сургууль ба тусгай байгууллагад соёл судлах газар байгуулагдаж (Бээжин их сургуулийн соёл судлах төв, Улаанхадын дээд сургуулийн соёл судлах төв) бүх талаар эрчимтэй судлал өрнүүлж байна. Манай улсад шинжилгээн салааны утга дахь соёл судлал 80-аад оноос ид хөгжив. 30-аад жилийн турш дундад өрнөд соёлын харьцуулсан судлал, дундадын эрт эдүгээх соёлын судлал, тусгаар аль нэг үндэстний соёл судлал, тусгай ямар нэгэн төрлийн соёл судлал гэх мэт өргөн дэлгэр хүрээнд шинжилгээ явуулж байна. Хүн жич үйл ажиллагааны барилдахууны харьцааны дундаас соёл үүсэж хөгждөг байна<sup>24</sup>.

Найруулал нь оюунч шинжтэй төрлийг хэрэглэж эдүгээ ярьдаг. Өргөлтөт шүлэг нь найруулалтай тун ойролцоо байдаг<sup>25</sup>. Найруулал нь шүлэг шигээр сэтгэлгээний өргөцийг дамжин санаагаа илрүүлдэг. 80-аад оны дундад улсын найрууллын хөгжил нь 50, 60-аад оны үед бүрэлдсэн онтологийн загварын хүлээслэлийг хүртэж байдаг. Иймэрхүү загвар нь ердөө багаар ихийг харуулах, үзэмж бодисоор сэтгэлгээгээ илтгэх арга хэлбэрээр цаг үеийн зориг санаа ба нийгмийн үзэл урсгалын гол сэдэвлэхүүн ба бүтцийн хандаштай ойртож, найрууллын шүлэгжих ба санаа ахуй бүтээхийг хөөцөлддөг<sup>26</sup>. 80, 90-ээд онд бүтээсэн найрууллын чухал нэг үзэгдэл бол хүмүүсийн сэхээтний найруулал эсвэл соёлын найрууллын хэлбэр болно. Иймэрхүү найрууллын зохиогчийн олонх нь хүн соёлын шинжээчдийн эсвэл нийгмийн шинжлэх ухааны судлаачид болно. Тэнд тусгай мэргэжлийн судалгаанаас гадна судлаачдын оюунч бодолхийлэл ба хувь хүний сэрэл мэдрэмжийг илтгэсэн зохиол туурвидаг<sup>27</sup>.

Соёлын найруулал хэмээх нэрийдэл улсын дотоодод өнгөрсөн зууны 80-аад онд бий болжээ. Манайд 80-аад оны үед ийм тодорхой нэрийдэл байсангүй ч Пэрлээ, Жамьяан нар нэгэнт анхны суурийг тавьсан байлаа. 90-ээд он болоход соёлын их орчин, хот, хошуу сум гэх мэт орон даяар шуугин босгосон соёлын салхи лугаа цуурай авалцаж хүмүүсийн соёлын ухамсар сэргээхийг дагалдан соёлын найруулал аяндаа бий болжээ. Илрүүлэх этгээд бусдач цогцоо соёлын талаас эзэмшиж нэн илүү соёлын агуулахууныг ачаалсан найрууллыг соёлын найруулал гэдэг. Шаравжамц, Алтанбагана, Гомбожав, Сэцэндалай, Бөхбаатар, Түмэн-Өлзий, Унага, Дайчин, Хүнбус нар нэг талаар угийн түүхээ эргэж үзэх ахиж харуулах төдий утга чиглэл

<sup>24</sup> Сүег. Монголчуудын эргний соёл ухамсрын арван тайлан. ӨМАХХ., 2012 т 17

<sup>25</sup> 维柯著, 朱光潜译: 《新科学》, 安徽出版集团, 2006年, 第273页。

<sup>26</sup> 洪子成: 《中国当代文学史》, 北京大学出版社, 1999年, 第369页。

<sup>27</sup> 洪子成: 《中国当代文学史》, 北京大学出版社, 1999年, 第377页。



## THE CULTURAL WAY

тогтонгуйрч байсан түүхэн найрууллыг соёл, нийгэм, гүн ухааны гэх мэт олон талаар хөгжүүлж түүхэн сэдвийн соёлын гэрэл гялбааг улмаар бадруулав.

Нөгөө талаар түүхэн гүн сэрэгдлээс иш авч бодит ахуйдаа шууд тулан тоост иргэншлийн хэм архаг, туургат үндэстний эмзэг согогийг хайр найргүй илчилж, шүүмжилнэ. Голчлон үндэстний соёл, угсаатны хувь заяанд тусгав. Н.Өлзийбат найрууллын тоог хөөцөлдөх бус, чанарыг эрхэмлэнэ. Өгүүлэн буй бүтээлээрээ зуучлалын уран зохиол дахь аяны тэмдэглэл, айлчилсан тэмдэглэлд хүргэсэн анхны зохиолч, харь айл хийгээд өөр нутгийн харилцан толидол дунд үндэстнээ соёлоо өөрийгөө дахиж таних буюу өртөөлөх уран зохиолын үйлдлийг бүтээлчээр өрнүүлэгч<sup>28</sup>.

Япон бол аж ахуйн хүчээр дэлхийн хоёрдугаарт орох хүчирхэг гүрэн юм. Аж ахуйн хөгжил нь соёлын хөгжил ба нийгмийн урагшлалтад шууд нөлөөлдөг. Соёл олон зүйл багтана. Дан ганц сургуулийн хүмүүжил төдий биш, нэг үндэстний соёл бол олон зуун жилийн турш бүрэлдсэн хүн ба байгаль, хүн ба хүн хоорондох харьцааны тухай үндсэн үзэл ойлгогдохуун түүнд хандах сэтгэлгээ, арга хэлбэр зэргийн ерөнхийлөл буюу түүний тундас гэж хэлж болох магад. Соёлд амьдралын тухай өртгийн үзэл, амьдрахуйн хэлбэр ба зан заншил, гүн ухаан, шашин суртахуун зэрэг олон зүйлс багтана. Соёл бол нэг улс үндэстний толь мөн. Япон соёлын энэхүү толинд өөрийгөө харж, долоон өнгөөр солонгорсон гадаад далайн эргээс өлгий нутаг өвөр монголоо эргэн харсан<sup>29</sup> найман найрууллаас бүрдэв. Зохиогч: “Хувийн зардлаараа японд суралцаж байсан үеийн өнгөрөлт болон өөрийн үзсэн сонссон сэрсэн ухаарсан тухайгаа бичсэн бодлын үгс юм. Японы нийгэмд гурван жил амьдарч суралцаж, өдөр бүр японы эгэл ардаас эрдэмтэн профессортой таарч уулзах тохиолтой байсан бөгөөд амьдралын шаардлагаар өөрөө ч өдөр бүр оюутан, хөлсний ажилтан, хоолны газрын зөөгч, заримдаа сэхээтний дүрээр, заримдаа хар ажилтан болох мэтээр хэдэн жилийн хэлбэр дүрээр амьдрах болохоор тэндэхийн нийгэм соёл, амьдрал, хүн ардынх нь зан араншны тухай зохих ойлголттой болжээ. Иймэрхүү өнгөрөлт нь богино хугацааны зуучлалын өнгөц төрөгдөлтэй адилгүй байснаас гадаад улсын тухай бичсэн монгол найрууллын дотор өөрийн гэсэн онцлогтой болсон байна<sup>30</sup>.

Зохиогчоос нутаг байгаль, амь ахуй, зан суртахуун зэрэг олон талаас хараа тусгасан байна. Доор Холын цэнхэр токион оюуны соёл, эд өглөгийн соёл, үйл ажиллагааны соёл, байгууламжийн соёл зэрэг талаар харьцуулан шинжлэх болно.

### *(Нэг) Оюуны соёлын харьцуулал*

Оюуны соёлд гүн ухаан, шашин шүтлэг, утга урлаг хүн иш ... зэрэг аливаа оюун ухааны зүйлс багтана. Энэ нь даруй соёл судлалын цөм болно. Япон улс – наран улсын үүсэл гарлын тухай домог үлгэр: монголчууд далай дотроос нар гарахыг үзээд маш сонирхож зуун шилдэг сайн хөвгүүн зуун гоо

<sup>28</sup> Одон. Өөрчлөлт нээлтээс нааш 40 жилийн найрууллын хөгжил. Алтан түлхүүр 2019 №3 т 36

<sup>29</sup> Н.Өлзийбат. Эх хэл утга зохиол ухамж сэрэгдэл. ӨМСХХ., 2008 т 267

<sup>30</sup> Н.Өлзийбат. Хайр ба хариуцлага-Аав нутаг хоёрын тухай хэлэх хэдэн үг, т 209





## THE CULTURAL WAY

охиныг сонгон томилж нарыг хайлгахаар мордуулсан гэнэ. Тэд явсаар нэгэн аралд хавьдахад тайфөн салхи хөдөлж онгоцыг нь эвдсэнд тэдгээр залуус дахиж хаашаа ч явж чадалгүй тэр арал дээр амьдрах болсон юм гэнэ.

Япон хэл авиа ба монгол хэл авиа: япон хэлний үндсэн авиалал, үгийн хувьлал, үргэлжийн байршил зэрэг нь монгол хэлтэй яасан төстэй аж. Наран тэмдэгт цагаан туг европын шунхайчууд монгол орноор аялагч Марко Пологийн жуулчлалын тэмдэглэлээс наран аралд алт их гардаг гэж дуулаад ховдог санаандаа хөтлөгдөж алтан овоог олохыг мөрөөдөн, наран арлыг хайсаар байж, наранчуудын ах дүү индианчууд дээр хүрч очсон. Наран тэмдэгт цагаан туг бол уг нь сүм хийдийн дарцаг байснаа 16 дугаар зууны үеэс японыг төлөөлсөн тугийн хувиар онгоц дээр намирах болж, наран манддаг орон гэсэн улсын нэртэйгээ нийцэх болохоор 1870 онд жинхэнээр төрийн далбааны хувиар далай тэнгисийн аялалд хөлөг онгоцноо хадагдах болжээ.

Бүлэгт цогцын зориг санааны зөрөө: самурайн зориг санаа – дайнд ойчсон ч зориг нь ойчоогүй, аж ахуй, хот балгас нь сүйрсэн боловч соёл нь сүйрээгүй зангидсан нударга мэт бат нягтарч, мятрашгүй зориг цөсөндөө түшин босож, өөрийн улс үндэстнээ татаж явсан япон соёлын гэрэл цацрангуй талыг үзүүлсэн байна. Бидэнд юунаас ч чухал, хамгийн дутагдаж байгаа зүйл бол өөр юм биш, харин үндэстний омог цөс, итгэл зориг, эв нэгдлийн зориг санаа мөн. Манайхан өөр нутгийн монгол боловсон хүчнээ салаан дарга ч суулгахгүй, сумын даргаас нь унагах гэж шүд зуун занаж тамираа шавхана. Тэнгэрлэг их эрсийн үр хойчисын цээж юм гэж үү? хот сахисан нохойгоо төдийгүй хорголын төдий эрх зэрэг, хумсан төдий ашиг хонжоон төлөө хотол олон монголчуудынхаа төлөө хүзүү сунган зүтгэдэг чин журамтадынхаа зүрх рүү зүү шивэхээс буцахгүй болдгийг яана. (Сибуяа өртөөн өнмөх Хачикогийн шуумал)

Айдинтит бол соёлын цогцын анхнаасаа байсан соёлын бэлгэ шинж буюу соёлын цогцын тухай соёлын онцлог шинж, бэлгэ чанартайгаа ижилдэн нэгдэх сэтгэлгээг хэлнэ. Айдинтитэд үндсэн таван бүрэлдэхүүн бий. Тухайлбал, өртгийн үзэл, үг хэл, гэр бүлийн дүрэм, амьдрах хэлбэр, оюун санааны ертөнц<sup>31</sup> зэрэг юм. Зохиогчоос япон зориг санаа хийгээд монгол үндэстний зориг санааны ялгаа зөрөөг зураглаж, үндэстний соёл сэтгэхүйн гүн давхарга дахь эмзэг тал, монголчуудын удам муут чанарыг илэрхийлж соёлын эчнээ давхаргын айдинтитийг сүвэгчилсэн байна. Монгол соёлын хүлээн авах чадвар хятад соёлоос сайн байдаг. Европчууд монгол соёлыг их хүндэтгэж, хэлний илтгэх чадвараар сайн зэрэг давуу талыг ч харуулсан байна. Зөнгийн задлаг сэтгэц зүйн онолд үндэслэвэл эзгүй ухамсрын агуулга нь бүх хүн төрөлхтөн ба үндэстэн угсаатны хамтлаг цогцтой холбоотой байдаг мөртөө иймэрхүү хамтлаг эзгүй ухамсартай холбоотой байдаг.

*(Хоёр) Эд өглөгийн соёлын харьцуулал*

Эд өглөгийн соёл нь хүн төрөлхтний бодисын үйлдвэрлэлийн үр бүтээл болох юм. Үүнд гэр барилга, багаж зэвсэг, идээ ундаа, өмсгөл зүүдэл ... эд бодис багтана. Нутаг байгалийн тухай зөрөө: Холын цэнхэр токиогийн

<sup>31</sup> Дорнотэнгэр. Текст, утгын бүтэц, соёлын тайлал. ӨМАХХ., 2014 т 51



## THE CULTURAL WAY

эхлэлд, Хүний нутаг сайхан байсан ч дулаан үгүй, бороолжтой цайдам бүрдтэй баларт нь тавхайн ормоо тамгалж, борзонтой голд нь шалдан наадаж, будантай ууланд нь жимс түүж явсан хөдөөгийн нэгэн хөдсөний тасархай надад бол өрөвгөр байсан ч ээж минь, алс байсан ч нутаг минь юм даа. Айлын зүүн дэх цагаан нуурын хөвөө, араар урсах гургалдайн голын дэнж, уудам өргөн эмзэг талаар ёстой цэцгийн далай, шувуудын диваажин л гэсэн үг. Энд тогоруу тоодгоос эхлээд хун галуу, хар болон халиун галуу, цахиргаа алаг, далан хэлт, зэрлэг нугас, ятуу, гургуул, хараацай, цэгцээхэй гээд зүйл бүрийн жигүүртэн шувуу ганганалдаж, өндөг зулзагаа гарган, баяр жаргалтай амьдардагсан. Өнөөдрийн элэр балар элсэн нутаг, хөөрөн униартсан хөдөө говь болсон.

Өнөөдрийн япон, токио маш хөгжжээ. Японд бараг 60 гаруй хөдөлгөөнт галт уул аюул түгшүүрээр амьсгалж, номхон далайн газар хөдлөлтийн цагаригт байршлаараа газар хөдлөлтийн гай гамшиг их хэцүү, жаахан нөөцтэй шиг хэлвэл японд газар хөдлөхгүй өдөр цөөн байдаг.

Уур амьсгалын зөрөө: Токио, Хөххотын амьдралын айзам цохилго, хэв маяг, зан заншил, соёл боловсролын аль нь ч гэсэн далай тэнгисийн уур амьсгал хийгээд эх хуурайн уур амьсгал шиг зөрөөтэй байдаг.

Идээний соёлын зөрөө: Монголчуудын хонь өрцөлж байгаа япончууд сасим иддэг заншил. Монгол соёл европ соёлтой адилавар тал олон бий. Зан дадал, идээ ундаа, амьдралын талаар их ойролцоо байдаг. Тэд ч мах, цагаа идээ их хэрэглэдэг. Одоо идээ ундаа элбэг дэлбэг, хувцас хунар овоо товоо, мөнгөтэй бол мах сааль, лууван ногоо архи дарс юу ч бэлэн. Манай гүрэнд жилд хоёр гурван зуун түмэн зэмдэг хүүхэд төрж байгаа юм. Химийн бордоо хэт их хэрэглэснийх биз. Тос төдийгүй гуа жимс, мах шөл, ногооноос эхлээд болд төмөр, модон материал хүртэл япончууд гадаадаас авахгүй юм байхгүй.

### *(Гурав) Байгууламжийн соёлын харьцуулал*

Байгууламжийн соёл нь хүн төрөлхтний нийгэм дэх элдэв олон харьцаа, ажил үйлс явуулахын хэмжээ баримжаа буюу дүрэмлэвээс зохих ёс дүрэм байжээ. Монгол толбо, мэнгэ, үндэстэн, япон үндэстэн: япон хүүхэд ч монгол хүүхэд шиг ууцан дээрээ хөх толботой байдаг болохоор япончууд өөрсдийгөө монгол удмын хүн гэж үзнэ. Хэрэв тийм тэмдэггүй бол жинхэнэ ямато үндэстэн – япон хүн биш гэж үздэг. Япон монгол үндэстний үүсэл гарлын түүх соёлыг мөрдөж, япончуудын ажил үйлс явуулах хэмжээ баримжаа, европын ахмад цэргийг дурсган тэмдэглэх газар зэргийн ялгаа зөрөөг тодруулж, хүний үнэ цэний үзэл, бодол ухамсар, амьдрахуйн үзлийн баримжаа шаардлагыг үзүүлсэн байна.

### *(Дөрөв) Үйл ажиллагааны соёлын харьцуулал*

Үйл ажиллагааны соёл нь хүмүүсийн аливаа үйл ажиллагааны илрэл жич баримжаалал болно. Үүнд үг яриа, үйл явдал, явж суух, овор ааш гэж байх, гийчилж зочлох ... зэрэг бие хэл сэтгэлийн аливаа илрэл хамрагдана. Зохиолчийн хэлсэн шиг: тэндэх сурах юм олон бий, их арван зүйлд бишрэхгүй байхын аргагүй, бишрэхгүй сурахгүй бол бид бядуу биш битүү болно. Бид бусад үндэстний давшингуй талыг суралцаж, өөрийн үндэстний онцлогтоо



## THE CULTURAL WAY

тохируулан шилдгийг нь авч шаарыг нь хаяж сонголттой шингээн авч өөрийгөө сайжруулан төгөлдөржүүлэх чухалтай байгааг сануулсан байна.

Гурав. Өнгөрсөн ба өнөөгийн харьцуулал

Өнгөрсөн ба өнөөгийн харьцуулал – Аав нутаг хоёрыг өнгөрсний дуртгал ба өнөөгийн тусгал болсон намтарчилсан шинжтэй найруулал Аав нутаг хоёрыг өнөөгийн байдлын тусгал, өнгөрсөн түүхийн эргэцүүлэл, өнгөрснийг одоохи шиг болгосон дурсамжит найруулал Мөөрүү мөөрүү шүрэн хадыг хүүхэд насны дуртгал өнгө үзэмжийг зурагласан зуучлалын тэмдэглэл, өнгөрсний дурсамжит найруулал зэрэг талаас онцолж байна.

*(Нэг) Өнгөрсний дуртгал ба өнөөгийн тусгал болсон намтарчилсан шинжтэй найруулал*

Найруулал нь үнэн хүн үнэн хэргийг бичдэг болохоор хүмүүс түүнийг үнэн бодитой амьдралын урлаг тэмдэглэл мөн гэж үздэг. Найруулал нь үнэн бодит чанарыг хадгалдаг тул түүнийг бичихэд эрхбиш нарийн нямбайгаар материал цуглуулах хэрэгтэй. Нутгийн өнгө үзэмжийг тэмдэглэн тоочихоор голчилж оновчтой хураангуйлал шүүмжлэн өгүүлж, утгын гүнээс уран санааг цогцлоосон байна. Н.Өлзийбатын найруулал үнэнч, борогжуу, лавдуун, оновчтой, авсаархан байдгаараа даасан босголцсон үзэгдэл болон хэв намбажиж байгаа байдалтай. Өгүүлбэрийн гэгээрчлэлээр биш харин бүхэл цогцын гоо төрх ба хайр сэтгэлээрээ хүнд нөлөөлнө.

*(Хоёр) Өнгөрснийг одоогийнх шиг болгосон дүрсэмжит найруулал*

Найруулал нь сэдэв тодорхой урьдал доор чөлөөтэй дэлгэрүүлж бичихийг эрхэмлэдэг. Үүнийг саланги бөгөөд саланги бус гэдэг. Мөөрүү мөөрүү шүрэн хад гэх эмхэтгэл нь адил бусын агуулга бүхий найман найрууллаар бүрэлдэв.

Өнгө үзэмжийг зурагласан зуучлалын тэмдэглэл: Манат хот Чүнчиний өдрийн хөгжөөнтэй гэхдээ шөнө нь нэн үзэмжтэй. Түмэдийн талын тогтуун намуухан намрын өглөө, эх дэлхий юутай иймэрхүү тааламжтай сайхан.

Дээрх дүрсэмж зохиолд зохиогчоос ахмад үеийн зохиолч эрдэмтэн, яруу найрагчдыг сурвалжилж бүдгэрснийг тодорхой болгож дүрс биетэй, хэзээд хөдөлдөг, ярьдаг, амьтай, бодолтой болгодог чадавхит арга хэлбэрийн илтгэл болсон байна. Дүрсэмжийн дотор сэтгэлгээний эндлэл оргилж, дүрсэмжийн цаана хүн чанарын хайлт, үндэстний ирэх маргаашийн тухай санаашрал, ирээдүйн тухай бодол алгасал нуугдаж байдаг.

### ДҮГНЭЛТ

Урлагийн сонирхомж нь үүдэн бүтээгчийг бүтээж, урлагийн үүдэн бүтээлгийн нөлөө тусгал нь урлагийн сонирхомжийг бүтээдэг. Хоёулаа харилцан түшиглэлцэхээр урьдал болгож, хоорондоо харилцан ахиулах үйл ажиллагаа болно. Урлагийн нөлөөлөх хүчний хэлбэр нь нэгд, харилцан эсэргүүцэлдлийн дунд нөлөөлөх, хоёрт, онцгой үзэл сэтгэлгээний үйл үүсгэдэг



## THE CULTURAL WAY

байна. Найруулал нь хүмүүсийн оюун санаанд долгиолт үүсгэж, өөрийнхөө өвөрмөц онцлогтой хөгжиж ирсэн байна.

### ABSTRACT

Comparative literature studies and Mongolian composition, about Mongolian composition, cultural comparison of “Holiin tsenher Tokyo” in terms of material culture, action culture, intellectual culture, structure culture comparison, past and present comparison – “Aav nutag hoyr” is a biographical version of the memory of the past and a reflection of the present.

Keywords: *Comparative literature, mongolian directing, N. Ulziibat, world of art*

### НОМ ЗҮЙ

1. Намжил. Монгол домгийн харьцуулсан судлал. БэҮнХХ., 2001
2. Линсе. Найрууллын тухай. ӨМСХХХ., 1997
3. Вэнь Лань, Дорнотэнгэр. Шинэ эриний монгол найруулал. ӨМБИСЭШС., 2020
4. Одон. Найруулал судлал хийгээд зохион бичлэг. ЛяҮнХХ., 1996
5. Н.Өлзийбат. Хайр ба харилцаа-Монгол найрууллын тухай сэтгэгдэл
6. Сүег. Монголчуудын эртний соёл ухамсрын арван тайлан. ӨМАХХ., 2012
7. Одон. Өөрчлөлт нээлтээс нааш 40 жилийн найрууллын хөгжил. Алтан тулхүүр 2019 №3
8. Н.Өлзийбат. Эх хэл утга зохиол ухамж сэрэгдэл. ӨМСХХ., 2008
9. Н.Өлзийбат. Хайр ба хариуцлага-Аав нутаг хоёрын тухай хэлэх хэдэн үг
10. Дорнотэнгэр. Текст, утгын бүтэц, соёлын тайлал. ӨМАХХ., 2014
11. 黎跃进著: 《比较批评与比较文学》, 东方出版社, 2002 年
12. 陈跃红著: 《比较诗学导论》, 北京大学出版社, 2005 年
13. 谢天振: 《中国翻译文学史 实践与理论》, 《中国比较文学》, 1998 年 第二期
14. (美) 勒内 韦勒克 奥斯汀 沃伦著: 《文学理论》, 江苏教育出版社, 2005 年
15. 陈 惇、孙景尧、谢天振主编: 《比较文学》, 高等教育出版社, 2004 年
16. 陈跃红、张辉、张沛主编: 《乐在其中 乐黛云教授八十华诞弟子贺寿文集》, 北京大学出版社, 2011 年
17. 谢天振著: 《译介学》, 上海外语教育出版社, 1999 年
18. 乐黛云、王向远著: 《比较文学研究》, 福建大学出版社, 2006 年
19. 杨 乃乔主编: 《比较文学概论》, 北京大学出版社, 2006 年
20. (日) 渡边洋著, 张青编译: 《比较文学研究导论》, 中国社会科学出版社, 2007 年
21. 张菊香著: 《鲁迅、周作人、胡适》, 南开大学出版社, 2017 年
22. 陈惇, 刘象愚: 《比较文学概论》, 北京师范大学出版社, 2004 年
23. 孟昭毅: 《比较文学通论》, 南开大学出版社, 2003 年
24. 维柯著, 朱光潜译: 《新科学》, 安徽出版集团, 2006 年
25. 洪子成: 《中国当代文学史》, 北京大学出版社, 1999 年



МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ҮРЧЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА  
(зарим улс орны жишээгээр)

А.Мөнхцэцэг\*

ХУРААНГУЙ

Үрчлэлт хүчин төгөлдөр байх хууль зүйн шаардлагыг зөрчсөн, эсхүл үрчлүүлэгчийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах шаардлагатай гэж үзэх бусад үндэслэлээр шүүхээс хуульд заасан журмын дагуу үрчлэгч, үрчлүүлэгчийн хоорондын харилцааг дуусгавар болгож буй хууль ёсны ажиллагааг ойлгоно. Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар - Хуульд заасан үндэслэл, журмын дагуу үрчлэлтийг хүчингүйд тооцсоноор үрчлэгч, үрчлүүлэгчийн хооронд тодорхой эрх, үүргийг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгож буй хуулиар тогтоосон үр дүнг ойлгоно.

Түлхүүр үгс: *Монгол, Хятад улс, Хууль, Хүүхэд, үрчлэх, үрчлүүлэх, Үрчлэлтийг хүчингүйд тооцох*

Үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт нь тухайн улсын Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцоор зохицуулагддаг. Олон улсын гэрээ конвенцын хувьд:

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц /1989 онд батлагдаж, Монгол улс 1990 онд соёрхон баталсан./ Уг конвенцын 21-р зүйлээр хүүхдийн үрчлэлтийн асуудлыг зохицуулж өгсөн байна.

2. Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц: 1998 оны 01 сарын 16 конвенцод улс бүр хүүхдийг өөрийн төрөлх гэр бүлийн асрамжид байх боломжийг бүрдүүлэх талаар зохих арга хэмжээг тэргүүн зэрэгт тавьж ажиллах шаардлагатайг онцлон тодорхойлж, харин өөрийн төрөлх улс оронд тохиромжтой гэр бүл олдохгүй байгаа нөхцөлд хүүхдийг байнгын гэр бүлийн давуутай талыг олгох боломжийн үүднээс улс хооронд үрчлэх үрчлэлтийн систем байж болохыг хүлээн зөвшөөрсөн юм. Улс хооронд үрчлэх системийн гол зорилго нь:

-Үрчлэлтийг хүүхдийн дээд ашиг сонирхлын дагуу олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн түүний үндсэн эрхийг хүндэтгэх үндсэн дээр хэрэгжүүлэх баталгааг бий болгох.

---

\* ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч



## THE CULTURAL WAY

-Хүүхэд хулгайлах, хил дамнан хамгаалагдахаас сэргийлэх хууль зүйн баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсуудын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох.

-Хүүхэд үрчлэлт нь дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдах боловч хүүхдийн эрхэм эрх ашгийг онцгой харгалзан үзэж, үүнд санхүүгийн ашиг хонжоо олох зорилго агуулж үл болох, түүнийг хориглосон байх.

Дээрх зохицуулалт нь хүүхдийн эрхийг хангах тэдний эрх ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг нь сэргээлгэх, хамгаалах үүднээс бүхий л үйл явц хуулиар зайлшгүй зохицуулагдах ёстой болохыг хүлээн зөвшөөрсөн юм.

Тухайлбал, Үрчлэх, үрчлүүлэх явцыг урьдчилан тогтоох үйл ажиллагаа, Үрчлэх, үрчлүүлэх процесс, Үрчлэгдсэн хүүхдийг үрчлэн авсан эцэг эх болон тухайн улс оронд шилжүүлэх, Үрчлэлтийн дараах хяналт процесс хамрагдана.

Дээрх олон улсын гэрээ конвенцын заалтад нийцүүлэн улс орнууд дотоодын хууль тогтоомжоор үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг бий болгож хүүхдийг эцэг эхтэй болгох, тэдний эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

### *Монгол улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт:*

Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хангах зарчим, түүнийг хангах баталгааг хуульчлан баталсан байдаг. Үрчлэлт нь хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хөндсөн асуудал болохынхоо хувьд хүүхдийн эрх, түүний хамгааллын хүрээнд зохицуулагдах асуудлыг багтаасан өргөн ойлголт бөгөөд тодруулбал хүүхдийн гэр бүл, эцэг, эхийг орлох хэлбэрийн онцгой зохицуулалт болох тул үрчлэлтийн бүхий л процесс хүүхдийн эрхийг хангах хүрээнд маш тодорхой зохицуулагдвал зохих хүний эрхийн асуудал юм. Монгол улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт нь 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль болон Иргэний хууль бусад холбогдох эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байна.<sup>1</sup>

### *Хятад хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалт:*<sup>2</sup>

Хятад улсын Иргэний хуулийн 1093-р зүйлд зааснаар эцэг эхээ алдсан өнчин хүүхэд, төрсөн эцэг эх нь олдоогүй насанд хүрээгүй хүүхэд, төрсөн эцэг эх нь хүндэтгэх шалтгааны улмаас хүүхдээ асарч чадахгүй хүүхдүүдийг үрчилнэ.<sup>3</sup> Мөн хуулийн 1098-р зүйлд зааснаар хүүхэд үрчлэхийг хүссэн хүн дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

- Хүүхэдгүй эсвэл ганц хүүхэдтэй;
- Үрчлэгдсэн хүмүүсийг тэжээх, сургах, хамгаалах чадвартай;
- Анагаах ухаанд хүүхэд үрчилж авах ёсгүй гэж үзсэн өвчингүй;
- Үрчлэгдсэн хүмүүсийн эрүүл өсөлтөд тохиромжгүй хууль бус, гэмт хэргийн бүртгэл байхгүй.

<sup>1</sup> Гэр бүлийн тухай хуулийн долоодугаар бүлэгт /54-62 дугаар зүйл / хүүхэд үрчлэлтийг харилцааг зохицуулсан.

<sup>2</sup> Хятад улсын насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах тухай хууль. 2012

<sup>3</sup> О.Өнөрцэцэг. Гадаад орнуудын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт, УБ., 2003 т 46



## THE CULTURAL WAY

- Бүтэн гучин нас хүрсэн байх.

Мөн Хүүхэд 8 нас хүрсэн бол үрчлүүлэхдээ зөвшөөрлийг нь заавал авна. Хүүхэд үрчлэгдсэний дараа дотоодыг хамгаалах байгууллага өрхийн тоо бүртгэлд бүртгэнэ. Үрчлэн авсан өдрөөс эхлэн үрчилж авсан эцэг эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ. Хүүхэд үрчилж авахдаа хуурамч материал бүрдүүлсэн, хууль бус арга хэрэглэсэн тохиолдолд үрчлэлтийг хүчингүйд тооцно. Үрчилж авсан эцэг эх, хүүхдийн хооронд харьцаа муудсан, цааш амьдрах боломжгүй болсон тохиолдолд мөн адил үрчлэлтийг хүчингүй болгоно. Хэрэв төрсөн эцэг эх нь үрчлэлтийн харилцааг цуцлахыг шаардсан бол үрчилж авсан эцэг эх нь үрчлэлтийн явцад зарцуулсан тэтгэмжийн төлбөрийг зохих ёсоор нөхөн төлөхийг шаардаж болно; Гэвч үрчилж авсан эцэг эх нь хүүхдийг хүчирхийлсэн, хараа хяналтгүй хаяснаас болж үрчлэлт хүчингүй болгосон байвал нөхөн төлбөр төлөхгүй.

Үрчлэлтийн харилцаа үүссэн өдрөөс эхлэн үрчлэн авсан эцэг, эх ба үрчлэгдсэн хүүхдийн хооронд үүсэх эрх, үүргийг Иргэний хуулийн 111-р зүйлд заасан эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцааны тухай заалтаар зохицуулна. Үрчлэгдсэн хүүхэд болон үрчлэн авсан эцэг, эхийн ойрын төрөл төрөгсдийн хооронд үүсэх эрх, үүргийг энэ хуулийн 112-р зүйлд заасан хүүхэд, эцэг эхийн ойрын төрөл төрөгсдийн тухай заалтаар зохицуулна. Үрчлэлтийн харилцаа үүссэнээр үрчлэгдсэн хүүхдүүд болон тэдний төрсөн эцэг, эх, ойрын бусад хүмүүсийн хоорондын эрх, үүргийн харилцаа дуусгавар болно.

Мөн Хятад улсын Иргэний хуулийн 1102-р зүйлд "Гэрлээгүй хүн бусад хүйсийн хүүхэд үрчилж авсан тохиолдолд үрчилж авсан болон үрчлэгдсэн хүний насны зөрүү 40өөс дээш байх ёстой" гэж заасан нь хүүхэд үрчилж авахдаа ёс зүй, ёс суртахууны асуудал гаргаж хүүхдийн эрхийг хохироохоос урьдчилан сэргийлэх зорилготой.<sup>4</sup>

Харьцуулсан судалгаа

1. Үрчлүүлэх нөхцөлөөр нь харьцуулан авч үзвэл:

Нийтлэг тал: Өнчин хүүхэд болон эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд, эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхдийг үрчлүүлж болохоор заасан байна.

Ялгаатай тал: Монгол улсад 14 нас хүрээгүй хүүхдүүд үрчлүүлж болно. Хятад улсад 18 нас хүрээгүй хүүхдүүд үрчлүүлж болно гэж заасан. Мөн төрсөн эцэг эх нь олдхоггүй насанд хүрээгүй хүүхдийг үрчлүүлэхээр хуульд заасан байна.

2. Үрчлэгчид тавигдах шаардлагаар нь харьцуулан авч үзвэл:

---

<sup>4</sup> Хятад улсын "Иргэний хууль" 2021





## THE CULTURAL WAY

Нийтлэг тал: Үрчлэгч нь иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байх хэрэгтэй. Гэмт хэрэг үйлдсэн хүн хүүхэд үрчлүүлэхийг хориглоно. Шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

Ялгаатай тал: Монгол улсад Гэр бүлийн тухай хуульд зааснаар үрчлэгч нь насанд хүрсэн хүн байна. Хятад улсын Иргэний хуулиар үрчлэгч нь 30 настай хүн байна. Хятад улсад хүүхэдгүй эсвэл ганц хүүхэдтэй хүн хүүхэд үрчилж болно. Монгол улсад бусдын асрамжинд байгаа 60-аас дээш настай төрөл, садан бус Монгол Улсын иргэн, 60-аас дээш настай гадаадын иргэн, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой хүнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

3. Үрчлэгдсэн хүүхэд, үрчлэн авсан эцэг, эхийн эрх, үүргээр харьцуулан авч үзвэл:

Нийтлэг тал: Үрчлэгдсэн хүүхэд нь төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үрчлэн авсан эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Ялгаатай тал: Монгол улсад тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг үрчлэгдсэн хүүхэд нь уг тэтгэвэр авах эрхээ хэвээр эдэлнэ.

4. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий нөхцөлөөр нь харьцуулан авч үзвэл:

Нийтлэг тал: Гэрлэгчдийн хэн нэг нь хүүхэд үрчлэн авч байгаа бол энэ тухай зөвшөөрлийг эхнэр буюу нөхрөөсөө авна. Бүтэн өнчин хүүхэд, түүнчлэн эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй бол хүүхдийг нь үрчлүүлэх тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын зөвшөөрлийг авна.

Ялгаатай тал: Монгол улсад хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл болон хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн байна. Хятад улсад үрчлэлтийн харилцаанд оролцогч талууд үрчлэлтийн гэрээ байгуулах хүсэлтэй байгаа бол байгуулж болно. Үрчлэлтийн харилцааны бүх талууд буюу нэг тал үрчлэлтийг нотариатаар гэрчлүүлэх хүсэлт гаргасан бол гэрчлүүлэх хэрэгтэй. Монгол улсад долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна. Хятад улсад найман нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна. Монгол улсад үрчлэн авахыг хүсэгч нь хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн засаг даргад хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргана. Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана. Хятад улсад хүүхэд үрчилж авахыг шианы 29 түвшнээс дээш ардын засгийн газрын иргэний хэргийн хэлтэст бүртгэх ёстой. Монгол улсад хүүхэд үрчилсэн тухай шийдвэрийг үндэслэн иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүүхэд үрчилснийг бүртгэнэ. Хятад улсад үрчлэлтийн харилцаа үүссэний дараа, олон нийтийн аюулгүй байдлын байгууллага төрийн холбогдох журмын дагуу өрхийн бүртгэлийг хийнэ. Монгол улсад эцэг, эх байх





## THE CULTURAL WAY

эрхээ хасуулсан хүний хүүхдийг энэ тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа үрчлүүлж болно. Хятад улсад төрсөн эцэг эх нь олдохгүй насанд хүрээгүй хүүхэд үрчилж авсан бол бүртгэлийг явуулж буй иргэний хэргийн хэлтэс бүртгэхээс өмнө зарлана.

5. Үрчлэлтийг хүчингүйд тооцохоор нь харьцуулан авч үзвэл:

Ялгаатай тал: Монгол улсад үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан, энэ хуулийн 57.2-т заасан этгээд болох нь илэрсэн тохиолдолд төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно. Шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно. Харин Хятад улсад энэ хуулийн I хэсэгт заасны дагуу иргэний эрх зүйн акт хүчингүй болсон, эсхүл энэ хэсэгт заасныг зөрчиж үрчлэн авсан нь хүчингүй болно. Үрчлэгч ба үрчлүүлэгч хоёр харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд үрчилж авсан хүүхдийг насанд хүрэхээс өмнө үрчлэлтийн харилцааг дуусгавар болгож болохгүй. Үрчлэгдсэн хүүхэд 8 нас хүрсэн бол тухайн хүний зөвшөөрлийг авна. Үрчлэгч нь насанд хүрээгүй үрчлэгдсэн хүүхдийг хүмүүжүүлэх үүргээ биелүүлээгүй, хүчирхийлсэн, орхисон зэрэг хууль ёсны эрх, ашиг сонирхолд халдсан тохиолдолд, үрчлүүлэгч нь үрчлэлтийн харилцааг цуцлахыг шаардах эрхтэй. Үрчлэгч ба үрчлүүлэгч хоёр үрчлэлтийн харилцааг дуусгавар болгох талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Талууд үрчлэлтийн харилцааг дуусгавар болгоход тохиролцсон тохиолдолд, үрчлэлтийн харилцааг дуусгавар болгох бүртгэлийг иргэний хэргийн хэлтэст хийх хэрэгтэй.

6. Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавараар нь харьцуулан авч үзвэл:

Нийтлэг тал: Үрчлэлтийн харилцаа дуусгавар болсны дараа үрчлэгдсэн хүүхдүүд болон үрчилж авсан эцэг эх, ойр дотны бусад хүмүүсийн хооронд үүсэх эрх, үүрэг нэн даруй дуусгавар болно. Ялгаатай тал: Монгол улсад үрчлэлтийг хүчингүйд тооцсон тохиолдолд хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь буцаах асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Хүүхдийг эцэг, эхэд нь буцааж өгөх нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд хохиролтой нь тогтоогдсон, эсхүл хууль ёсны өөр төлөөлөгч байхгүй бол түүнийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон зардлыг үрчлэгчээс гаргуулж, учирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Үүнд: о ХЯТАД УЛС-д Үрчлэлтийн харилцаа дуусгавар болсны дараа үрчилж авсан эцэг эхэд тэжээгдсэн насанд хүрсэн хүүхдүүд хөдөлмөрийн чадваргүй, амьжиргааны эх үүсвэргүй үрчлэн авсан эцэг, эхийн амьжиргааны зардлыг төлнө. Үрчлэгдсэн хүүхэд насанд хүрсэн



## THE CULTURAL WAY

хойноо үрчилж авсан эцэг эхээ хүчирхийлсэн эсвэл орхисноор үрчлэлтийн харилцаа дуусгавар болбол үрчилсэн эцэг эх үрчлэгдсэн хүүхдээ тэжээх явцад гарсан зардлыг нөхөн төлүүлэхийг хүсэж болно. о Төрсөн эцэг эх үрчлэлтийн харилцааг дуусгавар болохыг хүссэн тохиолдолд үрчилж авсан эцэг эх нь төрсөн эцэг эхээсээ хүүхэд үрчлэн авах явцад гарсан зардлыг зохих хэмжээгээр гаргуулахыг хүсэж болно. Гэвч үрчилж авсан эцэг эх нь үрчлэгдсэн хүүхдийг хүчирхийлсэн, орхисноос үрчлэлтийн харилцааг дуусгавар болгосноос бусад тохиолдолд гэм хорыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

*Монгол, Хятад улсын Хүүхэд үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтын давуу тал ба сул талыг харьцуулан авч үзвэл:*

	Монгол улс	Хятад улс
Давуу тал	<ol style="list-style-type: none"><li>1. Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг энэ тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа үрчлүүлж болно.</li><li>2. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг үрчлэгдсэн хүүхэд нь уг тэтгэвэр авах эрхээ хэвээр эдэлнэ.</li><li>3. Үрчлэгчийн насны хувд нээлтэй боломжтой.</li></ol>	<p>- Үрчлэлтийн харилцаа дуусгавар болсны дараа үрчлэгдсэн насанд хүрсэн хүүхдүүд хөдөлмөрийн чадваргүй, амьжиргааны эх үүсвэргүй үрчлэн авсан эцэг, эхийн амьжиргааны зардлыг төлнө.</p>
Сул тал	<p>- Үрчлэлтийн харилцаа дуусгавар болсны дараа үрчлэгдсэн насанд хүрсэн хүүхдүүд хөдөлмөрийн чадваргүй, амьжиргааны эх үүсвэргүй үрчлэн авсан эцэг, эхийн амьжиргааны зардлыг төлөх тогтоолгүй.</p>	<ol style="list-style-type: none"><li>1. Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг үрчлэх цагны талаар тодорхой тогтоолгүй.</li><li>2. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг үрчлэгдсэн хүүхэд нь уг тэтгэвэр авах эрхээ алдана.</li></ol>

### ДҮГНЭЛТ

Хүүхэд үрчлэлтийн талаарх аливаа хууль тогтоомж нь үндсэн хууль болон Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Олон улсын гэрээ конвенцоос бүрддэг хэдий ч өнөөг хүртэл зохицуулаагүй үлдсэн харилцаа, эрх зүйн үйлчлэл дутмаг ойлголтууд нийгэмд байсаар байна. Монгол, Хятад улсын хүүхэд үрчлэлтийн эрх зүйн тогтолцоо нь үрчлэгдсэн хүүхдийн эрх ашгийг хамгаалахад гол анхаарлаа хандуулдаг бөгөөд энэ нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг агуулсан, мөн талуудын хоорондын маргаанаас аль болохоор зайлсхийхэд чиглэгдэж байна.



# THE CULTURAL WAY

## ABSTRACT

The court terminates the relationship between the adopter and the adopter in accordance with the procedure prescribed by the law due to the violation of the legal requirements for the adoption to be valid, or for other grounds deemed necessary to protect the rights and interests of the adopter. Consequences of annulment of adoption - In accordance with the grounds and procedures set forth in the law, by annulment of adoption in accordance with the law, it is understood that certain rights and obligations are created, changed and terminated between the adopter and the adopter.

Key words: *Mongolia, China, Law, Children, Adoption, Adoption, Annulment of Adoption*

## НОМ ЗҮЙ

1. Дугармаа С, Монгол улсын гэр бүлийн эрх зүй Уб хот., 2005он
2. Өнөрцэцэг О, Гадаад орнуудын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт, 2022 он
3. “Хүүхэд үрчлэлийн харилцаа-хүүхэд хамгааллын бодлогын зарим асуудал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2014

## Хууль тогтоомж:

1. “Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль” 1999 он. Улаанбаатар
2. “Хүүхдийн эрхийн тухай хууль”. 2007
3. “Иргэний хэргийн журам”. 2018 он
4. “Хятад улсын Иргэний хууль” 2021 он
5. “Хятад улсын Насанд хүрээгүй хүүхдийг хамгаалах тухай хууль” 2012 он

## Санал:

Монгол улсын хувьд хүүхэд үрчлэх хэрэгцээтэй гэр бүлд хүүхэд олоход нь туслан, зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх; үрчлэлтийн үйл явцад орон нутгийн нийгмийн ажилтны оролцоог нэмэгдүүлэх; хүүхэд үрчлэхээс өмнө үрчлэгч гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх; эцэг эхийг бэлтгэх, сургалтад харуулах; үрчлэх үйл явцад хүүхэд, гэр бүлийг хооронд нь дасгах хугацааг анхаарч үрчлэх; үрчлэлтийн дараах үйл явцыг хянах; хаягдсан, асран хамгаалагчгүй гэх мэт үрчлүүлэгч тал нь тодорхойгүй, олдохгүй, эцэг эхийн үүргээ гүйцэтгэдэггүй хүүхдийн үрчлэлтийн зохицуулалтыг сайжруулах нь зүйтэй юм. Хятад улсын хувьд үрчлэгчдийн нас, тоог нарийн тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрээгүй, хүүхдийг үрчлэлт нь үрчлэгчдийн тоог хязгаарладаггүй тул хойшид хүнд ачаалал үүсгэнэ; гэрлээгүй хүмүүсийн хүүхэд үрчлэн авах эрхийг баталгаажуулах, ялангуяа ижил хүйстэн хосуудад хүүхэд үрчлэн авах боломжийг бий болгох нь цаг үеийн шийдвэрлэвэл зохих асуудал болж байна.

ТӨРИЙН АЛБАН ХЭРГИЙГ КИРИЛЛ БОЛОН ҮНДЭСНИЙ  
БИЧГЭЭР ХӨТЛӨН ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Л.Батчулуун\*

## ХУРААНГУЙ

XIII зуунаас эхлэн монголчууд монгол бичгийг төрийн үйл хэрэгт болон шинжлэх ухааны бүтээл туурвилыг бүтээхэд хэрэглэсээр ирсэн, албан ёсны сонгодог төдийгүй дэлхийн бичиг соёлын нандин өв юм. Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг юм. Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 11 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлохдоо —Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх<sup>1</sup> гэж, мөн хуулийн 7.2-т —Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна<sup>2</sup> гэж, 24.2-т —Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө<sup>3</sup> гэж тус тус заасан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн захиалгаар Үндэсний Статистикийн хорооноос 2021 онд Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгааг 159558 төрийн албан хаагчаас авч үр дүнг тайлагнасан. Судалгааны дүнгээр цаашид монгол бичгийн сургалтыг дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсролын салбарт эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, стандарт дүрэм, журмыг шинэчлэн батлах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, уялдуулах нь зүйтэй гэж тодорхойлсон.

Түлхүүр үгс: *Монгол бичиг, бичиг үсэг, үндэсний хөтөлбөр*

## Оршил хэсэг

Монгол Улс бичиг үсгийн мянган жилийн түүхтэй эртний соёлт улсын нэг. Монгол бичиг нь Монголын ард түмний соёл, мэдлэгийн санг олон үеийн турш тээж ирсэн билээ.

1930 оны 2 дугаар сард хуралдсан Монгол Ардын Намын наймдугаар Их хурлаар шинэ соёл боловсролын хөгжилтөд дөхөмгүй хэмээн үзэж монгол

\* ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч



## THE CULTURAL WAY

үсгийг халж, латин үсгийг өөрийн монгол хэл дээр зохицуулан хэрэглэхээр шийдвэрлэсэн. Энэ шийдвэрийн дагуу Монгол орон даяар латин үсэгт шилжих бэлтгэл ажил эхлэн, үсгийн дүрмийг хэрхэн боловсруулах талаар ажил өрнөжээ. Гэвч 1941 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн МАХН-ын Төв хорооны тэргүүлэгчид ба Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаас монгол бичгийг шинэ орос —Кирилл үсэгт шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. 1945 оны 5 дугаар сарын 18-ны БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв хорооны хамтарсан хурлаар —Бүх хэвлэл ба улсын албан хэргийг 1946 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн шинэ үсгээр явуулсугай! хэмээн шийдвэрлэснээр БНМАУ-д кирилл үсгийг хэрэглэх болсон.<sup>1</sup>

Ийнхүү шинэ үсгийн соёл Монголын цөөхөн хүн амыг нэн даруй бүрхэж, "Ардын эрх", "Үнэн", "Хөдөлмөр", "Улаан Од" сонин шинэ үсгээр хэвлэгдэн гарах болов. 1950 он гэхэд 1000 жилийн түүхтэй монгол бичгийг бүрэн халж, дараачийнх нь 40 жилийн хооронд бичиг үсгээ бараг л мартсан байна.

1991 онд Улсын Бага хурлаас —БНМАУ-д төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэлийг хангах тухай! 36 дугаар тогтоол гаргасан байна. Улсын Бага хурлын тус тогтоолыг үндэс болгон БНМАУ-ын Засгийн Газраас 1991 оны 10 дугаар сарын 21-ний өдөр «БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай» тогтоол гарсан байна. Тогтоолоор уг бэлтгэл хангах ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий улсын комиссын бүрэлдэхүүнийг баталж, холбогдох яамд, улсын хороо, тусгай газар, орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, нийт сонин, сэтгүүлийн реакцид тус тусын үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан тодорхой бэлтгэл ажил хийхийг даалгажээ.

Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт өөрчлөлт орж 1991 оны 9 дүгээр сарын 1-нээс нэгдүгээр ангийн сурагчдын хичээлийг монгол бичгээр явуулж эхэлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, хот, аймаг, сум, дүүрэг, баг, хороодын тамга, Монгол Улсын Үндсэн хуулийн эх, улсын мөнгөн тэмдэгтийг үндэсний бичгээр үйлдэв. Ийнхүү хэлбэр талаасаа нэлээд идэвхтэй урам зоригтой эхэлсэн боловч харин агуулга талаасаа буюу албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах ажлын хэрэгжилтэд төдий л ахиц гараагүй. Тиймээс Засгийн Газрын 1992 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн «Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай» тогтоол, 1994 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн «Албан хэргийг монгол бичгээр хөтлөх бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай» тогтоолууд удаа дараалан гарч холбогдох байгууллага нэгжүүдэд ахин дахин үүрэг даалгавар өгч, анх төлөвлөсөн ажил хийгээд түүнийг биелүүлэх цаг хугацааны тов хойшлогдсоор байлаа.

Улсын Бага Хурлын 1991 оны 36-р тогтоол нэгэнт биелэгдээгүй тул 1994 оны 66 дугаар тогтоолдоо албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах

<sup>1</sup> Г.Цэрэндорж. БНМАУ-д бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгасан нь. УБ., 2001



## THE CULTURAL WAY

бэлтгэл хангагдаагүйг тэмдэглээд албан хэрэг болон сургалтыг цаашид кирил бичгээр үргэлжлүүлэн явуулахаар болж, —Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-ийг боловсруулан батлуулахыг Засгийн газарт даалгасан байна.

Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд —Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II, 2008-2015 онд —Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ийг тус тус хэрэгжүүлсэн. —Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, III хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон.

Гэвч —Бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох зэрэг зорилтууд хангалтгүй хэрэгжиж иржээ.

2015 онд баталсан Монгол хэлний тухай хуулийн 7.2 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны 03 дугаар сард Монгол Улсын Засгийн газар ээлжит хуралдаанаараа —Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ыг хэлэлцэн баталсан.

—Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ын зорилго нь Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангахад оршиж байна.

Ийнхүү үндэсний бичгээ түгээн дэлгэрүүлэх ажил цаасан дээр бууж байгаа хэдий ч бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байна вэ?

### Үндсэн хэсэг

#### 1. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр – III түүний онцлох заалтууд

д/д	Үндэсний хөтөлбөрийн заалт	Хэрэгжсэн байдал
<b>МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР-III</b> (Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор батлав.)		
3.1.10.	—Төрийн мэдээлэл сэтгүүлийг 2021 оноос эхлэн хос бичгээр хэвлэж, 2023 оноос зөвхөн монгол бичгээр хэвлэх бэлтгэл хангаж, хэрэгжүүлэх	2022, 2023 оны сэтгүүлийн зөвхөн гарчгийг монгол бичгээр хөрвүүлсэн. 2023 оноос зөвхөн монгол бичгээр хэвлэх заалт хэрэгжээгүй
3.2.4.	. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн монгол хэл, монголын түүх, уран зохиол, иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийн сурах бичгийг нэн түрүүнд, бусад хичээлийн сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар монгол бичигт хөрвүүлэн хэвлэх;	Одоогоор хэрэгжиж эхлээгүй
3.2.10	2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлана	Зөвхөн монгол хэл, уран зохиолын багш хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд туссан. Бусад их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд зааж эхлээгүй



## THE CULTURAL WAY

3.2.11.	Их, дээд сургуульд суралцагчдаас монгол бичгийн чадварын шалгалт заавал авч, дүнг бакалаврын дипломд баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;	Одоогоор хэрэгжиж эхлээгүй
3.3.4.	Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагад монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусгах;	Одоогоор хэрэгжиж эхлээгүй
3.3.6.	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага бүр монгол хэл, бичгийн хянан найруулах чиг үүргийг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах;	Одоогоор хэрэгжиж эхлээгүй
3.3.7.	Төрийн байгууллагууд албан бичиг хэргээ 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөх орчин бүрдүүлэх, туршиж эхлэх;	Одоогоор хэрэгжиж эхлээгүй

—Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III 2020 онд батлагдсан бөгөөд 2024 оны босгон дээр дээрх заалтууд огт хэрэгжиж эхлээгүй ихэнх заалтууд эхлэх төдий байдалтай байгаа нь Монгол хэлний тухай хуулийн 7.2 дахь заалтыг хуулинд заасан хугацаанд хэрэгжүүлж эхлэх нь эргэлзээ төрүүлж байна.

### 2. Их дээд сургуульд элсэгчээс авах Монгол хэлний элсэлтийн ерөнхий шалгалтын дүн

д/д	Он	800 оноо авсан суралцагчийн тоо	Улсын дундаж оноо	Улсын дундаж оноо хувиар
1	2018	10	500	62,5
2	2019	13	507	63,3
3	2020	22	498	62,2
4	2021	27	500	62,5
5	2022	15	495	61,8
6	2023	14	499	62,0

Элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний хичээлийн дундаж оноо улсын хэмжээнд 2018-2023 онд 495-507 онооны хооронд байгаа бөгөөд сурагчид тухайн хичээлийг 61,8—63,3 хувийн үзүүлэлттэй сурсан байна.

Шалгалтын дүнгээс харахад Монгол улсын хэмжээнд Монгол, хэл бичгийн хичээлийн сургалтын чанар, сурагчдын мэдлэг боловсрол дунд цаашид сайжруулах шаардлагатай байгаа харагдаж байна

### 3. Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021 дүн<sup>2</sup>


Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос анх удаа —Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021|| судалгаа явуулж дүнг танилцуулсан байна. Үүнд:

<sup>2</sup> Монгол улсын үндэсний статистикийн хороо —Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021||





## THE CULTURAL WAY



Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх асуултад судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 53.6 хувь нь —Тийм! гэсэн бол үлдсэн 46.4 хувь нь —Үгүй! гэж хариулсан.

Төрийн албан хэрэг хөтлөлтийг цаашид үндэсний бичгээр явуулахад төрийн албан хаагчдын мэдлэг, чадварт онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.

Үндэсний бичгийн мэдлэгийг төрийн албаны албан тушаалын төрлөөр харвал удирдах албан тушаалтай алба хаагчдын 6.5 хувь нь маш сайн мэдлэгтэй, 18.2 хувь нь сайн мэдлэгтэй, 32.6 хувь нь дунд зэрэг мэдлэгтэй, 24.7 хувь нь бага зэрэг мэдлэгтэй, 18.1 хувь нь мэдлэггүй гэсэн бол гүйцэтгэх албан тушаалтай алба хаагчдын 6.4 хувь нь, туслах албан тушаалтай алба хаагчдын 2.0 хувь нь маш сайн мэдлэгтэй гэж хариулжээ.

Өгөгдсөн эхийн зарим хэсгийг судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 50.9 хувь нь унших чадвартай, 38.8 хувь нь бүтнээр нь унших чадвартай бол 10.3 хувь нь тухайн эхийг огт уншиж чадаагүй байна. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 5.2 хувь нь өөрийнхөө үндэсний бичгийн түвшинг —Маш сайн! гэж үнэлсэн бол 13.4 хувь нь сайн, 28.7 хувь нь дунд зэрэг, 25.4 хувь нь бага зэрэг, 27.2 хувь нь үндэсний бичгийн үсэг, тоо мэдэхгүй, ялгахгүй, уншихгүй, бичихгүй буюу ямар нэгэн мэдлэг огт байхгүй гэж хариулжээ.

Төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтын хэрэгцээ, шаардлага байгаа эсэх асуултад 85.0 хувь нь —Тийм! гэсэн бол үлдсэн 15.0 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байхгүй гэжээ.

Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа төрийн албан хаагчдын 56.1 хувь нь танхимын сургалт, 43.1 хувь нь цахим сургалт, 0.8 хувь нь бусад хэлбэрийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна гэж хариулжээ.

Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг үндэсний бичиг сурч байсан хугацаагаар тооцоход сурсан хугацаанаас мэдлэгийн түвшин шууд хамаарч байна. Тухайлбал, 35-39 насны төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг бусад насны бүлэгтэй харьцуулахад сайн байгаа нь ерөнхий боловсролын сургуульд үндэсний бичгийг илүү олон жилээр заалгаж байсантай холбоотой.

Төрийн албан хаагчдын —Үндэсний бичгийн мэдлэг тогтоох судалгаал-г тодорхой жилийн давтамжтай хийж, хуулийн болон сургалт, зохион байгуулсан үйл ажиллагааныхаа хэрэгжилтийг бодитой дүгнэж байх,





## THE CULTURAL WAY

судалгааны мэдээлэлд үндэслэн дараагийн шатны үйл ажиллагаагаа төлөвлөх нь тодорхой үр дүнг авчирхаар байна.

Эхний ээлжид үндэсний бичгийг албан ажилдаа зайлшгүй хэрэглэх шаардлагатай албан хаагчдыг шалгалтад хамруулж, мэдлэгийн түвшинг бодитой тогтоож, мэдлэгийн түвшинд нь тохируулан шат дараалсан сургалт зохион байгуулах нь үр дүнтэй юм.

Үндэсний бичиг хэл бүх нийтээр эзэмшиж, хэрэглээ болгоход ямар бэрхшээл тулгарч байна вэ?

1. Хүн бүрт үндэсний монгол бичиг, соёлоороо бахархах үзэл төлөвшүүлэх.
2. Монгол бичгийг сурах, сургах, түгээн дэлгэрүүлэх төрийн бодлого, хууль эрх зүйн баримт бичгийг нийтэд сурталчилж ойлгуулах явдал дутмаг
3. Монгол бичгийг сурах, сургах, түгээн дэлгэрүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажил хийгдэж байгай хэдий ч удааширалтай
4. Хэрэглэх орчин байхгүй учир ач холбогдол өгөх нь бага
5. Дунд сургуульд орж байгаа цаг гадаад хэлний цагаас ч бага байдаг.
6. Эцэг эхчүүд монгол бичгийн хичээлд ач холбогдол өгч хамтран хичээллэдэггүй, өөрсдөө мэддэггүй учраас тусалж чаддаггүй.
7. Монгол бичгийн хичээлийн хэрэглэгдэхүүн дутмаг, материал хомс, нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон гарын авлага дутмаг байдаг. Суралцагчдад үлгэр жишээ авмаар анги танхим цөөн. .
8. Хувь хүний идэвх чайрмайлт сул зэргийг дурдаж болно.



# THE CULTURAL WAY

## ДҮГНЭЛТ

Монголчуудын үндэсний бахархал, Монголын ард түмний оюуны соёлын давтагдашгүй өв, монгол бичиг юүгээ төрийн бичиг болгон, залуу хойч үедээ эзэмшүүлэн уламжлуулах, үндэснийхээ бичиг соёлыг хадгалан үлдэх нь хүн төрөлхтний өмнө Монголчуудын хүлээсэн үүрэг билээ. Бүх нийтийг монгол бичигтэн болгох ажлыг эрчимжүүлэхэд дараах хэдэн зүйлийг анхаарах нь зүйтэй болов уу.

- Монгол бичгийг сурах, сургах, түгээн дэлгэрүүлэх бодлогыг эрчимжүүлэх.
- Монгол бичгийн хэрэглээг бий болгох.
- Бүх нийтийг монгол бичигт сургах сургалтыг үе шаттай зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургуулийн VI-XII дугаар ангид судлах монгол бичгийн цагийг нэмэгдүүлэх, багшийн заах арга зүй, сургалтын чанарыг сайжруулах.
- Их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийн дэргэд хичээлээс гадуур монгол бичгийн дугуйлан, сургалт хичээллүүлэх, тэмцээн уралдаан зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн монгол хэл, монголын түүх, уран зохиол, иргэний боловсрол, ёс суртахууны хичээлийн сурах бичгийг нэн түрүүнд, бусад хичээлийн сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүнийг монгол бичигт хөрвүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрт —Монгол бичиг-ийн хичээлийг заавал судлахаар тусгаж хэрэгжүүлэх
- Ажил олгогч Монгол хэлний тухай хуулийн 7.4, 19.1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх.

## НОМ ЗҮЙ

1. Монгол хэлний тухай хууль УБ., 2015
2. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, II, III
3. Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай ерөнхийлөгчийн зарлиг УБ., 2010
4. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр БСШУЯ УБ., 2015
5. Ш.Үнэнтөгс Төгс эрх зүйн төлөөх тэмүүдэл УБ., 2013.
6. Г.Цэрэндорж. БНМАУ-д бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгасан нь. УБ., 2001.
1. Монгол улсын үндэсний статистикийн хороо —Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021II

ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНААС ҮҮССЭН МАРГААНД ХҮҮХДИЙН ЭРХИЙГ  
ХАМГААЛАХ ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ц.Түвшинбаяр\*

## ХУРААНГУЙ

Гэр бүл бол хүүхэд амьдрах, хөгжих, төлөвших анхдагч орчин байдаг. Тиймээс хүүхэд хамгааллын асуудлыг гэр бүлийн орчин, эцэг эхийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн бусад гишүүдийн оролцооноос салган үзэх боломжгүй билээ. Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болох бөгөөд шүүх гэрлэгчдийн гэрлэлтийг цуцалснаар гэрлэлтийн харилцааг дуусгавар болгохын зэрэгцээ өөр эрх зүйн харилцааг шинээр үүсгэнэ. Тухайлбал: хүүхдийн асрамж, тэтгэлэг буюу асран хамгаалалтын болон тэжээн тэтгэх харилцааг шинээр үүсгэдэг байна. Монгол улсын хэмжээнд 13436 хүүхэд 2022 оны байдлаар тэтгэлэг авч байна. Монгол улсын хэмжээнд хүүхдийн тэтгэлэг тогтоох эрх зүйн зохицуулалтын асуудал нийгэмд тулгамдсан асуудлын нэг болж байна. Тиймээс Хүүхдийн тэтгэлэг тогтоох ойлголт, эрх зүйн зохицуулалт түүхэн уламжлал, зохицуулалтын талаар судлаад зогсохгүй өнөөгийн хүүхдийн тэтгэлэг тогтооход тулгамдаж буй асуудлуудыг судлахыг зорьсон. Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд: Хүүхдийн тэтгэлэг тогтоох ажиллагааны ойлголт, Хүүхдийн тэтгэлэг тогтоох шүүхийн тогтоол, практикт хийсэн дүн шинжилгээ Түлхүүр үгс: *Гэр бүл, гэр бүлийн харилцаа, хүүхдийн эрх, гэр бүлийн маргаан, хүүхдийн тэтгэлэг,*

Хүүхдийн тэтгэлэг тогтоох ажиллагааны ойлголт, онцлог

Статистикаас хархад Шүүхийн шийдвэрээр жилд 4000 орчим гэр бүл цуцлуулж, мянга хүрэхгүй тохиолдолд хүүхдийн тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэдэг байна. Үлдсэн 3,000 орчим салалтаас хүүхдийн тэтгэмж авч чаддаггүй. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хуулиар цуцлуулсан тохиолдолд 0-11 насны хүүхдэд амьжиргааны доод түвшний 50 хувиар буюу 100 орчим мянган төгрөгийн тэтгэмж тогтоодог. Харин хүүхэд 11 наснаас дээш бол амьжиргааны түвшинтэй тэнцүү хэмжээний тэтгэмж тогтоодог заалттай. 2021 оны байдлаар өрх толгойлсон 72 мянган эх, 19.5 мянган эцэг байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд зааснаар эцэг эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн

\* ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч



## THE CULTURAL WAY

тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заажээ. Хэрэв тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг шүүх тогтоох бөгөөд хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно.<sup>1</sup>

Гэр бүлийн баталгаагүй тухайлбал гэрлэлтээ бүртгүүлээгүй бол тэтгэлэг тогтоолгох үндэслэл: Гэр бүлийн тухай хуульд гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхэдтэй адил эрх эдэлж, үүрэг хүлээдэг учир хүүхэддээ тэтгэлэг тогтоолгох боломжтой. Хүүхэд эцгээрээ овоглодог бол эсхүл хүүхдийн эцэг мөн эсэх тал дээр маргаангүй бол эцэг тогтоолгох шаардлагагүй юм. Харин хүүхдийн эцэг мөн эсэх дээр маргаантай бол хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, эцэг тогтоолгох нэхэмжлэлийг хамт гаргах нь зүйтэй. Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргана. Нэхэмжлэлд дараахь баримтуудыг хавсаргана. Үүнд: нэхэмжлэл, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хорооны засаг даргын тодорхойлолт, хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар, Хүүхэд эрүүл өсөн бойжиж байгаа талаарх тодорхойлолтыг өрхийн эмнэлэгээс авах, сургуулийн тодорхойлолт зэрэг баримтуудыг бүрдүүлнэ.<sup>2</sup> Тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа гэдэг нь гэр бүлийн гишүүний аль нэг нь нөгөөдөө хуульд заасан журмын дагуу материаллаг тусламж үзүүлэхтэй холбогдсон гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаа юм. Тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаанд оролцогч субъектыг бүрэлдэхүүний хувьд эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, гэрлэгчид бие, биенээ, төрөл садангийн хүмүүс бие биенээ тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа гэж ангилан үзнэ.<sup>3</sup> Үүнд:

1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар
2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр<sup>4</sup>

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2017 он/ хуулиар зохицуулдаг буюу энэхүү хуульд заасан журмын дагуу шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааг явуулдаг. Хүүхдийн тэтгэмж тогтоолгох тухай шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон боловч хариуцагч буюу хүүхдийн эцэг төлбөрөө зохих ёсоор төлөхгүй буюу шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй байх тохиолдолд

<sup>1</sup> А.Дугармаа. “Гэр бүлийн эрх зүй”. УБ., 2006 он

<sup>2</sup> А.Батбаатар, Р.Булгамаа “Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал”. УБ., 2017 он

<sup>3</sup> Б.Амарбаясгалан “Эрх зүйн үндэс” УБ., 2015 он

<sup>4</sup> Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. 1999.06.11.//Төрийн мэдээлэл. УБ., 1999. № 30.



## THE CULTURAL WAY

“Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой, эсхүл төлбөр төлөгчид тодорхой хугацааны туршид давтамжтай төлбөр төлөх болон бусад үүрэг хүлээлгэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид албадан гүйцэтгэж болно.”<sup>5</sup> гэж заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дагуу хүүхдийн төлбөрийг албадан гаргуулахаар шүүхэд хэдийд ч хандах боломжтой. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хариуцагч буюу хүүхдийн эцэг гадаадад зорчих эрхийн тухайд 59 дүгээр зүйлийн 59.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэхийг хориглоно.” гэж заасны дагуу гадаадад зорчиход зөвшөөрөл авах шаардлагагүй байна.

Харин зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй этгээдээс тэтгэлэг гаргуулах тохиолдолд хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй. Хүүхдийн тэтгэлгийг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд зарцуулах ба тэтгэлгийг тухайн хүүхдийн өөрийнх нь хэрэгцээнд зарцуулаагүй болох нь тогтоогдвол тэтгэлэг төлөгч /эцэг, эх/ тэтгэлгийг зориулалтын дагуу зарцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Мөн хүүхдийн тэтгэлгийг мөнгөн хэлбэрээр юм уу аль эсвэл эд хөрөнгөөр олгож болох бөгөөд сар, улирал, хагас жил, жилээр, эсхүл нэг удаа бөөнд нь олгож болно. Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болдог. Харин шүүхийн шийдвэрээр суутгах, эсхүл тэжээн тэтгэх гэрээний дагуу төлөх хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь тэтгэлэг төлөгчийн цалин хөлсний 50 хувиас хэтэрсэн буюу шүүхээр өөр тэтгүүлэгчид тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн бол тэтгэлэг төлөгч тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Мөн тэтгэлэг төлөгч нь шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлөх үүрэгтэй бөгөөд алдангийн нийт хэмжээ нь төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байхаар хуульд заасан байна. Тэтгэлэг олгогдох хүүхдийн наснаас хамаараад тухайн нэхэмжлэлд төлөгдөх улсын тэмдэгтийн хураамж өөр өөр байдаг. Тухайлбал, 11 хүртэлх насны хүүхдийн тэтгэлэг гаргуулах бол: (тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувь) х 12=(1 жилийн хугацаанд төлбөл зохих дүн гарна) 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдийн тэтгэлэг гаргуулах бол: (амьжиргааны доод түвшингийн хэмжээ) х 12=(1 жилийн хугацаанд төлбөл зохих дүн гарна). Шүүхийн шийдвэрээр суутгах, эсхүл тэжээн тэтгэх гэрээний дагуу төлөх хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь тэтгэлэг төлөгчийн цалин хөлсний 50 хувиас хэтэрсэн буюу

<sup>5</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт



## THE CULTURAL WAY

шүүхээр өөр тэтгүүлэгчид тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн бол тэтгэлэг төлөгч тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Тэжээн тэтгэх гэрээ - 1999 оны Гэр бүлийн тухай хуулийн нэг онцлог бол хуульд зааснаар гэрлэгчид бие биеэ, эцэг эх нь үр хүүхдээ, насанд хүрсэн хүүхэд нь хөдөлмөрийн чадваргүй болсон эцэг, эхээ, төрөл садангийн хүмүүс бие биеэ тэжээн тэтгэх үүргийг тэжээн тэтгэх гэрээ байгуулсаны үндсэн дээр харилцан тохиролцож хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож өгсөнд оршино.

Тэжээн тэтгэх гэрээгээр тэтгэгч, тэтгүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр тэжээн тэтгүүлэх эрх үүссэнээс хойш тохиролцсон нөхцөлөөр бие биеэ тэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Тэжээн тэтгэх гэрээний оролцогч нь нэг талаас бусдыг тэжээн тэтгэх үүрэг хүлээсэн тэтгэгч, нөгөө талаас тэтгэгчээс материаллаг тусламж зайлшгүй шаардлагатай болсон тэтгүүлэгч байна. Хүүхдэд олгох тэтгэлгийг хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар, 11-16 настай /суралцаж байгаа бол 18/, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтооно.<sup>19</sup>

Хүүхдийн тэтгэлэг тогтоох - Шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлээд түүнд олгох тэтгэлгийг хуульд заасан журмын дагуу тогтоож байгаа ажиллагааг ойлгоно. Хүүхдийн тэтгэлгийн асуудлаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх гэрээ байгуулах боломжтой бөгөөд энэ талаар тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам, хүүхэд тус бүрт тэтгэлгийг тогтооно. Гэрээний тэтгэгч тал нь үүрэг хүлээсэн учраас нэг талын, хариу төлбөргүй гэрээ юм. Тэтгэгч нь тэтгүүлэгчийг тэтгэсний төлөө хариу төлбөр нэхэх, эд хөрөнгө, мөнгө шаардах эрхгүй ба тэтгүүлэгч тэтгэгчид буцааж төлбөр төлөх үүрэг хүлээхгүй. Тэжээн тэтгэх гэрээг бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлсэн байна. Энэхүү гэрээнд талууд тэтгэлгийн хэмжээ, хэлбэр, хугацаа зэргийг тодорхой тохиролцоно. Тэтгэлгийн хэмжээг талууд тохиролцоходоо тэтгэгчийн цалин, орлогын тодорхой хувийг эсхүл тодорхой хугацаагаар тогтмол мөнгөн дүнгээр, эсвэл гэрээний нийт хугацаанд нэг удаа тодорхой мөнгө буюу эд хөрөнгөөр тохиролцох боломжтой. Гэрээгээр тохиролцох тэтгэлгийн хэлбэрийн хувьд мөнгөн эсхүл эд хөрөнгө байж болно. Тэтгэлгийг эд хөрөнгөөр тохиролцвол түүний үнийг зах зээлийн тухайн үеийн ханшаар тогтооно.

Гэр бүлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т тэтгэлгийг сар, улирал, хагас жил, жилээр эсхүл нэг удаа олгохоор гэрээндээ зааж болно. Тэтгэгч тэтгэлгийг хугацаандаа төлөхгүй бол учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хожигдуулсан хоног тутамд алданги төлүүлэхээр тохиролцож болно. Гэрээний талууд харилцан тохиролцсоноор гэрээг өөрчлөх, цуцлах хуулиар зөвшөөрөгдсөн ямарч нөхцөлийг тусгаж болох бөгөөд өөрчлөх, цуцлах талаар хэдийд ч харилцан тохиролцож болно. Энэхүү гэрээг өөрчлөх,



## THE CULTURAL WAY

цуцлах тухай тохиролцоог бичгээр үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байна. Тэжээн тэтгэх гэрээг өөрчлөх, цуцлах талаар маргаан гарвал шүүх шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уг хуулийг УИХ-аас 2002 онд батлан гаргаж, одоо мөрдөж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулж байгаа нэг гол харилцаа нь шүүхээс гаргасан буюу түүнээс баталгаажуулсан шийдвэрийг албадан биелүүлэхтэй холбогдсон харилцаа юм. Уг хуульд хүүхдийн тэтгэлэг албадан гаргуулах журам, асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байх хүнийг шилжүүлэхтэй холбогдсон зэрэг олон асуудлыг тусгаж өгсөн юм. Тэтгэлэг тогтоохтой холбогдсон харилцаа нь түүхэн талаасаа дараах байдлаар зохицуулагдаж ирсэн байна.

- Гэрлэгчид, эцэг, эх, хүүхэд, төрөл садангийн хүнд тэтгэлэг тогтоох
- Тэтгэлгийн хэмжээг өөрчлөх
- Тэжээн тэтгэх гэрээг өөрчлөх, цуцлах
- Тэжээн тэтгэх тухай гэрээг биелүүлэх
- Тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөх
- Хариуцагчаас нэмэлт зардал гаргуулах
- Тэтгэлгийг нөхөн төлүүлэх

Монгол улсын хэмжээнд сүүлийн зургаан жилийн хугацаанд гэрлэлт цуцлалттай холбоотой 10,000 орчим шүүхийн шийдвэр шүүхийн цахим санд байршсанаас дийлэнх хувьд нь хүүхдийн тэтгэлэг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагатай байгаа бөгөөд Гэр бүлийн маргаанд хүүхдийн эрх ашиг шууд хөндөгдөж байдаг тул гэрлэлт цуцлалтын улмаас үүсэх хүүхдийн эрхийн зөрчлүүд мөн яригдах нь зүйтэй юм. Гэр бүлийн эрх зүйн зохицуулах зүйлийн хүрээнд хамрагдах нийгмийн онцлог харилцаа бол гэр бүлийн гишүүдийн бие, биеэ тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа юм. Тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа гэдэг нь гэр бүлийн гишүүний аль нэг нь нөгөөдөө хуульд заасан журмын дагуу материаллаг тусламж үзүүлэхтэй холбогдсон гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаа юм. Тэжээн тэтгэх харилцааны агуулга нь харьцангуй амины шинжийг агуулсан эрх үүргээр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл тэжээгч нь тэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргийг хэн нэгэнд шилжүүлэх бэлэглэх өв залгамжлалаар үүрэг болгох боломжгүй бөгөөд тэжээн тэтгэгч, эсхүл тэтгүүлэгч нас барсан тохиолдолд тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно. Тэжээн тэтгэх харилцаа нь харьцангуй үргэлжилсэн мөн хариу төлбөр шаарддаггүй гэдгээрээ онцлог юм. Тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаанд оролцогч субъектын байдлаас шалтгаалан:





## THE CULTURAL WAY

1. Эцэг, эх нь хүүхдээ
2. Хүүхэд нь эцэг, эхээ
3. Гэрлэгчид бие, биенээ
4. Төрөл садангийн хүмүүс бие биенээ тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа гэж ангилан үздэг.

Гэр бүлийн харилцаанаас хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж үздэг. Хүүхэд төрснөөр эцэг, эхийн үүрэг үүсдэг бөгөөд хүүхдээ асран хамгаалж, тэжээн тэтгэх үүрэг үүсдэг тул гэр бүлийн маргаан гэрлэлт цуцлалтын үед эцэг, эх байх үүргээсээ салж үл болох жам ёсны үүрэг, хариуцлага юм. Иймд гэр бүлийн харилцаа эхнэр, нөхрийн харилцаа нь дуусгавар болсон ч хүүхдийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлага үргэлжилсэн шинжтэй, ямар нэгэн байдлаар хязгаарлаж үл болох үүрэг юм. Гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эх нь хүүхдээ аль нэгнийхээ асрамжинд үлдээж байгаагаас шалтгаалан нөгөөдөө хүүхдээ тэжээн тэтгэх, асран халамжлах бүхий л талаар туслалцаа, дэмжлэгийг үзүүлдэг. Эцэг, эх нь хүүхдээ асран, тэжээн тэтгэхтэй холбогдуулан гэрээ хийгээгүй бол шүүхээс тухайн харилцаатай холбогдуулан хуулиар зохицуулж өгсөн байдаг. Шүүхээс хүүхдийн тэтгэлэг тогтоохтой холбогдуулсан нэхэмжлэл, маргааны үүднээс хуульд заасаны дагуу тэтгэлгийг тогтооно.

Шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлээд түүнд олгох тэтгэлгийг хуульд заасан журмын дагуу тогтоож байгаа ажиллагааг ойлгоно. Хүүхдийн тэтгэлгийн асуудлаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх гэрээ байгуулах боломжтой бөгөөд энэ талаар тохиролцож чадаагүй бол Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам, хүүхэд тус бүрт тэтгэлгийг тогтооно.

Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.Эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй гэж заасан байдаг бөгөөд эцэг, эх нь хүүхдийнхээ өмнө ижил тэгш үүрэг, хариуцлагыг хүлээх ёстой. Иймээс гэрлэлт цуцлалттай холбогдуулан эцэг, эх нь тэжээн тэтгэхтэй холбогдуулан гэрээ хийж болох бөгөөд энэ тухай гэрээ хийгээгүй бол шүүхээс тэтгэлгийн хэмжээг тогтоож өгнө. Тэтгэлгийн хэмжээг долоогоос доош насны хүүхдэд тухайн оршин суугаа бүс нутгийнхан амжиргааны доод түвшиний 50 хувиар долоогоос арван найман нас хүртэлх хүүхдэд амжиргааны доод түвшинтэй тэнцэх хэмжээний тэтгэлгийг төлөх үүрэгтэй юм. Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтооно гэж заажээ.”<sup>6</sup>

Шүүхийн тогтоолд хүүхдийн тэтгэлэг тогтоох практикт хийсэн дүн шинжилгээ

Тав: Улсын дээд шүүхийн тогтоол: Хүүхдийн тэтгэлэг.

---

<sup>6</sup> Гэр бүлийн тухай хууль.1999 но





## THE CULTURAL WAY

Дархан-Уул аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 979 дүгээр шийдвэрээр Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2 дахь хэсэгт зааснаар 2007 оны 12 дугаар сарын 02-нд төрсөн охин О.О-ыг 11 нас хүртэл тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар, 11-16 нас хүртэл /суралцаж байгаа нөхцөлд 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр сар бүр тэтгэлэг гаргуулан эцэг Р.Ц-ээр тэжээн тэтгүүлж, 21500 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт зааснаар зөвхөн цалин хөлснөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүйг дурдаж, Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх, асран хамгаалах, тэжээн тэтгэх, үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох, хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах үүргээ хэрэгжүүлж байхыг эцэг Р.Ц, эх Ц.Онарт даалгаж, зохигчид нь эд хөрөнгийн маргаангүй болохыг дурдаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3, 63 дугаар зүйлийн 63.1.5-д зааснаар нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдсөн болохыг дурдаж, хариуцагчаас нэг жилийн хугацаанд төлөгдвөл зохих хүүхдийн тэтгэлгийн хэмжээнд улсын тэмдэгтийн хураамж тооцож 28 209 төгрөг гаргуулж төрийн сангийн орлогод оруулж шийдвэрлэжээ. Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 162 дугаар магадлалаар Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 979 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагч Р.Ц-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.4-т зааснаар хариуцагч Р.Ц-ийн давж заалдах гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 28 209 төгрөгийг төрийн сангийн орлогод хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Улсын Дээд шүүх шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Үйл баримтын тухайд: Нэхэмжлэгч Ц.О охин О.О-д холбогдуулан хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, замын зардал 21 500 төгрөг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасныг хариуцагч эс зөвшөөрч, “охин О.О миний хүүхэд гэдэгт эргэлзэж байна, мөн би өөрийн хүү Р.М-г өсгөн хүмүүжүүлж байгаа тул хүүхдийн тэтгэлэг төлөхгүй” гэж маргажээ. Хэрэгт авагдсан баримтаар Ц.О, Р.Ц нар 2005 оноос хамтран амьдарч, 2006 онд хүү Р.М, 2007 онд охин О.О нар төрсөн. 2007 оноос хойш эх Ц.О охин О.О-тай хамт нөхөр, хүүгээсээ тусдаа амьдарсан байна. Хариуцагч Р.Ц Р.М-г 2007 оны 8 дугаар сард өөрийн эцэг Е.Р-д үрчлүүлсэн нь Үрчилсний бүртгэлийн лавлагаагаар нотлогдож байна.



## THE CULTURAL WAY

2007 оны 12 дугаар сарын 02-ны өдөр төрсөн охин О.О-ын биологийн эцэг байх 99.9%-ийн магадлалтай болох нь ДНХ-ийн шинжилгээ хийсэн 2013 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 3408 дугаартай шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон байх тул Гэр бүлийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.-д зааснаар охин О.О-ыг тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Хоёр шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулж, хэргийн оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг зөрчөөгүй байна.

Зургаа: Улсын Дээд шүүхийн тогтоол:

Зохигчид 1999 онд гэр бүл болсон ба хамтран амьдрах хугацаанд охин Г.О 1999 онд, Г.А 2003 онд төржээ.

Хэргийн 41-45 дугаар талд авагдсан шинжээчийн дүгнэлтэд “...гэрлэгчдийн хэн аль нь хүүхдэд зөв хүмүүжил, төлөвшил олгох, хүүхэд хөгжүүлэх арга барил сайтай, хүүхдэд анхаарал халамж сайн тавьдаг болохыг дурдаж, охин Г.О, Г.А нарыг эх Д.А-ийн асран хамгаалалтад үлдээх талаар дүгнэлт гаргажээ.

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-т зааснаар хүүхэд долоо ба үүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзэх ба охин Г.О, Г.А нар шүүхэд гаргасан тайлбартаа “...аав С.Г-тай хамт амьдрах саналтай” гэжээ.

Насанд хүрээгүй хүүхдүүдийн одоогийн амьдарч буй нөхцөлийг өөрчлөх тодорхой шалтгаан байхгүй байхад өсөж төрсөн, мөн дассан орчныг солих нь хүүхдийн эрх ашигт нийцэхгүй гэж үзнэ. Анхан шатны шүүх хэрэгт авагдсан баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзэж, охин Г.О, Г.А нарыг эцэг С.Г-ын асрамжид үлдээсэн нь Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7-г зөрчөөгүй байна. Гэр бүлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүүхдийн асрамжийг өөрчлөх тодорхой нөхцөл үүссэн тохиолдолд Д.А нь хүүхдийн асрамж өөрчлөх нэхэмжлэл гаргахад энэхүү тогтоол саад болохгүй гэж дүгнэж, магадллыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

-Хүүхдийн асрамж

-Хүүхдийн тэтгэлэг

-Хүүхдэд ногдох дундын өмчийн асуудлыг шийдвэрлэх хуулийн зохицуулалттай.

Цаашид хүүхдийн асрамж, тэтгэлэг, болон дундын өмч шийдвэрлэж байгаа эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлж байгаа шүүхийн практикийн талаар судлах болно. Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд зөвлөгөө өгөх, гэр бүл дэх хүүхдийн эрхийн баталгааг хангах, эрхдэлд нөхцөлд байгаа хүүхдийн өмчийг хамгаалах, гадаадын харьяат гэр бүлд хүүхэд үрчлэх асуудлыг шинээр, хүүхэд үрчлэлт, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагын асуудлаар гэр бүлийн асуудлыг нарийвчлан



## THE CULTURAL WAY

зохицуулах нь хүүхдийн эрхийг хамгаалах чухал механизм төдийгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах гэр бүлийн өмнө хүлээсэн төрийн үүрэг мөн.

### ДҮГНЭЛТ

Хүүхдээ тэжээн тэтгэхээс зайлсхийж байгаа үйлдэл нь цаашлаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт тэтгэлэг төлөхгүй байдлаар үргэлжилж байгаа нь харамсалтай юм. Хүүхдийн тэтгэлгийг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд зарцуулах ба тэтгэлгийг тухайн хүүхдийн өөрийнх нь хэрэгцээнд зарцуулаагүй болох нь тогтоогдвол тэтгэлэг төлөгч /эцэг, эх/ тэтгэлгийг зориулалтын дагуу зарцуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Хүүхдийн тэтгэлэг нэхэмжлэхгүй, эсхүл төлөхгүй гэж зайлсхийх явдал нь цөөнгүй байгаа бөгөөд энэ тохиолдолд хүүхдийн хэрэглээг хязгаарлах, эдийн засгийн хувьд дутагдах нөхцөл байдал үүсч байна. Яагаад үр хүүхдээ бодитоор өсгөн хүмүүжүүлэх үүргээ биелүүлээгүй атлаа хүүхдийг тэжээн тэтгэхээс зайлсхийж, орлого нуун дарагдуулж байгаа тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага гарч байна.

### НОМ ЗҮЙ

1. Т.Мөнхжаргал. “Гэр бүлийн эрх зүй”, УБ., 1995 он
  2. А.Дугармаа. “Гэр бүлийн эрх зүй” УБ., 2005 он
  3. А.Дугармаа. “Гэр бүлийн эрх зүй” УБ., 2006 он
  4. Батбаатар, Булгамаа. Гэр бүлийн эрх зүйн зарим асуудал УБ., 2017 он  
буууХ тогтоомж:
1. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль 1999 он
  2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2000 он
  3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

### Санал:

Дээрх судалгаандаа үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд: Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайсхийсэн тэжээн тэтгэгч /эцэг, эх/-д тооцох хууль зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар тэтгэлэг төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлж, тэтгэлэг төлөхгүй байгаа тохиолдолд бусад эрхийг хязгаарладаг хууль зүйн зохицуулалтыг бий болгох

БАГШ ХӨГЖИХӨД ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ  
НЭМЭГДҮҮЛЭХ, БАГШ БҮР ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Ц.Өнөболд\*

## ХУРААНГУЙ

Манай ард түмэн сурган хүмүүжүүлэх арвин баялаг туршлагаар хойч үеэ сургаж боловсруулж ирсэн уламжлалтай. “Ном дор мөргөмүй, багш дор мөргөмүй” хэмээн ухаант ард маань багшийг хүндлэн дээдэлж ирсэн. Өнөөдөр дэлхий нийтээрээ хүний хөгжилд анхаарлаа хандуулж, улс орны хөгжил хүний хөгжлөөр тодорхойлогдож байна. Хүний хөгжлийн үндэс нь мэдлэг боловсрол юм. Багшаа хөгжүүлэх асуудлыг шинжлэх ухааны үндэстэй хийж байгаа улс оронд л боловсролын шинэчилэл нийгмийн хэрэгцээг хангахуйцаар шийдвэрлэгддэг болохыг олон Улсын туршлага харуулж байна. Багш нар багаар хамтран хичээлээ бэлтгэж байх үедээ бие биеэсээ суралцах, туршлага солилцох ойлголтын зөрүүгээ арилгах, дэмжих зэргээр ажиллах бөгөөд энэ үед багш бас хөгжиж байдаг. Багш нарын хичээлийн судалгаанд тулгуурлан буй хичээлийн чанар өгөөж нь жилийн жилд чанаржиж, сурагчдаар мэдлэг бүтээлгэх арга зүй нь сайжирч, олон хувилбарт болж байгаа нь багш нар ажлын байранд хөгжиж байгаагийн гол илрэл юм.

Түлхүүр үгс: *Хувь хүний хөгжлийн хэрэгцээ, багшийн хөгжил, хамтын ажиллагаа, багш*

Багшийн хөгжил нь нийгмийн хөгжил, боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, хөгжилтэй тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Монгол улсын хөгжлийн хэмжүүрт таван зүйл ордгийн хоёрдугаарт хүний хөгжил ордог байна. Эндээс үзвэл, хувь хүний хөгжих өөрчлөгдөх хэрэгцээ нийгмийн хөгжлөөс хоцорч болохгүй нь тодорхой. Гэтэл багшийн хөгжлийн хэрэгцээг төдийлөн анхаарахгүй байх нь боловсролын өөрчлөлт шинэчлэлд багшийн хөгжил-багш хүний хүчин зүйл, хувь багшийн идэвхтэй оролцоо, хувь нэмрийг дутуу үнэлж байна гэсэн үг юм.

Багшийн хөгжил нь нийгмийн хөгжил, боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт, хөгжилтэй шууд хамааралтайгаар тасралтгүй үргэлжлэх үйл явц. Багшийн хөгжил гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг хэлнэ

---

\* ДХИС-ийн ЭЗНУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш цагдаагийн ахлах дэслэгч



## THE CULTURAL WAY

Хонконг, Австрали, Япон, Англи, Индонез, Финланд, Шотланд, Итали, Малайз, Сингапур зэрэг улсын багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг харьцуулан судалсан судалгаанд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил (Continuing professional development)-ийг тогтолцоонд нь авч үзэж, багш өөрийн хөгжих хэрэгцээнд үндэслэн мэргэжил дээшлүүлэх олон талт үйл ажиллагаанд идэвхтэй оролцох замаар насан туршдаа суралцах, хөгжих үйл явц хэмээн томъёолсон байна. Багш өөрийгөө хөгжүүлэхийн тулд мэргэжлийн хөгжлийн явцад “юуг, хэрхэн, хэзээ, хаана” өөрчлөн шинэчлэх вэ? гэдгийг судалж, оновчтой шийдлийг сонгон бүтээлчээр хэрэгжүүлэх хэрэгтэй. Сурахуйн аль нэг тохиромжтой онол баримтлалыг баримжаалан гадаад орчны таатай дэмжлэгт тулгуурлан, өөрийгөө үнэлэх, өөрийгөө хөгжүүлэх замаар багшлах үйл ажиллагаандаа эргэцүүлэл хийж, хөгжих боломж багш бүхэнд байна. Багш нар мэргэжлийн практик үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандаж, бүтээлчээр сэтгэж чадвал практик үйл ажиллагаанд ахиц өөрчлөлт гарч мэргэжлийн хувьд өсөх боломжтой юм

Боловсролын салбарын өөрчлөлтийн хүрээнд багш боловсролын чанарын асуудал чухал ач холбогдолтойг Европын Холбооны баримт бичгүүдэд онцлон тэмдэглэж байна. Тухайлбал, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага (OECD)-аас 2010 онд гаргасан “Бүх нийтийн чадамжид оруулах хөрөнгө оруулалт” хэмээх баримт бичиг стратегийн зорилтод “Багш нар бол хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн туршлагыг хөхүүлэн дэмжих онцгой чухал хүмүүс юм” гэж тодорхойлсон байна. Өнөөдөр Европын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага (OECD)-аас багшлахуйг дараах байдлаар авч үзэж байна. Үүнд:

1. Дээд зэргийн мэдлэг, чадвар, дадал шаардсан мэргэжил: Мэргэжлийн шинжлэх ухааны мэдлэг, чадвар төдийгүй сурган хүмүүжүүлэх мэдлэг, багш бие хүний чанарыг дээд түвшинд эзэмшсэн, багшийн ажлыг хийхэд тавигдах стандартыг хангасан байх)

2. Тасралтгүй, насан туршдаа суралцах нөхцөлд оршин байх мэргэжил: Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломжоор хангагдах ёстой. Мэргэжил дээрээ хөгжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг нь урамшуулж байх хэрэгтэй.

3. Хувьсан өөрчлөгдөх мэргэжил: Нэгэн хэвийн бус, хувьсан өөрчлөгдөх байдал нь багш боловсролын анхан шатны болон ахисан түвшний хөтөлбөрүүдийн гол бүрдэл хэсэг байх болно.

4. Түншлэлд тулгуурласан мэргэжил: Багш боловсролын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд нь ажлаа сургалтын байгууллагуудтай хамтарч зохион байгуулах, сургуульд тулгуурласан сургалт зохион байгуулдаг түнш байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай.



## THE CULTURAL WAY

### Багшийн хөгжил төлөвшлийн үе шат

Ажилласан жил	Гол шинж	
1-3	Шинээр эхлэх орчиндоо дасан зохицох, байр сууриа хайх, хөлөө олох, “нээлт хийх	
4-6	Тогтворжих байр сууриа олох	
7-18	Туршилт “Идэвхжил”	Эргэцүүлэл “Өөртөө эргэлзэх”
19-30	Туйлшрал, тоомсоргүй хандлага	Хуучнаа хадгалж үлдэх
31-41	Орчиноос тасарч хэт чөлөөтэй болох	

Энэхүү “Багшлах ажилд дадах, тасралтгүй суралцах загвар”-аас харахад багш байгаа байдалдаа сэтгэл ханалгүйгээр өөрийн хуримтлуулсан мэдлэг чадвараа мэргэжлийн үйл ажиллагааны үе шат бүртээ хөгжүүлэн боловсролын үйлчилгээний чанарыг ахиулах, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн төлөө шаргуу ажиллан тсралталтгүй хөгжих шаардлагатай нь харагдаж байна.

Энэ хуулийн “Багшийн хөгжлийг дэмжих” гэсэн үгний утга санаа нь “багшийг хөгжүүлэх” гэснээс багш нар “өөрсдөө, өөрөө өөрийгөө хөгжүүлэх” хувийн төлөвлөгөөтэй ажиллаж, сургууль болон бусад төв, орон нутгийн боловсролын байгууллагууд тэрхүү “төлөвлөгөөнийх нь хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” хөтөлбөртэй байж хамтран ажиллана гэсэн утгатай гэж ойлгож байгаа юм. Өөрөөр хэлбэл хуулийн нэрээс нь эхлээд зөв ойлгож, багш хөгжих үйл явцыг жинхэнэ хувь хүний хөгжин төлөвших зүй тогтлын дагуу дэмжин хөтлөх нь чухал юм. Хүн бүрийн, түүний дотор багш бүхний хувийн сонирхол, авьяас чадварын төлөвшил, ажиллаж байгаа орон нутаг, хамт олны онцлогтой уялдан харилцан адилгүй бөгөөд бүх хүнд тохирох хөтөлбөр, төлөвлөгөө байх боломжгүй нь хэнд ч ойлгомжтой.

“Хөгжил” гэдэг нь чухамдаа “чанарын өөрчлөлт” байдаг бөгөөд тэр нь цаанаа “Ямар нэгэн сул талаа засах”-тай холбоотой байх учиртай тул, “багшийн хөгжил” нь ч тухайн багшийн “өөрийнхөө алдаж, доголдож байгаа талаа засахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүн” байна. Хүн “өөрийнхөө ололт амжилт -д тайвширснаар төдийлөн алт, Хөгждөггүйг бид өөрсдийнхөө болоод салбарынхаа амьдрал, үйл ажиллагаанаас харж болно. Боловсролын хувьд тайвшрал бол хоцрогдлын эхлэл болдог” гэж ойлгоход нэг их алдаа болохгүй. Ямар ч үнэлгээнд “шалгуур гэдэг ихээхэн чухал зүйл байдаг. Бидний өнөөдрийг хүртэл нэг их олж хараагүй явсан алдаа маань чухам энэхүү энэ “шалгуур”-т байсан. Ихэнхдээ тодорхой “шалгуур”-гүйгээр үнэлж ирсэн.

Багш мэргэжлийн хөгжлөө төлөвлөхдөө дараах үе шатын дагуу цикл үйл ажиллагааг хэрэгжүүлэх шардлагатай.

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн багш, албан хаагчдаас /40 хүн/ авсан судалгаа.



# THE CULTURAL WAY

## Хүснэгт 1

Таны нас ?

Д/д	Насны ангилал	Хамрагдсан хүний тоо
1	20-30	5 хүн
2	30-40	25 хүн
3	40-50	8 хүн
4	50 дээш	2 хүн

## Хүснэгт 2

Таны хүйс?

Д/д	Хүйс	Хамрагдсан хүний тоо
1	Эрэгтэй	9 хүн
2	Эмэгтэй	31 хүн

## Хүснэгт 3

Багшлах бүрэлдэхүүнд орж ажилласан байдал?

Д/д	Ажилласан жил	Хариулсан байдал
1	0-1 жил	15 хүн
2	1-3 жил	7 хүн
3	3-7 жил	10 хүн
4	7-10 жил	2 хүн
5	10 -аас дээш жил	6 хүн

## Хүснэгт 4

Багш та өөрийгөө хөгжүүлэхийн тулд мэдээллийн ямар эх үүсвэрийг ашиглааг вэ?

Д/д	Эх үүсвэр	Хариулсан байдал
1	Сонин сэтгүүл	0 хүн
2	Радио телевизор	0 хүн
3	Сургалт семинар	6 Хүн
4	Интернэт цахим орчин	18 Хүн
5	Ном зохиол	16 Хүн



## THE CULTURAL WAY

### Хүснэгт 5

Багш та өөрийгөө хөгжүүлэх ойрын болон хэтийн зорилго байна уу?

Д/д	Сонголт	Хариулсан байдал
1	Тийм	40 хүн
2	Үгүй	0
3	Бусад	0

### Хүснэгт 6

Багш нар ажлын байрандаа хөгжихөд сургуулийн зүгээс юуг анхаарвал зохих вэ?

Д/д	Анхаарвал зохих асуудал	Хариулсан байдал
1	Багшийн урамшууллын системийг боловсронгуй болгох	14 хүн
2	Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх	14 хүн
3	Ажлын байран дахь сургалтыг сайжруулах	8 хүн
4	Техник технологийг сайжруулах	3 хүн
5	Ажлын орчинг сайжруулах	1 хүн

### Хүснэгт 7

Таныг ажлын байранд хөгжихөд юу саад болж байна вэ?

Д/д	Саад болж буй зүйл	Хариулсан байдал
1	Цалин хөлс бага	10 хүн
2	Урамшууллын систем муу	7 хүн
3	Бичиг цаасны ажил	21 хүн
4	Удирдлагын дарамт	1 хүн
5	Ажлын ачаалал хэт их	1 Хүн

### Хүснэгт 8

Багш нарын хамтын үйл ажиллагаа гэж таны бодлоор?

Д/д	Багшийн хамтын үйл ажиллагаа гэж	Хариулсан байдал
1	Багаар ажиллах	19 хүн
2	Туслан зааварчлах, зөвлөх	5 хүн
3	Бие биенээсээ суралцах үйл явц	5 хүн
4	Туршлага солилцох	2 хүн
5	Эрдэм шинжилгээний ажилд хамтрах	2 хүн
6	Нэг зорилго доор хамтарч ажиллах	1 хүн
7	Арга зүй мэдээлэл солилцох	1 хүн
8	Бие биенээ дэмжих	1 хүн
9	Багш нар хамтран хичээл бэлтгэж заах,	1 хүн





## THE CULTURAL WAY

	хөтөлбөр боловсруулах	
10	Аливаа үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх	1 хүн
11	Амбицгүй баг хамт олон байх	1 хүн
12	Хувь хүний санаачлага, бүтээлч үйл ажиллагааг хуваалцах	1 хүн

Хүснэгт 9

Манай сургуулийн хувьд багш нар ямар хэлбэрээр хамтарч ажиллаж байгаа вэ?

Д/д	Багш нар хамтарч байгаа хэлбэр	Хариулсан байдал
1	Эрдэм шинжилгээ, Судалгааны чиглэлээр	17 хүн
2	Хамтарч ажилладаггүй	11 хүн
3	Хамтарч ажиллах нь бага	7 хүн
4	Багаар	1 хүн
5	Зөвхөн бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд хамтарч байгаа	1 хүн
6	Тэнхим дотроо	1 хүн
7	Туршлага солилцох	1 хүн
8	Онол арга зүйн семинар тогтмол зохион байгуулдаг	1 хүн

Хүснэгт 10

Багш нар хоорондоо хамтарч ажиллах нь багшийн хөгжилд ямар нөлөө үзүүлэх вэ?

Д/д	Хамтарч ажиллахын үр нөлөө	Хариулсан байдал
1	Ажлын үр дүнд эерэгээр нөлөөлнө	11 хүн
2	Багш бүр жигд хөгжих боломж бүрдэнэ	11 хүн
3	Багшийн мэдлэгийг илүү хөгжүүлэх	6 хүн
4	Бие биенээсээ суралцана	5 хүн
5	Залуу багш нар туршлага хуримтлуулах	3 хүн
6	Багаар ажиллах чадавхи нэмэгдэнэ	1 хүн
7	Ажлын уялдаа холбоо сайжирна	1 хүн
8	Чухал ач холбогдолтой	1 хүн
9	Шууд хамааралгүй	1 хүн



## THE CULTURAL WAY

### Хүснэгт 11

Багш нар хамтарч ажиллахад ямар нэгэн саад байна уу?

Д/д		Хариулсан байдал
1	Харилцаа хандлага, ёс зүй зэргээс шалтгаалж	12 хүн
	Байхгүй	11 хүн
2	Багшийн БИ гэсэн үзэл	9 хүн
3	Бичиг цаасны ажил их	1 хүн
4	Ажлын ачаалал, ур чадваргүй байдал	1 хүн
5	Цагийн зөрүүтэй байдал	1 Хүн
6	Ажлыг үргэлж дангаар хувиарлаж байгаа нь	1 Хүн
7	Хувийн ашиг сонирхолоо илүүд үзэх	1 Хүн
8	Тэнхимийн хүрээнд ажлаа явуулдаг	1 Хүн
9	Бүрэлдэхүүн сургуулиудаар хязгаарлагддаг	1 Хүн
10	Үл ойлголцол	1 Хүн
11		1 Хүн

#### Судалгааны хураангуй

• Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн багшлах бүрэлдэхүүний дийлэнх хувийг 30-40 насны алба хаагчид эзлэж байна.

• Багшлах бүрэлдэхүүний 37%-ийг 0-1 жил ажилласан багш нар, 25%-ийг 3-7 жил ажилласан багш нар үлдсэн хувийг 7-10, 10-аас дээш жил ажилласан багш нар эзлэж байна.

• Багш нар өөрийгөө хөгжүүлэхийн тулд 45% нь интернэт, цахим орчноос, 40% нь ном зохиолоос үлдсэн хувь нь сонин сэтгүүл, радио телевизор, сургалт семинараас мэдээллийн эх үүсвэрийг авч байна.

• Багш бүр өөрийгөө хөгжүүлэх ойрын болон хэтийн зорилготой байна (100%)

• Багш нар ажлын байрандаа хөгжихөд сургуулийн зүгээс юуг анхаарвал зохих вэ? гэсэн асуултад 35% нь ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, 35% нь багшийн урамшууллын системийг боловсронгуй болгох, үлдсэн хувь нь ажлын орчинг сайжруулах, техник технологийг сайжруулах, ажлын байран дахь сургалтыг сайжруулах гэж хариулсан байна.

• Багш ажлын байрандаа хөгжихөд 52% нь бичиг цаасны ажил, 25% нь цалин хөлс бага, 17% нь урамшууллын систем муу, үлдсэн хувь нь удирдлагын дарамт, ажлын ачаалал саад болж байна гэж хариулжээ.

• Багш нарын хамтын үйл ажиллагаа гэж таны бодлоор? Асуултад судалгаанд хамрагдсан 40 алба хаагчийн 19 нь багаар ажиллах гэж хариулсан ба үлдсэн хувь нь туслан зааварчлах, зөвлөх, бие биенээсээ суралцах үйл явц, туршлага солилцох, эрдэм шинжилгээний ажилд хамтрах, нэг зорилго доор хамтарч ажиллах, арга зүй, мэдээлэл солилцох, бие биенээ дэмжих, багш нар хамтран хичээл бэлтгэж заах, хөтөлбөр боловсруулах, аливаа үйл ажиллагаа,



## THE CULTURAL WAY

төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, амбицгүй баг хамт олон байх, хувь хүний санаачлага, бүтээлч үйл ажиллагааг хуваалцах гэж хариулжээ.

- Манай сургуулийн хувьд багш нар ямар хэлбэрээр хамтарч ажиллаж байгаа вэ? Гэсэн асуултад судлагаанд хамрагдсан 40 алба хаагчийн 17 нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр, 11 нь хамтарч ажилладаггүй, үлдсэн хувь нь хамтарч ажилладаггүй, бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд, тэнхим дотроо, туршлага солилцох, онол арга зүйн семинар тогтмол зохион байгуулдаг зэргээр хариулжээ.

- Багш нар хоорондоо хамтарч ажилласнаар 27% нь багш бүр жигд хөгжих боломж бүрдэнэ, 27% нь ажлын үр дүнд эерэгээр нөлөөлнө, 15% нь багшийн мэдлэгийг илүү хөгжүүлнэ, 15% нь бие биенээсээ суралцана, үлдсэн хувь нь залуу багш нар туршлага хуримтлуулна, шууд хамааралгүй, ажлын уялдаа холбоо сайжирна, багаар ажиллах чадавхи нэмэгдэнэ гэх зэргээр хариулжээ.

- Багш нар хамтарч ажиллахад 30% нь харилцаа хандлага, ёс зүйгээс шалтгаалж, 27% нь байхгүй, 22% нь багшийн би гэсэн үзэл үлдсэн хувь нь ажлын ачаалал ур чадваргүй байдал, бичиг цаасны ажил их, бүрэлдэхүүн сургуулиар хязгаарлагддаг, үл ойлголцол, ажлыг үргэлж дангаар хувиарлаж байгаа нь, тэнхимийн хүрээнд ажлаа явуулдаг нь саад болж байна гэж хариулжээ.

### ДҮГНЭЛТ

Багш ажлын байрандаа хөгжихөд олон хүчин зүйлс чухал болох нь ажиглагдаж байна. Үүнд:

Багш бүр өөрийгөө хөгжүүлэх ойрын болон хэтийн зорилготой байна (100%)

2. Багш нар өөрийгөө хөгжүүлэхийн тулд интернэт, цахим орчин, ном зохиолоос мэдээллийн дийлэнх эх үүсвэрийг авч байна.

3. Багш нар ажлын байрандаа хөгжихөд сургуулийн зүгээс ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, багшийг урамшуулах системийг боловсронгуй болгохыг дийлэнх хувь нь хүсэж байна.

4. Багш ажлын байрандаа хөгжихөд бичиг цаасны ажил их, цалин хөлс бага байгаа нь саад болж байна гэж дийлэнх хувь нь үзэж байна.

5. Багш нарын хамтын үйл ажиллагаа гэж бүх хэлбэрээр багаар ажиллахыг хэлнэ.

6. Багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажлын чиглэлээр илүү хамтарч ажиллаж байна.

7. Багш нар хамтарч ажилласнаар багш нар жигд хөгжих боломж бүрдэнэ.

8. Багш нар хамтарч ажиллахад багшийн харилцаа хандлага, ёс зүй ихээхэн саад болж байна.



# THE CULTURAL WAY

## ABSTRACT

The driving force of the country's socio-economic and cultural values is the development of education. Educational development is a continuous process that evolves as a result of change. The teachers, who are the main driving force of this change, needs to consider development, understanding the way to solve the problems, and the indicators of the results. This is teachers issue emerged from daily job. The issue of teacher development has been assumed in 2 stages: prepare teacher training and professional development, on the one hand, the government policy support for teacher development, and on the other hand, the teacher's own effort. It is a link between two factors and how it is interconnected aimed to seek all opportunities for effective and development.

*Keywords: Personal needs for development, teacher development, collaboration, teacher*

## НОМ ЗҮЙ

1. Дээд боловсролын тухай хууль
2. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
3. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
4. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
5. Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
6. Монгол улсын Дотоод хэргийн их сургуулийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” (Бодлогын баримт бичиг 2021-2025)
7. Дотоод хэргийн их сургуулийн стратеги төлөвлөгөө 2016-2025
8. “Багш боловсролын шинэчлэл “ 147, 2013”
9. Жадамбаа ”Багш боловсролын шинэчлэлийн чиг хандлагийн өөрчлөлт”

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

NEWS

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвөөс  
кирилл үсэгт хөрвүүлсэн судалгааны бүтээлээс

1400 ЖИЛИЙН ӨМНӨХ ӨВӨГ  
МОНГОЛ ХЭЛ

1400 жилийн өмнөх өвөг  
МОНГОЛ ХЭЛ

Солонгод Д.Хурцбат


1400 жилийн өмнөх өвөг  
МОНГОЛ ХЭЛ



Elias Verlag IMoFiF e.V.  
Cologne Germany 2020

1400 жилийн өмнөх өвөг  
МОНГОЛ ХЭЛ

# Солонгодол Хуриватарын Хадгаламж Сууцлын Цуврал






© 2021 by Elias Verlag IMoFiF e.V. - Cologne, Germany

© 2021 by Elias Verlag IMoFiF e.V. - Cologne, Germany

# Өвөг монгол хэл - Монгол брахми бичиг



1450 онд бичигдсэн  
Монгол брахми бичиг —  
Эхний удаагийн судалгаа

Эхний удаагийн судалгаа

Elias Verlag IMoFiF e.V.  
Cologne Germany 2021




# КИРИЛЛ ҮСЭГТ ХӨРВҮҮЛЖ, ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛСЭН СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ

2021 онд анх удаа хийгдсэн "Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл"

2021 онд анх удаа хийгдсэн  
 "Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл"

Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл  
 Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл



Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл  
 Кирилл үсэгт хөрвүүлж, эрхлэн хэвлүүлсэн судалгааны бүтээл



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠠᠭᠤ ᠨᠠᠶᠢᠷᠭᠢᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠠᠭᠤ ᠨᠠᠶᠢᠷᠭᠢᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶᠢᠷᠠᠭᠤ ᠨᠠᠶᠢᠷᠭᠢᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ ᠶᠤᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨ



Mongolian Prose Anthology by S. D. HASBAATAR	
ГАРШИГ	6
ОМHOХ ҮГ	8
УДИРГАГАД	8
1. Р.Чойном ба Д.Чулуунбаярын яруу найргийн	15
2. Сүлдэгдэвчийн байдал	23
3. Судлагдахуун, судлагдахуунч	24
4. Судлагдахуунч	24
БЭГДЭДЭР БУСДЫН НАМГАР БА УРАН БУТГАА	25
Илгээгч хэсэг, Яруу найрагч Ригвичийн Чойномын намтар	40
Хөвдөгдөр хэсэг, Ригвичийн Чойномын уран бүтээлүүд	45
Гүрэмтүгч хэсэг, Ригвичийн Чойномын намтар	45
1. Энэ өрнө, утгайга, тусгайр тогтохын утга	49
2. Ардчилал, эрх чөлөөт буюу эрх чөлөөт	51
3. Могойн могойчуудтай тус тус ба чөлөөт	57
4. Илгээгч хэсэг бүтэц байгуулалт	60
5. Шүүж найргийн тусгай	62
6. Шүүж найргийн хэсэг байдал ба хайр дурлалын тусгай	63
7. Ардчилал тусгай	66
Дөрвөдүгч хэсэг, Р.Чойномын яруу найргийн	66
уран бүтээлийн онцлог	67
1. Р.Чойномын хэсэг бүтэц, стилистик онцлог	71
2. Р.Чойномын яруу найргийн стилистик онцлог	82
3. Р.Чойномын яруу найргийн ураншуул онцлог	89
4. Р.Чойномын яруу найргийн ураншуул онцлог	106
5. Утгайга могойчуудтай тус тус	122
Төгсгөл хэсэг, Д.Чулуунбаярын намтар	122
1. Д.Чулуунбаярын намтар	124
2. Яруу найрагч Д.Чулуунбаяр их амьтат дурсгал	147
Урлагчид хэсэг, Д.Чулуунбаярын намтар	147
1. Яруу найрагч Д.Чулуунбаярын яруу найргийн тусгай	150
2. Д.Чулуунбаярын яруу найргийн тусгай	161



**“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд**

**ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ**

***Ерөнхий шаардлага:***

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

***Техник шаардлага:***

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-15

***Судалгааны ажлын бүтэц:***

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (abstract)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

***Өгүүлэл хэвлэгдэх явц:***

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

8-15 – גיליון 15 – 2000

10) המערכת

המערכת לשימוש ב-APA

12) המערכת

B5

המערכת

המערכת

המערכת

המערכת

המערכת:

המערכת

המערכת

המערכת

המערכת

המערכת:

המערכת

-> **לשון המהירות** ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (למשל: **לשון המהירות**) ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים ..

**לשון המהירות** :

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (למשל: **לשון המהירות**) ..

-> **לשון המהירות**

-> **לשון המהירות**

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (key word)

-> **לשון המהירות**

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (abstract)

-> **לשון המהירות**

-> **לשון המהירות**

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (למשל: **לשון המהירות**) ..

-> **לשון המהירות** היא מילה המיוערת לשימוש במסמכים המיוערים לשימוש במסמכים (content)

-> **לשון המהירות**

**לשון המהירות** :